



**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ  
УХААНЫ ЯАМНЫ 2010 ОНЫ  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

Улаанбаатар хот  
2010 он

## ГАРЧИГ

ОРШИЛ .....

1. Тайлан гаргах хууль, эрх зүйн үндэслэл .....
2. Тайлангийн зорилго .....
3. Тайлангийн хамрах хугацаа .....
4. Тайланг өргөн барих хугацаа .....
5. Тайлан гаргахад баримтлах зарчим .....

I. ЧИГ ҮҮРЭГ .....

II. ЭРХЭМ ЗОРИЛГО .....

III. 2009 ОНЫ ҮНДСЭН ЗОРИЛТУУД .....

IV. БОДЛОГЫН ЗОРИЛТЫГ ТОДОРХОЙЛОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА,  
ТҮҮНИЙ ҮР ДҮН.....

Нэг. Сургуулийн өмнөх боловсролын талаар.....

Хоёр. Бага, дунд боловсролын талаар.....

Гурав. Дээд болон мэргэжлийн боловсролын талаар .....

Дөрөв. Соёл, урлагийн талаар .....

Тав.Шинжлэх ухаан, технологийн талаар .....

Зургаа. Санхүү, хөрөнгө оруулалт.....

Долоо. Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээ: .....

Найм. Гадаад хамтын ажиллагааны талаар.....

Ес. Төрийн захиргааны удирдлага.....

Арав. Дүгнэлт, зорилт .....

ХАВСРАЛТУУД.....

- БСШУЯ-аас Засгийн газрын хуралдаанаар 2009 онд хэлэлцүүлсэн асуудлын жагсаалт .....
- Засгийн газрын тогтоолоор 2009 онд батлагдсан салбарын хэмжээнд мөрдөгдөх баримт бичгийн жагсаалт.....
- Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийн дүн.....
- Эдийн засаг, нийгмийг 2009 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийн дүн.....
- БСШУЯ-ны 2008 оны үр дүнгийн гэрээний биелэлт .....
- Яамны үйл ажиллагааг үнлэх эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн биелэлт .. ..
- Яамны үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээ.....

## ОРШИЛ

### 1. Тайлан гаргах хууль, эрх зүйн үндэслэл

Засгийн газрын 2010 оны 11 дүгээр тогтоолоор батлагдсан "Яам болон аймаг, нийслэлийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх, үр дүнг үнэлэх журам"-ын дагуу Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны 2010 оны үйл ажиллагааны тайланг гаргав.

### 2. Тайлангийн зорилго

- (1) Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамнаас 2010 онд гүйцэтгэсэн ажлууд, тэдгээрийн үр дүнг Засгийн газарт тайлагнахад энэхүү тайлангийн зорилго оршино.
- (2) Тайлан гаргахдаа яамны үйл ажиллагааг нэг талаас бодит гүйцэтгэл буюу үр дүнтэй нь харьцуулан дүгнэх, нөгөө талаас боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарын өөрчлөлт, шинэчлэл, хөгжлийн чиг хандлагад хэрхэн нөлөөлж буйг сүүлийн 3 жилийн үзүүлэлтүүдийн өсөлт, бууралтаар харьцуулан судлах зарчимд тулгуурласан болно.
- (3) Тайлан нь яамны үйл ажиллагааг цаашид төлөвлөх, хэрэгжүүлэх, гүйцэтгэлийг дүгнэх, үйл ажиллагааны үр дүн, өгөөжийг дээшлүүлэхэд чиглэсэн санал, зөвлөмжийг агуулсан болно.

### 3. Тайлангийн хамрах хугацаа

Жилийн үйл ажиллагааны тайлан нь /цаашид "Тайлан" гэнэ/ 2010 оны 1 дүгээр сарын 1-ээс эхлэн мөн оны 12 дугаар сарын 31-ийг дуустал хугацааг хамарсан.

### 4. Тайланг өргөн барих хугацаа

Тайланг 2010 оны 4 дүгээр сарын 1-ний дотор багтаан Засгийн газарт өргөн барина.

### 5. Тайлан гаргахад баримтлах зарчим

- (a) Тайлан нь яамны үйл ажиллагааны бодит байдалтай нийцсэн байна.
- (b) Хариуцлагын болон ил тод байх тогтолцоонд нийцсэн байна.
- (c) Тайлан нь чанартай, хэрэглэгчдийн хэрэгцээг хангасан байна.

## I. ЧИГ ҮҮРЭГ

- Сургуулийн өмнөх боловсролыг хөгжүүлэх бодлогын удирдамжаар хангахад зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх;
- Ерөнхий боловсролыг хөгжүүлэх бодлогын удирдамжаар хангахад зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх;
- Ерөнхий боловсролыг хөгжүүлэх мастер төлөвлөгөө, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн зохицуулалтыг сайжруулах;
- Ерөнхий боловсролын талаархи төрийн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх;
- Албан бус боловсролыг хөгжүүлэх, түүний бүх хэлбэрийг дэмжих бодлогын удирдамжаар хангахад зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх.

- Мэргэжлийн болон дээд боловсролыг хөгжүүлэх бодлогын удирдамжаар хангахад зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх;
- Мэргэжлийн болон дээд боловсролыг хөгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээний боловсруулалт, хэрэгжилтийн зохицуулалтыг сайжруулах;
- Мэргэжлийн болон дээд боловсролын талаархи төрийн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх.
- Соёл, урлагийг хөгжүүлэх бодлогын удирдамжаар хангахад зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх;
- Соёл, урлагийг хөгжүүлэх хөтөлбөр, төсөл боловсруулах, хэрэгжүүлэх ажлын зохицуулалтыг сайжруулах;
- Соёл, урлагийн талаархи төрийн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх.
- Шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх бодлогын удирдамжаар хангахад зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх;
- Шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх мастер төлөвлөгөө, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын зохицуулалтыг сайжруулах;
- Шинжлэх ухаан, технологийн талаархи төрийн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх;
- Үндэсний инновацийн тогтолцоо бий болгох, хөгжүүлэхэд зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх.
- Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсөв, хөрөнгө оруулалтын бодлогыг төлөвлөх, зориулалтын дагуу зарцуулах, тайлагнах;
- Ажил үйлчилгээ, бараа бүтээгдэхүүнийг хууль тогтоомжийн дагуу худалдан авах үйл ажиллагаанд бүх талын дэмжлэг үзүүлэх, үр нөлөөг дээшлүүлэх;
- Салбарын хүрээнд хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөр, арга хэмжээний санхүүгийн зохицуулалт, уялдаа холбоог сайжруулах.
- Салбарын статистик мэдээллийн шалгуур үзүүлэлт, бодит байдал, боловсруулалтыг сайжруулж, статистик мэдээлэл гаргах, удирдлагыг мэдээллээр хангах;
- Салбарын бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төслийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх;
- Удирдлагын мэдээллийн нэгдсэн сан, сүлжээ бүрдүүлж, мэдээллээр үйлчлэх тогтолцоог боловсронгуй болгох.
- Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын чадавхийг дээшлүүлэхэд дэмжлэг, үйлчилгээ үзүүлэх;
- Яамны ажилтнууд өндөр бүтээмжтэй ажиллах нөхцөлийг хангаж, байгууллагын соёлыг төлөвшүүлэхэд дэмжлэг үзүүлэх;
- Гадаад хамтын ажиллагааны олон талт болон хоёр талт гэрээ, хэлэлцээр, төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх;
- Гадаад хамтын ажиллагааны чиглэлээр гэрээ, хэлэлцээр байгуулах, хурал, уулзалт зохион байгуулахад зөвлөгөө дэмжлэг үзүүлэх.

## **II. ЭРХЭМ ЗОРИЛГО**

### **ЭРХЭМ ЗОРИЛГО**

Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны эрхэм зорилго нь иргэн бүрийг бие даан сурах, ажиллах, чадвартай болгон төлөвшүүлэх, эрдэм шинжилгээний ажлын үр өгөөжийг нэмэгдүүлэх, соёл, урлагийн үйлчилгээний хүртээмж, чанарыг дээшлүүлэх таатай орчинг бий болгох, тогтолцоог боловсронгуй болгон хөгжүүлэх явдал мөн.

### III. 2010 ОНЫ ҮНДСЭН ЗОРИЛТУУД

#### БОЛОВСРОЛ:

- Боловсролын эрх зүйн шинэчлэлийг гүнзгийрүүлэх
- “Боловсрол” хөтөлбөрийг шинээр боловсруулах, хэрэгжилтийн хангах
- Баг бүрт гэр цэцэрлэг байгуулах ажлыг үргэлжлүүлж, сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтыг нэмэгдүүлэх
- 12 жилийн сургалтын тогтолцоонд шилжих шилжилтийг үргэлжлүүлэх
- Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын сурах бичгийг төрөөс хангах ажлыг эхлүүлэх
- Хүүхдэд ээлтэй сургуулийн орчинг бүрдүүлж, сургуулийн үйл ажиллагаанд суралцагч, эцэг, эхийн оролцоог нэмэгдүүлэх
- Мэргэжлийн болон техникийн боловсролыг нийгмийн эрэлт, хөдөлмөрийн захтай холбож, мэргэжлийн боловсролд хувийн хэвшлийн оролцоог өргөжүүлэх, нийгмийн бүтээлч түншлэлийг хөгжүүлэх
- Мэргэжлийн боловсрол, сургалтын хөтөлбөрийг нийгмийн эрэлт, шаардлага, шинэ технологитой уялдуулж боловсронгуй болгох, МСҮТ-ийн хүчин чадал, суралцагчдын тоог нэмэгдүүлэх, багш, мастер багш нарыг чадваржуулах
- Монгол Улсын дээд боловсролыг шинэчлэх бодлогын чиглэлийг тодорхойлох
- Дээд боловсролын хамрах хүрээг зохистой болгож, сургалтын чанарыг олон улсын нийтлэг жишигт ойртуулах
- Оюутан, суралцагчдын сурах нөхцөлийг сайжруулан, сурлагын амжилт, чармайлтыг урамшуулан дэмжих, мэргэжлээрээ хөдөлмөр эрхлэх чадамжийг сайжруулах
- Албан бус боловсролын тогтолцоог, нийт иргэд мэдлэг чадвараа ахиулахад нийцтэй, хүртээмжтэй болгох

#### ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИ:

- Шинжлэх ухаан, технологийн эрх зүйн шинэчлэлийг гүнзгийрүүлэх
- Шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх мастер төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах
- Шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэл, цөм технологийг тодорхойлох
- Монгол Улсад үндэсний инновацийн тогтолцоог хөгжүүлэх хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж, улс эх орны хөгжилд инновацийн гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэх
- Шинжлэх ухаан, технологийн хөгжлийн чиг хандлагыг үйлдвэржүүлэлттэй уялдуулан хөгжүүлэх, шинжлэх ухааны үйл ажиллагаанд хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх
- Шинжилгээ, туршилтын бааз, лабораторийг шинэчлэх, шинэ тоног төхөөрөмжөөр хангах
- Төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр дүнд бий болсон шинэ бүтээл, оюуны өмчийг хамгаалах, ашиглах тогтолцоог хөгжүүлэх
- Зах зээлийн эрэлт, хэрэгцээ шаардлагыг хангахуйц судалгаа боловсруулалтын өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, эрдэм шинжилгээний ажилтан, залуу эрдэмтдийг бодлогоор дэмжих

## СОЁЛ, УРЛАГ:

- Соёл, урлагийн салбарын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох
- Соёл, урлагийн хорооы үйл ажиллагааг төлөвшүүлэх
- Монгол Улсын соёл, урлагийг хөгжүүлэх Мастер төлөвлөгөөг боловсруулах
- Соёл, урлагийн байгууллагуудын үйл ажиллагааны хүрээ, хүртээмжийг нэмэгдүүлэх
- Соёл, урлагийн боловсон хүчний хангамж, чадавхийг дээшлүүлэх, нийгмийн асуудлыг шийдвэрлэх
- Соёл, урлагийн менежментийг зах зээлд нийцүүлэх
- Соёлын өв, музейн үзмэрийг хамгаалах, баяжуулах, музей болон цэцэрлэг, бүх шатны сургуулийн үйл ажиллагааны түншлэлийг хөгжүүлэх
- Соёл, урлагийн байгууллагыг хөгжмийн зэмсэг, ном, тоног төхөөрөмжөөр хангах
- Монгол Улсын гадаад сурталчилгааг хөгжүүлэх
- Соёл, урлагийн гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх

#### IV. БОДЛОГЫН ЗОРИЛТЫГ ТОДОРХОЙЛОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА, ТҮҮНИЙ ҮР ДҮН

"Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль"-ийн дагуу Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Ерөнхий менежер, Төсвийн ерөнхийлөн захирагчтай бүтээгдэхүүн нийлүүлэх 2010 оны үр дүнгийн гэрээ байгуулан ажиллаж, 8 анги 30 бүтээгдэхүүн /370 арга хэмжээ/-ийг Төсвийн ерөнхийлөн захирагчид нийлүүллээ.

"Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр", "Эдийн засаг, нийгмийг 2010 онд хөгжүүлэх үндсэн чиглэл", салбарын мастер төлөвлөгөө, үндэсний хөтөлбөрүүдэд боловсрол, соёл, шинжлэх ухааны талаар тусгагдсан зорилтуудыг хэрэгжүүлэх, боловсрол, шинжлэх ухааны шинэчлэлийн бодлогыг тодорхойлох, соёл, урлагийн гадаад сурталчилгааг нэмэгдүүлэх, иргэдэд үзүүлэх үйлчилгээний хүртээмж, чанарыг дээшлүүлэх, гадаад орон, олон улсын байгууллагатай хамтын ажиллагааг хөгжүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлж ажиллалаа.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний болон Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2010 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийн тайланг Засгийн газарт тусгайд нь тайлагнадаг учир энд зөвхөн гүйцэтгэлийн дүнг хүснэгтээр нэгтгэн үзүүлэв (хүснэгт № 1, 2).

##### Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний биелэлт

								Хүснэгт №1
	Биелэлт /%/							Дүн
Биелэлтийн хувь	0	10	30	50	70	90	100	52.8
Арга хэмжээний тоо	7	7	19	47	28	5	12	125

Энэхүү хүснэгтээс үзвэл Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг баталснаас хойших 2 жилийн хугацаанд тус яам хэрэгжүүлбэл зохих, зорилт, арга хэмжээнийхээ 53 орчим хувийг биелүүлээд байгаа нь үлдсэн хугацаанд тэдгээрийг бүрэн биелүүлэх боломжтой болж байна.

##### Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2010 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт

								Хүснэгт №2
	Биелэлт /%/							Дүн
Биелэлтийн хувь	0	10	30	50	70	90	100	90.33%
Арга хэмжээний тоо	2	-	2	-	4	12	40	60

Үр дүнгийн гэрээг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, түүний хавсралтуудыг боловсруулан батлуулж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулсан болно.

Гэрээ, төлөвлөгөөг хэрэгжүүлэх талаар нэгж, мэргэжилтэнд байнгын зөвлөгөө өгч, дэмжлэг туслалцаа үзүүлэн гүйцэтгэл, чанар, хугацааны хяналт тавьж, явц, дүнг нэгжийн дарга нарын зөвлөлийн түвшинд болон хамт олны хурлаар хэлэлцэж, хугацаатай үүрэг, даалгавар өгч эрчимжүүлэх, зарим томоохон бүтээгдэхүүний нийлүүлэлтэд явцын хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх зэргээр удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллав.

Байгууллагыг хөгжүүлэх гол хүчин зүйл нь төрийн албан хаагчдын мэдлэг, чадвар, мэргэшлийн түвшин, нөгөө талаас ажлын байрны нөхцөл, албан хэргийг явуулах боломж байдаг. Иймээс тайлангийн хугацаанд УИХ, Засгийн газар болон бусад яам, агентлаг, төрийн бус байгууллага, Олон улсын байгууллагаас Улаанбаатар хотод зохион байгуулсан сургалт-семинар, хурал, зөвлөгөөнд яамны аппаратын 20 /давхардсан тоогоор/ гаруй ажилтныг, гадаадын богино хугацааны сургалт-семинарт 38 ажилтныг хамруулсны зэрэгцээ АНУ, Австралид 2 ажилтныг магистрантурын сургалтад сургаж байна. Мөн дотоодын их, дээд сургуульд 4 ажилтныг шинэ мэргэжил эзэмшүүлэх сургалтад үзүүлэв.

Энэ бүхэн нь аппаратад ажиллагчдын онол, арга зүйн мэдлэгийг дээшлүүлэх, тэдэнд шинэ мэдлэг, мэдээлэл өгөх, эцсийн дүндээ ажлын үр дүнг ахиулахад ач холбогдолтой болсон гэж үзэж байна.

Яамны албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтын дагуу эрхэлсэн ажлаа мэргэжлийн түвшинд чанартай гүйцэтгэх боломжийг бий болгох, ажил хэргийн мэдлэг, чадварыг ахиулах зорилгоор яамны албан хаагчдын сургалтын хөтөлбөр, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр, төлөвлөгөөнүүдийг шинэчлэн боловсруулж батлан хэрэгжүүлж эхлэв.

Байгууллагын үйл ажиллагааны хүрээнд тавих хяналтыг үр дүнгийн гэрээний биелэлтийг хангахад чиглүүллээ. Өөрөөр хэлбэл, яамны үйл ажиллагаанд тавих хяналтыг төсвийн ерөнхийлөн захирагчийн, ерөнхий менежерийн, нэгжийн менежерийн гэсэн 3 түвшинд хэрэгжүүлж, ажлын гүйцэтгэлийг эрчимжүүлж ажиллав. Үүнд:

- Төсвийн ерөнхийлөн захирагчид нийлүүлэх бүтээгдэхүүний хугацааны хяналтын график гарган, биелэлтийг нэгжийн дарга нарын зөвлөлийн хурлаар удаа дараа хэлэлцүүлж, газар, хэлтэс, мэргэжилтэнд хугацаа хоцорсон бүтээгдэхүүн бүрээр 3 удаагийн албан захидал, тушаалаар даалгавар өгч гүйцэтгэлийг эрчимжүүлэв.
- Төлөвлөгөөт ажлын явц, биелэлтийн талаарх мэдээллийг нэгжийн дарга нарын зөвлөлийн хурлаар долоо хоног тутам сонсож, бүтээгдэхүүн нийлүүлэлтийн чанар, үр дүнг дээшлүүлэх, хариуцлагыг өндөржүүлэх талаар зөвлөмж гарган, үүрэг даалгавар өгч, биелэлтийг дүгнэж ажиллав.
- Үр дүнгийн гэрээ, төлөвлөгөөний явц, биелэлтийг улирал бүрээр яамны цахим хуудас, тусгай самбарт ил тод тавьж ажилласан нь ажлын үр дүнг нийтийн хяналтад байлгах, хариуцсан ажлаа бусадтай харьцуулах болон өөрөө хянах, дүгнэлт хийж ажиллахад ач холбогдолтой болов.

Бүтээгдэхүүн нийлүүлэх үр дүнгийн гэрээний биелэлт 91.98 хувийн хэрэгжилттэй байна. Гэрээний хэрэгжилтийг мэргэжилтэн, газар, хэлтсийн гаргасан тайлан, тэдгээрт нэгжүүдийн хурлаар хэлэлцсэн тэмдэглэл, төрийн захиргааны удирдлагын газраас болон төрийн нарийн бичгийн даргын зүгээс хянаж тооцсон дүн, энэ талаар өгсөн үүрэг, даалгаврын хэрэгжилт, явцын хяналт-шинжилгээ, үнэлгээнд тулгуурлан гаргасан болно.

Тус яамны 2010 оны үйл ажиллагааны гол үр дүнг салбараар тус тус бүрээр нь дараахь байдлаар товч томъёолж байна.

## Нэг. Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын талаар

### *“Боловсрол” үндэсний хөтөлбөрийг боловсруулж, батлуулав.*

Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор “Боловсрол” үндэсний хөтөлбөрийг боловсруулж, Засгийн газрын 2010 оны 31 дүгээр тогтоолоор батлууллаа. Энэхүү хөтөлбөрт боловсролын салбарын өнөөгийн байдал, шийдвэрлэвэл зохих тулгамдсан асуудлыг тодорхойлсны үндсэн дээр боловсролын салбарыг 2021 он хүртэл хөгжүүлэхэд баримтлах бодлого, агуулгын ерөнхий зарчмууд, хэрэгжүүлэх арга зам, хүрэх үр дүн, учирч болох эрсдлүүд зэргийг тодорхойлсон болно.

Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого /2007-2021/, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр /2008-2012/, эдийн засаг, нийгмийн хөгжлийн өөрчлөлт, боловсролын салбарын шинэчлэл, түүний хэрэгцээ шаардлагад нийцүүлэн “Монголын боловсролыг 2006-2015 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөө”-нд нэмэлт, өөрчлөлт оруулж, мастер төлөвлөгөөний шинэчилсэн хувилбарыг боловсролын хандивлагчдын зөвлөлдөх уулзалтаар 2010 оны 3, 5 дугаар сард тус тус хэлэлцүүлэн эцэслэн боловсруулаад байна. Шинэчилсэн мастер төлөвлөгөөнд дараах бодлогын чанартай, ойрын ирээдүйд зайлшгүй шийдвэрлэх шаардлагатай томоохон асуудлуудыг тусгасан. Үүнд:

- ✓ Ерөнхий боловсролын 12 жилийн тогтолцоонд нийцүүлэн боловсролын стандарт, хөтөлбөрийг шинэчлэн сайжруулж, хэрэгжилтийг хангах;
- ✓ 2008 онд баталсан Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн хэрэгжилтийг хангах;
- ✓ 2009 онд баталсан Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн хэрэгжилтийг хангах;
- ✓ Дээд боловсролын салбарт бүтцийн өөрчлөлт хийх замаар тухайн дэд салбарт чанарын дэвшил гаргах;
- ✓ Насанд хүрэгчдийн тасралтгүй боловсролын үйлчилгээг нэвтрүүлэх замаар албан бус сургалтын тогтолцоог өргөжүүлэх зэрэг асуудлыг багтаав.

### *Гэр цэцэрлэгийн тоо өсч байна.*

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан баг бүрийг цэцэрлэгээр хангах зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор Нэгдсэн үндэсний байгууллагын Хүүхдийн сангийн санхүүжилтээр 5 аймгийн 19 сум, нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 116



дугаар цэцэрлэгт тус бүр нэг гэр, тавилга, тоног төхөөрөмж, тоглоом наадгай, түүнчлэн зудад нэрвэгдсэн 19 суманд гэр, тавилга тоног төхөөрөмж, тоглоом наадгай нийлүүлэв. Мөн “Бүх нийтийн боловсролын үр дүнд түргэн хүрэх санаачилгын төсөл”-ийн шугамаар 459.1

мянган ам.долларын өртөг бүхий 100 гэрийг холбогдох ширээ сандал, тоглоом, заах аргын материалын хамт төвөөс алслагдсан сумдад нийлүүлэв. Ингэснээр сүүлийн

жилүүдэд 539 гэр цэцэрлэг байгуулж, багийн 35 орчим хувийг гэр цэцэрлэгээр хангаад байна. Цэцэрлэгийн барилга, түүний ашиглалтын талаар нэгдсэн зураглал гаргах судалгааг аймаг, нийслэлийн нийт цэцэрлэгүүдээс авч нэгтгэн мэдээллийн бааз үүсгээд байна. Түүнчлэн 50, 75, 100, 150, 280 хүүхдийн хүчин чадалтай цэцэрлэгийн загвар зураг боловсруулах ажлыг Барилга захиалагчийн алба болон холбогдох байгууллагуудаар хийлгэлээ. Цэцэрлэгийн загвар зураг гарснаар улсын хэмжээнд ижил стандартын шинэ барилга, өргөтгөл барих зураг төсвийн үнийг хэмнэх ач холбогдолтой юм.

### ***Цэцэрлэгийн хүүхдийн хоолны үлгэрчилсэн цэсийг боловсруулж баталгаажуулав.***

Бага насны хүүхдийг чанартай, хоногийн хэрэгцээнд нь нийцсэн, баталгаатай хоол хүнсээр хангах зорилгоор “Цэцэрлэгийн хүүхдийн хоолны үлгэрчилсэн цэс”-ийг Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэнгийн Хоол судлалын үндэсний төвд захиалан хийлгэж, НҮБ-ын Хүүхдийн сангийн санхүүжилтээр 1000 хувь хэвлүүлэн аймаг, нийслэлийн нийт цэцэрлэгт түгээн, туршиж Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2010 оны 458 дугаар тушаалаар баталгаажууллаа. Ийнхүү цэцэрлэгийн хүүхдийг хоногийн хоолны норм, шимт бодис, илчлэгийн хэрэгцээнд нийцсэн хоол хүнсээр хангах, тогооч нар технологийн дагуу эрүүл, чанартай хоол бэлтгэн цэцэрлэгийн хүүхдийг хангах боломж бүрдлээ.

### ***“Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын сургалт эрхлэхэд тавигдах шаардлага”-ыг боловсруулж, батлав.***

Боловсролын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4 дэх хэсгийн хэрэгжилтийг хангах зорилгоор “Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичигт тавигдах шаардлага”-ын төслийг боловсруулж, БСШУ-ы сайдын 2010 оны 353 дугаар тушаалаар баталгаажуулж, Хууль зүй, дотоод хэргийн яамаар хянуулан улсын бүртгэлд 2010 оны 8 дугаар сарын 27-ны өдрийн 3184 дүгээрт бүртгүүлээ.

### ***Ерөнхий боловсролын сургуульд Кембрижийн стандартыг нэвтрүүлэх ажлыг эхлүүлэв.***

Олон улсад нийтлэг хүлээн зөвшөөрөгдсөн Кембрижийн ерөнхий боловсролын хөтөлбөрөөр хичээллэх төрийн өмчийн анхны лаборатори сургуулийг байгуулж, үйл ажиллагааг нь 2010 оны 9 дүгээр сараас эхлүүлээд байна. Үүний бэлтгэлийг хангах



хүрээнд олон арга хэмжээг хэрэгжүүллээ. Тухайлбал, Кембрижийн ерөнхий боловсролын хөтөлбөрөөр хичээллэх сургуульд ажиллах багш нарын сонгон шалгаруулалт явуулж, 16 багш, удирдах ажилтны англи хэлний ярианы болон бичгийн түвшинг дээшлүүлэх эрчимжүүлсэн 100 цагийн сургалтыг Боловсролын их сургуультай хамтран 2010 оны 3-5 дугаар сард зохион байгуулсны зэрэгцээ 4 багшийг Бүгд Найрамдах Энэтхэг Улсад англи хэлний гүнзгийрүүлсэн сургалтад,

АНУ-ын Англи хэлний институтийн Монгол дахь салбараас зохион байгуулсан “Excel” хөтөлбөрт 12 багшийг 2010 оны 7 дугаар сарын 5-наас нэг сарын хугацаатай үргэлжлүүлэн сургаж бэлтгэлээ. Мөн Кембрижийн олон улсын шалгалтын төвийн зөвлөх үйлчилгээний багийг Монгол Улсад 2010 оны 4 дүгээр сарын 18-23-ны өдрүүдэд ажиллуулж, хөтөлбөрийг нэвтрүүлэх боломжийн талаар судлан Кембрижийн Их сургуулиас “Кембрижийн ерөнхий боловсролын хөтөлбөрийг Монголын ерөнхий боловсролын сургуульд нэвтрүүлэх чиглэл” /Roadmap/-ийг ирүүлсэн болно.

### **“Хүүхэд, залуучуудын хөгжил, төлөвшил” Үндэсний хөтөлбөр боловсруулав.**

Хүүхдийг аливаа эрсдлээс хамгаалах, хариуцлагад сургах, хүүхдийн идэвхтэй оролцоог гэр бүлийн түвшинд хангах, тэдний хүмүүжил, төлөвшлийн асуудлыг бодлогын хэмжээнд авч үзэх зорилгоор “Хүүхэд, залуучуудын хөгжил, төлөвшил” Үндэсний хөтөлбөрийн төслийг эцэслэн боловсруулаад байна. Энэхүү хөтөлбөр нь үндэсний уламжлалт сэтгэлгээ, зан заншил, үнэт зүйлс, соёлын үнэлэмжийг дээшлүүлэх, үндэсний болон даяаршлын соёлын үнэ цэнэтэй өвийг зохистой хослуулан хэрэглэх, хамгаалах механизмыг буй болгох замаар хүүхдийн зан суртахуун, төлөвшлийг зүй зохистой чиглүүлж, Монгол Улсын үндэсний дархлааг бэхжүүлэхэд чиглэгдэж байгаа юм. Үндэсний хөтөлбөрийн хүрээнд дараахь 4 зорилтыг дэвшүүлсэн болно:

- ❖ Хүүхдийн хөгжил төлөвшлийг хангахад гэр бүл, эцэг эх, асран хамгаалагчийн үүрэг хариуцлагыг өндөржүүлэх, тэдний мэдлэг, чадварыг дээшлүүлэх, хариуцлагын тогтолцоо бүрдүүлэх;
- ❖ Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн орчин, сургалт, хүмүүжлийн бүхий л үйл ажиллагааг хүүхдийн хөгжил төлөвшлийг хангахад чиглүүлэх;
- ❖ Хүүхдийн хөгжил төлөвшлийг хангахад төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааг хангах;
- ❖ Хүүхдийн хөгжил, төлөвшлийг хангах эрх зүйн орчин бүрдүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих механизм бүрдүүлэх.

Эдгээр зорилт бүрийн хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэлийг тодорхойлон хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд салбар дундын болон гэр бүл, хэвлэл мэдээллийн байгууллагын оролцоо, хариуцлагыг дээшлүүлэх, Хүүхдийн эрхийн тухай болон Гэр бүлийн тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулах, хүүхдийн асуудлаар Засгийн газрын байгууллагын чиг үүрэг, статусыг тодорхой болгох асуудлыг дээрх хөтөлбөрийн төсөлд тодорхойлов.

### **Ерөнхий боловсролын сургуулийн үлгэрчилсэн дүрмийг боловсруулж батлав.**

Боловсролын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5 дахь заалтын хэрэгжилтийг хангах зорилгоор “Ерөнхий боловсролын сургуулийн үлгэрчилсэн дүрэм”-ийг боловсруулан БСШУ-ы сайдын 2010 оны 471 дүгээр тушаалаар баталж, улсын бүртгэлд 2010 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 3197 дугаарт бүртгүүлэв. Өнөөг хүртэл “Ерөнхий боловсролын сургуулийн дүрэм”-ийг баталсан хэм хэмжээ байхгүй байсан бөгөөд боловсролын салбарын эрх зүйн шинэчлэлийг хөгжүүлэх, улмаар сургуулийн дүрмийг нийтлэг байдлаар тодорхойлох хэрэгцээ, шаардлага гарсан юм. Дүрэм нь үндсэн 8 хэсгээс бүрдэж байгаа бөгөөд дүрмээр (i) сургууль хүүхдийн эрхийг дээдэлсэн, ардчилал, шударга ёс, ил тод байдал, хамтын удирдлагын зарчимд тулгуурлан үйл

ажиллагаагаа зохион байгуулах; (ii) сургууль хөгжүүлэх хөтөлбөр, төлөвлөгөөтэй ажиллах; (iii) шийдвэр гаргахад сургуулийн өөрийн болон мэргэжлийн удирдлагын байгууллагын төлөөллийн оролцоог хангах; (iv) сургуулийн үйл ажиллагаанд багш, суралцагч, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх замаар түншлэлийг бэхжүүлэх /үйл ажиллагаа төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ хийх/; (v) боловсролын үйлчилгээг стандартын шаардлага хангасан эрүүл, аюулгүй хамгаалагдсан орчинд зохион байгуулах, сургууль, сургалтын үйл ажиллагаанд эрүүл ахуй, аюулгүй байдлыг бүрэн хангаж ажиллах; (vi) сургуулийн удирдлагын мэдээллийн системийг бүрдүүлж, мэдээллийн нууцлалыг ханган ажиллах ба сургуулийн үйл ажиллагаа, төсвийн зарцуулалтын ил тод, нээлттэй байдлыг хангаж багш, ажилтан, суралцагчдад мэдээлэх; (vii) хичээл хоорондын завсарлагааны үргэлжлэх хугацаа, суралцагчдад өгөх нэг өдрийн гэрийн даалгаврын хэмжээг тогтоосон; (viii) сургууль, сургалтын үйл ажиллагаанд хориглох зэрэг асуудлыг зохицуулсан болно. Ингэснээр сургуулийн сайн засаглалыг бэхжүүлэх, ерөнхий боловсролын сургуулиудын дүрэмд тусгах асуудлын хамрах хүрээ улсын хэмжээнд нэгэн адил хэм хэмжээний зохицуулалттай болох, өөрийн сургуулийн дүрэм боловсруулахад нэгдсэн арга зүйн удирдлагаар хангагдах, сургуулийн үйл ажиллагаанд багш, суралцагч, эцэг, эхийн оролцоог нэмэгдүүлэх, түншлэлийг хөгжүүлэх, үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангахад бодитой тус нэмэр болно гэж үзэж байна.

### **Сурагчийн мэдлэг, чадвар, төлөвшлийг үнэлэх, дүгнэх асуудлыг журамлав.**

“Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн мэдлэг, чадвар, төлөвшлийг үнэлэх, дүгнэх журам”-ыг боловсруулан Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2010 оны 361 дүгээр тушаалаар батлан, улсын бүртгэлд бүртгүүлэн 2010-2011 оны хичээлийн жилээс эхлэн мөрдөж байна.

### **Сурах бичгийн хангамжийг нэмэгдүүлэхэд ахиц гарлаа.**

Ерөнхий боловсролын 12 жилийн сургалттай сургуулийн сурагчдыг 2014 он гэхэд хичээл тус бүрт үндсэн нэг сурах бичигтэй болгох зорилго бүхий 2009-2014 онд ЕБС-ийн сурагчдыг сурах бичгээр хангах дунд хугацааны төлөвлөгөөний төслийг боловсруулав. “Сурах бичгийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Боловсрол, соёл шинжлэх ухааны сайдын 2010 оны 135 дугаар тушаалаар 2010 онд шинээр зохиох, хэвлэх сурах бичгийн жагсаалт, шаардагдах санхүүжилтийг баталлаа. Энэ онд 12 жилийн сургалттай III, VIII ангийн 23 нэрийн сурах бичиг, биеийн тамирын багшийн ном, нийт 25 нэрийн сурах бичгийг шинээр, 12 жилийн сургалттай I ангийн 6, II ангийн 5 сурах бичгийн тус тус дахин хэвлэж нөхөн хангалт хийхээр төлөвлөсөн. БСШУ-ы дээрх тушаалын дагуу шинээр сурах бичиг зохиох зохиогчдын багийг сонгон шалгаруулж, БСШУ-ы сайдын 2010 оны дүгээр сарын 29-ний өдрийн 203 дугаар тушаалаар “12 жилийн сургалттай III, VIII ангийн сурах бичиг зохиох багийн бүрэлдэхүүн”-ийг баталснаар сурах бичиг зохиох ажлыг эхлүүлсэн. Харин сурах бичгийн хэвлэлийн эх бэлтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг 2010 оны 5 дугаар сарын 19-нд зарлан шаардлага хангасан хэвлэлийн 10 компанитай эх бэлтгэлийн гэрээ байгууллаа.



12 жилийн сургалттай I ангийн сурах бичгийг “Адмон”, “Соёмбо принтинг”, “Содпресс” хэвлэлийн компанитай шууд гэрээ байгуулах болон нөхөн хангалт хийх II ангийн сурах бичиг, шинээр зохиосон 12 жилийн сургалттай III, VIII ангийн сурах бичгийг худалдан авах тендер шалгаруулах арга хэмжээг зохион байгуулав. Энэхүү тендер шалгаруулалтад нийт 20 хэвлэлийн компани оролцсон бөгөөд 2 дугаар ангийн сурах бичгийг Би Си Ай, Мөнхийн үсэг, Интерпресс ХХК-тай гэрээ байгуулж, Сангийн яам, Азийн хөгжлийн банкнаас ирүүлсэн гэрээ байгуулах эрх олгох зөвшөөрлийн дагуу 3, 8 дугаар ангийн 24 нэрийн сурах бичгийг нэр бүхий 7 компани хэвлэхээр гэрээ байгуулах ажил хийгдэж байна. Энэ онд ерөнхий боловсролын сургуульд нийт 674,1 мянган ширхэг сурах бичгийн нийлүүлээ.

### ***Казах хүүхдийн боловсролын үйлчилгээний чанарыг сайжруулах ажлыг эхлэв.***

Казах хүүхдийн боловсролын үйлчилгээний чанарыг сайжруулах, хэлний ялгаатай байдлыг арилгах, хүүхдийн сурч боловсрох эрхийг хангах асуудлыг боловсруулж, Засгийн газрын 2010.03.17-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж, “Казах хүүхдийн боловсролын үйлчилгээний чанарыг сайжруулах талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2010 оны 66 дугаар тогтоолоор батлав. Уг тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор “Казах хүүхдийн боловсролыг дэмжих хөтөлбөр”-т өөрчлөлт оруулсны зэрэгцээ Баян-Өлгий аймгийн боловсролын үйлчилгээний чанарыг сайжруулах үйл ажиллагааны төлөвлөгөө”-г БСШУ-ы сайдын 2010 оны 106 дугаар тушаалаар батлан хэрэгжүүлж байна.

### ***Албан бус боловсролын бодлогыг тодорхойлов.***

Албан бус боловсролын сургалтын талаар баримтлах бодлого, “Амьдрах ухаанд суурилсан бичиг үсгийн сургалтын хөтөлбөр”, “Гэгээрэл” төвийн үлгэрчилсэн дүрмийг боловсруулж БСШУ-ы сайдын 2010 оны 556 дугаар тушаалаар батлав. Үүнтэй холбогдуулан албан бус боловсролын ажлын байрны тодорхойлолт, албан бус боловсролын захирлын болон багшийн ажлын байрны үлгэрчилсэн тодорхойлолт зэрэгт зохих өөрчлөлт оруулсны зэрэгцээ “Албан бус боловсролын багшийн ажлыг төлөвлөх, үнэлэх, дүгнэхэд баримтлах чиглэл”-ийг боловсруулан БСШУ-ы сайдын 2010 оны 600 дугаар тушаалаар батлав. Бодлогын энэхүү арга хэмжээг авснаар албан бус боловсролын сургалтыг орон нутагт зохион байгуулах, “Гэгээрэл” төв болон албан бус боловсролын багшийн ажлыг үнэлэх, дүгнэх тогтолцоо тодорхой болж байгаагаас гадна Мянганы хөгжлийн зорилт, Бүх нийтийн боловсролын зорилтыг хэрэгжүүлэхэд тус салбарын гүйцэтгэх үүргийг улам нэмэгдүүлж байна.

### ***Албан бус боловсролын сургалтыг онлайн хэлбэрт шилжүүлэх эхлэлийг тавив.***

Албан бус боловсролын боловсрол нөхөн олгох бага, суурь, бүрэн дунд боловсролын дүйцсэн хөтөлбөрийн сургалтыг онлайн хэлбэрт шилжүүлэх эхлэлийг тавьж, бага, дунд, бүрэн дунд боловсролын дүйцсэн хөтөлбөрийн 124 модулийг боловсруулж, эхийг АББЗСҮТ-ийн [www.nfde.mn](http://www.nfde.mn) web.сайтад байршуулсны гадна 500 хувь хэвлэн орон нутагт хүргүүллээ. Энэхүү модулийг манай улсын хэмжээнд ашиглагдаж

байгаа хамгийн бага хурдтай интернетийн орчинд хүлээн авах боломжтой хийсэн нь давуу талтай болно. Эдгээр модуль нь бага, суурь, бүрэн дунд боловсролын түвшинд албан бус боловсролын “Гэгээрэл” төвүүдэд суралцаж байгаа болон энэ чиглэлээр судалгаа хийж буй сонирхсон иргэд хэрэглэх боломжтой юм. Мэдээллийг цахим хэлбэрээр цуглуулах асуудлаар сургалт зохион байгуулж, бага, суурь бүрэн дунд боловсролын дүйцсэн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх, онлайн хэлбэрээр сургалт явуулах арга зүйд суралцлаа. Дүйцсэн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх цахим мэдээллийн бааз цуглуулах серверийг Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Дата төвд байршуулсан болно.



### ***Монгол бичгийн иж бүрэн программ хангамжтай боллоо.***

“Монгол бичиг үндэсний хөтөлбөр-II”-ийг хэрэгжүүлэх зорилгоор ерөнхий боловсролын сургуульд монгол бичгийн цогц программ, цахим мэдээллийн Unicode-д тулгуурласан компьютерт ашиглах монгол бичгийн иж бүрэн программ хангамжийг боловсруулах ажлыг дуусган ерөнхий боловсролын сургуульд түгээх, компьютерийн лабораторид эл програмыг суурилуулах, сургалтад нэвтрүүлэх ажлыг эхлүүлж, сургуулиудад энэхүү програмыг CD хэлбэрээр хүргүүлээд байна.

### ***Эцэг, эхэд зөвлөгөө өгөх төв байгуулав.***

Бага насны хүүхэдтэй эцэг, эхийн хүүхдээ хөгжүүлж, хүмүүжүүлэх боловсролыг нь дээшлүүлэх зорилгоор Дорнод, Увс аймагт “Эцэг, эхэд зөвлөгөө өгөх төв”-ийг НҮБ-ын Хүүхдийн сангийн санхүүжилтийн дэмжлэгтэйгээр байгуулсан нь 13459 эцэг эх бага насны хүүхдийн хөгжлийн асуудлаар мэргэжлийн хүмүүсээс зөвлөгөө авах боломж бүрдүүлэв. Түүнчлэн Дорнод аймгийн Баян-Уул, Чойбалсан, Увс аймгийн Хяргас, Улаангом сум, нийслэлийн Багануур, Налайх дүүргийн нийт 180 эцэг, эхэд сургалт зохион байгууллаа. Гэр бүлд бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих гарын авлагад тулгуурлан “Бага насны хүүхдийн хөгжил” телевизийн 6 цуврал нэвтрүүлгийг бэлтгэн Боловсрол телевизээр дамжуулан үндэсний хэмжээнд нэвтрүүллээ. Уг нэвтрүүлгийг электрон хичээл болгон казак хэлнээ хөрвүүлж, 2500 казак гэр бүлд хүргүүллээ.

### ***Улсын тэргүүний сургууль, цэцэрлэгүүдийг шалгаруулан урамшуулав.***

Цогц чадамжид суурилсан боловсролын стандартыг хэрэгжүүлэх, хүүхэд бүрт сурч, хөгжих тэгш боломжийг бүрдүүлж, тэдний оролцоог хангах, улмаар хүүхдэд ээлтэй сургалтын орчин бүрдүүлэх замаар боловсролын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилго бүхий “Улсын тэргүүний ерөнхий боловсролын сургууль” шалгаруулах ажлыг зохион байгууллаа. Улсын тэргүүний сургуулиар нийслэлийн Чингэлтэй дүүргийн 24 дүгээр сургууль, Өвөрхангай аймгийн Баянгол сумын ерөнхий боловсролын сургуулийг тус тус шалгаруулав. Улсын тэргүүний цэцэрлэгээр Увс аймгийн Тариалан сумын цэцэрлэг, нийслэлийн Баянгол дүүргийн 94 дүгээр цэцэрлэг, Булган аймгийн 4 дүгээр цэцэрлэг, Завхан аймгийн 1 дүгээр цэцэрлэгийг тус тус шалгарууллаа. Эдгээр сургууль, цэцэрлэгийг батламж, хаяг, нэг сая төгрөгөөр урамшууллаа.

### ***“Оны тэргүүний багш” шалгаруулав.***

Монголын багш нарын 44 дэх өдрийг тохиолдуулан тэргүүний үйл ажиллагаатай шилдэг багш нарыг шалгаруулан урамшуулах арга хэмжээг зохин байгууллаа. “Оны тэргүүний багш”-аар нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн “Ирээдүй” цогцолборын 1 дүгээр ахлах сургуулийн хими, биологийн багш Дэмбэрэлийн Үдэлгарав, 2 дугаар ахлах сургуулийн математикийн багш Жууяарын Чогмаа, Архангай аймгийн Эрдэнэбулган сумын 1 дүгээр цэцэрлэгийн багш Дариймаагийн Энхтуул, Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 1 дүгээр сургуулийн химийн багш Намсрайн Сүхбат, нийслэлийн Сүхбаатар дүүргийн “Олонлог” сургуулийн математикийн багш Балдандоржийн Ганболд нарыг шалгаруулж, тус бүрийг өргөмжлөл, 1 сая төгрөгөөр шагнав.

### ***Мэргэшил дээшлүүлэх сургалтууд зохион байгуулав.***

2010 онд зохион байгуулах сургалтын нэгдсэн төлөвлөгөөний дагуу “Бүх нийтийн боловсролын үр дүнд түргэн хүрэх санаачилгын түншлэл” хөтөлбөрийн хүрээнд Дэлхийн Банкны “Каталик” сангийн санхүүжилтээр 2010-2011онд 12 жилийн сургалттай сургуулийн 1-р ангид хичээл заах 1778 бага ангийн багшийг хамруулсан 2 шаттай сургалтыг зохион байгуулав. Үндэсний сургагч багш бэлтгэх эхний шатны сургалт-ыг 6 сарын 21-25-ны өдрүүдэд зохион байгуулж, 108 сургагч бэлтгэсэн бөгөөд тэдний 60 хувийг аймаг, нийслэлийн бага боловсрол хариуцсан мэргэжилтэн болон 2008-2009 оны хичээлийн жилд 6 настай хүүхдэд хичээл заасан шилдэг багш нар, сүүлийн 3 жид дараалан туршилтын 16 ангид хичээл заасан багш нараас бүрдүүлсэн болно. Мөн аймгууд дахь бага ангийн багш бэлтгэдэг бүх коллежийн төлөөллийг оролцууллаа. Сургалтад хэрэглэхээр бага ангийн багш нарт зориулан 7 хэвлэлийн хуудас бүхий “Зургаан настай суралцагчийн мэдлэг, чадвар, төлөвшлийн үнэлгээ” гарын авлагыг боловсруулан 2000 хувь хэвлэж, нэгдүгээр ангид хичээл заах багш нарт болон бага ангийн багш бэлтгэдэг бүх коллежийн номын санд хүргүүлээ.

Хүний эрхийн олон улсын байгууллага болох “Эмнести интернэйшл” ТТБ-тай хамтран Ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн хөтөлбөрт “Хүний эрхийн агуулгыг тусгах нь” сэдвээр 5 удаагийн сургалтыг явууллаа. Эхний ээлжинд ерөнхий боловсролын сургуулийн 12 жилийн сургалтын хөтөлбөр боловсруулах мэргэжлийн багийн гишүүдийг хамарсан 2 өдрийн сургалтаар сургалтын хөтөлбөрийн агуулгад хүний эрхийн боловсролыг тусгах аргагүй сэдвээр ажиллалаа.

Хувилбарт сургалтын хүртээмж, чанарыг сайжруулах зорилтын хүрээнд Завхан, Увс, Дундговь, Ховд, Хөвсгөл аймгийн 166 багшид хувилбарт сургалтыг зохион байгуулах арга зүйн сургалт зохион байгуулсан нь хувилбарт сургалтын чанарыг сайжруулах, багш нарын мэргэжил арга зүйн чадавхийг сайжруулахад нөлөөлсөн гэж үзэж байна. Түүнчлэн нийслэлд 9 аймгийн цэцэрлэгийн эмч, арга зүйч, Баянхонгор аймгийн цэцэрлэгийн эмч, арга зүйч нийт 50 хүнд бага насны хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах ажлыг хэрхэн зохион байгуулах талаар сургалт зохион байгуулж, эмч нарт зориулсан гарын авлага боловсрууллаа.

Багшийн хөгжлийн нийгэмлэгтэй хамтран бүтээлч багш хөдөлгөөн өрнүүлж, ЕБС-ийн багш нарын дунд уралдаан зарлаж ирүүлсэн бүтээлийн төрөл бүрээр шалгаруулалт хийж, шалгарсан бүтээлээр Занабазарын нэрэмжит музейд 2 өдөр үзэсгэлэн гаргаж

нийтийн хүртээл болгосон нь багш нарын ур чадварыг нийтэд сурталчилж, урам өгсөн ажил байлаа.

Улаанбаатар хотын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилго бүхий “МӨРӨӨДЛИЙН СУРГУУЛЬ-НОГООН ТӨГӨЛ” байгуулах асуудлаар Солонгосын “Ногоон-Ази” ТББ-ын Монгол дахь төлөөлөгчийн газар, Боловсрол, соёл шинжлэх ухааны яам, Нийслэлийн Боловсролын газар, Монгол-Солонгосын хүүхэд залуучуудын хамтарсан байгаль хамгаалах сантай хамтран ажиллах “Санамж бичиг” байгуулан түүний дагуу БСШУЯ-наас ерөнхий боловсролын сургууль, их, дээд сургууль төгсөгчдийг эх дэлхийгээ хайрлан хамгаалах, төгсөгч бүр нэг мод тарьж хүрээлэн буй орчиндоо эрүүл агаар бэлэглэх хөдөлгөөн өрнүүлж нийслэлийн 10 сургуулийн төгсөгчдийг оролцуулан 2010 оны 5 дугаар сарын 16-17-ны өдрүүдэд мод тарих үйл ажиллагааг зохион байгуулав.

## **Хоёр. Дээд болон мэргэжлийн боловсролын талаар**

Тус яам дээд болон мэргэжлийн боловсролын салбарын цаашдын шинэчлэл, өөрчлөлтийн суурийг тавьсан эрх зүйн орчин, зохицуулалтыг хийхэд анхаарч ажилласны дүнд 2010 онд тодорхой ахиц гаргалаа.

***Дээд боловсролын шинэчлэлийн зураглал /roadmap/-ыг батлан хэрэгжүүлж эхлэв.***

Дээд боловсролын салбарт төрөөс дэвшүүлсэн зорилтуудын хэрэгжилтийг хангах ажлын төлөвлөлт, зохицуулалтыг сайжруулах, уялдаа холбоог хангаж цогцоор нь хэрэгжүүлэх зорилгоор төрийн бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан болон цаашид авах арга хэмжээг иж бүрэн байдлаар харуулсан “Дээд боловсролын шинэчлэлийн зураглал /roadmap/ 2010-2021”-ыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, БСШУ-ы сайдын тушаалаар батлан хэрэгжүүлж эхэллээ. Энэхүү зураглалд тусгагдсан арга хэмжээ хэрэгжсэнээр нийт их сургуулийн сургалтын хөтөлбөр олон улсын стандартад бүрэн нийцэж, төрийн өмчийн сургуулиудын хотхон ашиглалтад орж, боловсролын чанарын үнэлгээний шинэ тогтолцоог буй болгосоноор иргэд чанартай дээд боловсрол эзэмших тасралтгүй суралцах боломж нэмэгдэн, Монголын дээд боловсролын өрсөлдөх чадвар, үнэлэмж дээшлэн, дээд боловсролтой холбоотой үндэсний бодлого, хөтөлбөр, төслүүдийн хэрэгжилтийг хангасан байх юм.

***Төрийн өмчийн их, дээд сургуулийн бүтцийн өөрчлөлт хийх шийдвэр гарган хэрэгжүүлж эхлэв.***

Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан өрсөлдөх чадвартай цөөн сургуулийг буй болгох зорилтыг хэрэгжүүлэхдээ Засгийн газар бүтцийн өөрчлөлтийг төр өөрөөсөө эхлэх ёстой гэсэн чиглэлийг удирдлага болгон төрийн өмчийн дээд боловсролын сургалтын зарим байгууллагыг өөрчлөн байгуулах асуудлыг Засгийн газрын 2010 оны 15 дугаар тогтоолоор шийдвэрлэв. Тогтоолд заасны дагуу төрийн өмчийн их сургуулиудад зарим сургалтын байгууллагыг нэгтгэх, их сургуулийн харъяа сургуулиудыг тухайн их сургуулийн салбар болгон өөрчлөх, шаталсан сургалттай зарим коллежийг МСҮТ болгон өөрчлөн зохион байгуулах, зарим сургуулийг татан буулгах арга хэмжээ авч хэрэгжүүллээ. Ийнхүү тогтоолд заасан арга хэмжээг хэрэгжүүлснээр төрийн

өмчийн дээд боловсролын байгууллагын тоо 42-оос 16 болж цөөрөв. “Төрийн өмчийн дээд боловсролын сургалтын зарим байгууллагын өөрчлөн байгуулалттай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2010 оны 319 дугаар тушаалаар өөрчлөн байгуулалтад орсон сургуулиудын магистрантур, докторантурт суралцаж буй нийт 288 багшийн сургалтын төлбөр 580 сая төгрөг, орон нутгаас нийслэлд шилжин ирэх 507 оюутны замын зардал, сургалтын төлбөрийн зөрүү нийт 508 сая төгрөгийг Сургалтын төрийн сангаас тус тус санхүүжүүлэхээр шийдвэрлэж бүтцийн өөрчлөлтийг дэмжив. Эдгээр цогц арга хэмжээний дүнд Засгийн газрын 2010 оны 15 дугаар тогтоол амжилттай хэрэгжлээ.

Энэхүү бүтцийн өөрчлөлт нь дээд боловсролын салбарын хөрөнгөө оруулалтын үр ашгийг дээшлүүлэх, материаллаг болон хүний нөөцийн ашиглалт, чадавхийг сайжруулах, их сургуулийг хотхоноор хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлэх таатай суурь нөхцөлийг бүрдүүлж байгаа болно.

### **“Их сургуулиудыг хотхоноор хөгжүүлэх чиглэл”-ийг батлуулан хэрэгжүүлж эхлэв.**

“Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого”-ыг хэрэгжүүлэх зорилгоор “Их сургуулиудыг хотхоноор хөгжүүлэх чиглэл”-ийг боловсруулан Монгол Улсын Засгийн Газрын 2010 оны 149 дүгээр тогтоолоор батлуулав. Их, дээд сургуулийн профессор, багш, судлаач, магистрант, докторант, ШУА-ийн хүрээлэн, төвүүдийн эрдэмтэн, эрдэм шинжилгээний ажилтны хамтын ажиллагааг шинэ шатанд гаргаж, сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг хамтран хийж, гарсан үр дүнг нь бизнесийн болон санхүүгийн байгууллагатай хамтран үйлдвэрлэлд шуурхай нэвтрүүлэхэд энэхүү хотхон байгуулах бодлого чиглэгдэж байгаа болно. “Их сургуулиудыг хотхоноор хөгжүүлэх чиглэл”-д их сургуулиудыг хотхоноор хөгжүүлэхэд



баримтлах зарчим, их сургуулиудын хотхонд тавих шаардлага, хотхоны байршил болон шийдвэрлэх арга хэмжээний чиглэл, хотхоны санхүүгийн эх үүсвэр зэргийг тодорхой тусгав. Энэхүү чиглэл хэрэгжүүлснээр үндэсний их сургуулиудын сургалт, судалгааны орчин нөхцөл, түүний ашиглалт сайжруулж, дээд боловсролын олон улсын хэмжээнд өрсөлдөх чадвар дээшилж, олон улсын

тэргүүлэх их сургуулиудын жишигт ойртох нөхцөлийг бүрдүүлэх юм. Их сургуулиудын хотхоныг 2010-2021 онд багтаан үе шаттайгаар барьж байгуулна.

Дээр дурдсан чиглэлд их сургууль болон хотхоныг дараах байдлаар төлөвлөж хөгжүүлэхээр тусгагдсан болно:

- Эхний ээлжинд ШУТИС-ийн хотхоныг Улаанбаатар хотын Налайх дүүргийн зүүн урд хэсэгт “Шивэрт”-ийн хөндийд 2000 гаруй га газарт “Оюуны” дагавар хот байдлаар “Силикон вээлий”-гийн хамт байршуулах.
- Төрийн ба төрийн бус өмчийн бусад их, дээд сургууль, коллеж дангаараа эсхүл нэгдэж их сургуулийн хотхон байгуулах тохиолдолд хөрөнгө оруулагчийн сонголт хийсэн газарт байрших боломж олгох.
- Геологи, уул уурхайн их сургуулийн хотхоныг Орхон аймгийн төвд “Эрдэнэт” ХХК болон хувийн хэвшлийн дэмжлэгтэйгээр зохион байгуулж эхлүүлэх.
- Ховд аймаг дахь Ховд их сургуулийг баруун бүсийн сургалт, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэл, бизнесийн төв болгон хөгжүүлэх.
- Дорнод аймаг дахь Дорнод дээд сургуулийг зүүн бүсийн сургалт, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэл, бизнесийн төв болгон хөгжүүлэх.
- Дархан-Уул аймгийн төвд техникийн чиглэлийн их сургуулийг байгуулж хөгжүүлэх. Төрийн бус өмчийн их, дээд сургууль, коллежийн нэгдэх эсхүл хамтарч хотхоноор хөгжих санаачилгыг төрөөс дэмжиж хотхон байгуулах эдэлбэр газар олгох, дэд бүтцийг байгуулахад бодит дэмжлэг үзүүлэх.

“Их сургуулиудыг хотхоноор хөгжүүлэх чиглэл”-ийн хэрэгжилтийг хангахад Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам онцгой анхаарч ажиллав. Их сургуулиудын хотхоны ашиглалтын өмнөх захиргааг БСШУ-ы сайдын 6 дугаар сарын 25-ны өдрийн 303 дугаар тушаалаар байгуулж, түүнийг хуулийн этгээдийн эрхтэйгээр Улсын бүртгэлийн ерөнхий газарт албан ёсоор бүртгүүлж үйл ажиллагааг нь эхлүүлэв.

БСШУЯ, БНСУ-ын Солонгосын боловсролын хөгжлийн хүрээлэн хамтран “Монголд их сургуулийн хотхоныг байгуулах нь” сэдэвт Монгол-Солонгосын боловсролын бодлогын форумыг Улаанбаатар хотноо зохион байгуулав. Энэхүү форумд Солонгосын талаас Сеулийн үндэсний их сургууль болон Станфорд их сургуулийн хотхон байгуулсан туршлага, хотхоны байгууламжийн туршлагыг танилцуулсан нь хотхон байгуулах практик үйл ажиллагааг тодорхойлоход зохих тус нэмэр боллоо.

БСШУ-ы сайд Ё.Отгонбаяр БНСУ-ын дулааны цахилгаан станц хариуцсан “КОСЕР” компаний удирдлагатай уулзаж, Шивээтийн хөндийд баригдах их сургуулиудын хотхоныг эрчим хүчээр хангах техник- эдийн засгийн судалгааг уг компаниар хийлгэхээр тохиролцлоо. Энэхүү тохиролцооны дагуу Санамж бичиг байгуулав. Өмнө нь Солонгосын талын мэргэжилтнүүд манай улсад ирж их сургуулиудын хотхоныг барих газартай танилцсан бөгөөд урьдчилсан байдлаар 100 мвт-ын хүчин чадалтай дулааны цахилгаан станц барихаар төлөвлөөд байна. Энэ цахилгаан станц одоогийн манай IV цахилгаан станцаас 4 дахин бага хүчин чадалтай байх ч их сургуулиудын хотхоныг цахилгаан эрчим хүчээр бүрэн дүүрэн хангаад зогсохгүй бусад дагалдах үйлчилгээ, аж ахуйн газруудыг цахилгаан эрчим хүчээр хангах боломжтой юм.

Хотхоны туршлага судлах ажлын хэсгүүдийг БНСУ, БНХАУ-д явуулах талаар холбогдох талтай хийж буй яриа хэлцэл амжилттай явагдаж байна. БНХАУ-ын туршлага судлах ажлын хэсгийг 2011 оны эхний улиралд явуулахаар тохиролцоод байна.

Концессын хуулийн хүрээнд Засгийн газрын дэмжлэг үзүүлэх объектуудын тоонд Их сургуулиудын хотхоны барилга байгууламжуудыг хамруулах асуудлыг шийдвэрлүүлэв.

### **“Хүний хөгжил сан”-аас оюутны сургалтын төлбөр олгохоор боллоо.**

Төр, засгаас дээд боловсролын үйлчилгээнд онцгой анхаарал хандуулж, “Хүний хөгжил” сангаас иргэдийн авах үйлчилгээний төрөлд дээд боловсролын үйлчилгээг хамруулж, 2010-2011 оны хичээлийн жилийн сургалтын төлбөрийн эхний 4 сард ногдох хэсгийг суралцагч өөрөө хариуцах, 2011 оны 1 дүгээр сараас эхлэн сургалтын төлбөрийн зохих хэсгийг Хүний хөгжил сангийн тухай хуульд нийцүүлэн Монгол Улсын 2011 оны төсвийн төсөлд тусгах асуудлыг шийдвэрлүүлэв. Хүний хөгжил сангаас дээд боловсролын сургалтын төлбөрийн тодорхой ихэсгийг төлнө гэсэн нийгмийн хүлээлтэд хариу өгч, сургалтын төлбөртэй холбогдон иргэнд учирч байгаа дарамтыг тодорхой хэмжээгээр хөнгөвилчилсэнд энэ шийдвэрийн ач холбогдол оршино.

### **Дээд боловсролын хөтөлбөрийг олон улсын магадлан итгэмжлэлд хамруулах бэлтгэлийг хангаж байна.**


Дээд боловсролын чанарыг дээшлүүлэх чухал хөшүүрэг болох магадлан итгэмжлэлийн стандарт, түүний үзүүлэлт, үнэлгээний арга зүйг олон улсын жишигт хүргэх, Монголын дээд боловсролын сургалтын байгууллагууд хөтөлбөрөө олон улсын эрх бүхий байгууллагаар магадлан итгэмжлүүлэх үйл ажиллагааг дэмжиж, шаардлагатай дэмжлэг тусалцааг үзүүллээ. Америкийн Бизнесийн сургууль, хөтөлбөрүүдийн холбоо, Монгол Улсын Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл, Санхүү, эдийн засгийн дээд сургууль хамтран “Олон улсын магадлан итгэмжлэл” сэдэвт олон улсын семинарыг Улаанбаатар хотноо 2010 оны 4 дүгээр сарын 6-7-ны өдрүүдэд БСШУЯ-ны ивээл дор зохион байгуулав. Энэхүү семинарт АНУ-ын Дээд боловсролын магадлан итгэмжлэлийн зөвлөлийн тэргүүн, хатагтай Жудит Йитэн, Америкийн Бизнесийн сургууль, хөтөлбөрүүдийн холбооны гүйцэтгэх захирал, ноён Дуглас Виеланд нар оролцож, АНУ-ын дээд боловсролын чанарын баталгаажуулалт, Америкийн Бизнесийн сургууль, хөтөлбөрүүдийн холбооны үйл ажиллагааны жишээн дээр хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн зарчим, үзэл баримтлал, стандарт ба түүний шалгуур, гадаад орны сургууль, хөтөлбөр АНУ-ын бүсийн болон үндэсний магадлан итгэмжлэх байгууллагаар хэрхэн магадлан итгэмжлүүлэх талаар зөвлөгөө өгч, туршлагаасаа хуваалцлаа. Энэ арга хэмжээний үр дүнд олон улсын түвшний боловсролын магадлан итгэмжлэлийн байгууллагын эрх зүйн орчны талаар нэгдсэн ойлголттой болж, магадлан итгэмжлэлийн шинэчлэлийг гүнзгийрүүлэх, их, дээд сургуулиуд хөтөлбөрөө олон улсын байгууллагаар магадлан итгэмжлүүлэх сонирхол дээшлэн, сэтгэлзүйн нэн таатай орчин буй болж байгна. Олон улсын хөтөлбөрийн магадлан итгэмжлээр дамжуулан Монголын дээд боловсролын салбарт олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн. Стандартуудыг нэвтрүүлэх, магадлан итгэмжлэлийн үйл ажиллагааг зохион байгуулдаг туршлагаас суралцах өргөн боломж нээж байгаа юм. Хэд хэдэн их, дээд сургууль энэ байгууллагаар магадлан итгэмжлэл хийлгэх асуудлыг тохироод байна.

МУИС-ийн Эдийн засгийн сургууль хөтөлбөрүүдээ тус байгууллагаар магадлан итгэмжлүүлэх бэлтгэл ажилд орж, тэнхимийн эрхлэгчид оролцсон 15 хүн АНУ-ын Лос-Анжелест болсон Бизнесийн сургууль, хөтөлбөрүүдийн холбооны жил бүр болдог уламжлалт хуралдаанд оролцон уг холбооны гишүүн сургуулиуд дээр очиж туршлага

судалсан. Америкийн Бизнесийн сургууль, хөтөлбөрүүдийн холбоо МУИС-ийн ЭЗС-ийн хөтөлбөрийн магадлан итгэмжлэл хийлгэх тухай өргөдлийг хүлээн авч танилцаад МУИС-ийн ЭЗС нь уг холбооноос тавьдаг шаардлагыг хангаж байгаа тул МУИС-ийн ЭЗС-ийг холбооны албан ёсны гишүүн болгож, хөтөлбөрийн олон улсын магадлан итгэмжлэл хийлгэх "кандидат"-ын статустай болгосныг гэрчилсэн Сертификатыг олголоо. Одоо МУИС-ийн ЭЗС магадлан итгэмжлэлийн өөрийн үнэлгээ хийх бэлтгэлийг хангах ажилдаа идэвхийлэн ороод байна.

### ***Гадаад орны их, дээд сургуульд суралцагчдын тоог нэмэгдүүлэх талаар ахиц гарлаа.***

Өндөр хөгжилтэй оронд оюутан магистрант сургах тоог нэмэх, суралцах хүмүүсийг чиг зорилготойгоор шалгаруулах арга хэмжээ авав. Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээрийн дагуу 2010-2011 оны хичээлийн жилээс гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцуулах хүмүүсийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгууллаа. Энэ хичээлийн жилд манай улсаас ОХУ, БНХАУ, Турк, Энэтхэг, БНПУ, БНЧУ, БНСУ, БНСВУ, БНАЛАУ зэрэг 15 оронд 484 оюутан, 6 оронд 169 магистр, докторант илгээлээ.



ХБНГУ-ын Германы эрдмийн солилцооны албатай хамтран ажиллах санамж бичгийг 2010 оны 6 дугаар сард байгуулж, түүний дагуу хамтран хэрэгжүүлж байгаа "Уул уурхайн салбарт ажиллах мэргэжилтэн бэлтгэх" хөтөлбөрийн хүрээнд 2010-2011 оны хичээлийн жилд ХБНГУ-д 10 бакалавр, 7 магистр элсүүлэн сургаж байна. АНУ-ын Фулбрайтын сантай хамтарсан тэтгэлгийн хөтөлбөр хэрэгжүүлэх санамж бичиг байгуулж, энэ хичээлийн жилд АНУ-д 10 хүн сургахаар тохиролцоод байна.

Өндөр хөгжилтэй оронд магистрантурт суралцах хүсэлтэй орон нутагт ажиллаж байгаа залуучуудыг дэмжих зорилгоор ЗГХЭГ-тай хамтран аймаг бүрээс 1 хүнийг өндөр хөгжилтэй орны магистрантурт сургахаар шалгаруулж, тэднийг 3 сарын англи хэлний эрчимжүүлсэн сургалтад хамруулаад байна. Багшийн чадавхийг дээшлүүлэх зорилгоор өндөр хөгжилтэй орны их сургуулийн магистрантур, докторантурт төрийн өмчийн их сургуулиудын 60 багшийг 2010-2011 оны хичээлийн жилээс суралцуулах тусгай арга хэмжээ авч, их сургуулиудаас нэр дэвшигчдийн материалыг хүлээн авч, сургалтад хамруулах бэлтгэл ажлыг зохион байгуулав.

### ***Дээд болон мэргэжлийн боловсролын салбарт төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхэд анхаарч байна.***

Азийн хөгжлийн банкны тусламжаар "Монгол Улсын дээд болон мэргэжлийн боловсролыг бэхжүүлэх" техникийн туслалцааны төсөл хэрэгжив. Энэхүү төслийн хүрээнд 2011 оноос эхлэн 5 жилийн хугацаатай хэрэгжүүлэх "Дээд боловсролыг

бэхжүүлэх” төслийн дизайныг боловсруулаад байна. Энэхүү төсөлд их, дээд сургуулиудын багш нарыг чадавхижуулах, зарим сургуульд засвар хийх, лабораторийн тоног төхөөрөмж нийлүүлэх, дээд боловсролын салбарын шинэчлэлтэй холбогдуулан эрх зүйн зохицуулалт хийх зэрэг асуудлыг тусгаад байна.



Үндэсний мэргэжилтэй ажилтан бэлтгэх талаар авах арга хэмжээний саналыг НХХЯ-тай хамтран боловсруулж Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 212 дугаар тогтоолоор шийдвэрлүүлэв. Энэ тогтоолын биелэлтийг хангах ажлыг тус яам НХХЯ хамтран зохион байгуулж байна. Энэ ажлын хүрээнд “Оюу толгой ХХК-ий хөрөнгө оруулалтаар үндэсний мэргэжилтэй ажилтан бэлтгэх, ажилд зуучлах журам”-ыг боловсруулж, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2010 оны 409/123 дугаар

хамтарсан тушаалаар баталгаажуулаад байна. Уг журмаар томоохон төсөл, бүтээн байгуулалтад ажиллах хүсэлтэй болон орон нутгийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэст бүртгэлтэй ажилгүй иргэн, Зэвсэгт хүчний хугацаат цэргийн мэргэжлийн албан хаагч 3300 иргэнийг “Оюу толгой” ХХК-ий хөрөнгө оруулалтаар 36 Мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвд суралцуулан мэргэжил эзэмшүүлэх асуудлыг зохицуулах юм. Энэ хүрээнд эхний 1000 суралцагчийг элсүүлэн сургалтын үйл ажиллагааг 2010 оны 10 дугаар сараас 12 МСҮТ дээр эхлүүлэв.

Оюу толгой төслөөс хийх 36 тэрбум төгрөгийн санхүүжилтийн 12.1 тэрбумыг суралцагчдын сургалтын зардал, тээвэр, тэтгэлэг, нийгмийн даатгал, хоол хүнсний зардалд, 15 тэрбумыг Мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн чадавхийг бэхжүүлэх, тоног төхөөрөмжөөр хангахад, 7.8 тэрбумыг багш нарын сургалт болон олон улсын зөвлөх урих, сургалтын хөтөлбөр шинэчлэх, худалдан авах, сургалтын хэрэглэгдэхүүн орчуулах, хэвлэхэд зарцуулахаар төлөвлөөд байна.

Суралцагчдыг сонгож сургахдаа төв, орон нутгийн оролцоог жигд хангаж, нийт хүн амын тоотой нь хувь тэнцүүлэн, суралцах хүний квотыг хот, аймаг, сум, дүүргүүдэд тогтоох зарчмаар гаргасан болно. Дунджаар 816 хүн тутам 1 квот ногдож байна. Энэ квотыг “Оюу толгой ХХК-ий хөрөнгө оруулалтаар үндэсний мэргэжилтэй ажилтан бэлтгэх, ажилд зуучлах журам”-ын хамт аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга нарт хүргүүлсэн болно. Насанд хүрэгчдийн сургалтын эхний ээлжийн 1000 хүнийг сонгон авч сургалтыг 2010 оны 10-р сараас 12 сургууль дээр эхлүүлэв. Хоёрдугаар ээлжийн 2300 гаруй хүний сургалтыг 2011 онд улсын хэмжээнд 36 сургууль дээр зэрэг эхлүүлэх бэлтгэлийг хангав.

“Оюутны дотуур байр-20000” хөтөлбөрийн төслийг боловсруулж шинээр 1000 ортой оюутны дотуур байр барих ажлыг нийслэлийн Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэр Сэлбэ голын эрэгт дээр эхлүүлж, 2012 онд ашиглалтад оруулахаар ажиллаж байна.

Тус яамнаас “Оюу толгой ХК-тай хамтран ажиллах санамж бичиг байгуулж, шинээр 2 МСҮТ байгуулах, 4 МСҮТ-ийг загвар МСҮТ болгох хөрөнгө оруулалт хийх, гадаадад

сургах 30 хүний тэтгэлэг олгох, дотоодын их, дээд сургуульд уул уурхайн чиглэлээр 120 хүний тэтгэлэг олгох зэрэг асуудлыг шийдвэрлэлээ.

Мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын багш нарыг сургах зүйн боловсрол олгох, үндсэн мэргэжлээр нь мэргэшлийг нь дээшлүүлэх, шинэ техник технологитой танилцуулах ажлыг үргэлжлүүлж байгаагийн зэрэгцээ МСС-ийн “Техник мэргэжлийн боловсрол, сургалтын төсөл”-өөр багш нарыг гадаадад урт, богино хугацаагаар сургах ажлыг эхлээд байна. Тухайлбал, Монголын мянганы сорилтын сангийн “Техник мэргэжлийн боловсрол, сургалтын төсөл”-өөр хүнд машин механизмын жолооч-оператор бэлтгэж байгаа 22 сургалтын байгууллагын багш нарт “Вагнер-Ази” компанийг түшиглэн сургалт явуулж, энэ сургалтад нийт 29 багш хамруулав. Эдгээрээс 6 багшийг АНУ-д сургалтад хамруулаад байна. Мөн 2010 оны 7 дугаар сарын 5-ны өдрөөс 8 дугаар сарыг дуустал Говьсүмбэр аймгийн Чойр дахь Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв дээр зохион байгуулсан сургалтад уул уурхай, барилгын чиглэлээр сургалт эрхэлдэг мэргэжлийн боловсролын байгууллагуудын хүнд машин механизмын оператор, барилгын мужаан, гагнуур болон англи хэлний мэргэжлийн 30 багшийг хамруулав.

***Их сургуулийн багш нарын мэргэшлийг дээшлүүлэд бодитой ахиц гарч байна.***

Тайлан онд их сургуулиуд багш нарынхаа мэргэшлийг гадаад, дотоодод дээшлүүлэх талаар ихээхэн чармайлт гарган ажиллалаа. Тухайлбал, Монгол улсын их сургууль 55, Шинжлэх ухаан, технологийн их сургууль 264, Эрүүл мэндийн шинжлэх ухааны их сургууль 78, Хөдөө аж ахуйн их сургууль 77, Соёл, урлагийн их сургууль 31, Боловсролын их сургууль 63, “Ховд” их сургууль 34, нийт 602 багшийг гадаадад мэргэжил дээшлүүлэх, туршлага судлах томилолтоор ажиллуулсан байна. Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Монголын их, дээд сургуулийн консорциум хамтран зохион байгуулж Бүгд Найрамдах Солонгос Улсын Сөүлийн их сургуульд мэргэжил дээшлүүлсэн их, дээд сургуулийн 10 багшийн сургалтын зардлын зөрүү 10000000 /арван сая/ төгрөгийг боловсролын төвлөрсөн арга хэмжээний зардлаас санхүүжүүлэв. Түүнчлэн Монгол улсын их сургууль 35, Шинжлэх ухаан, технологийн их сургууль 186, Эрүүл мэндийн шинжлэх ухааны их сургууль 457, Хөдөө аж ахуйн их сургууль 82, Соёл, урлагийн их сургууль 47, Боловсролын их сургууль 330, “Ховд” их сургууль 52, нийт 1791 багшийн мэргэшлийг дотооддоо дээшлүүлэв. Эдгээр их сургуулийн хувьд 2010 онд мэргэжил дээшлүүлсэн багшийн тоо өмнөх оноос 5,6 хувиар өсчээ.

## **Гурав. Соёл, урлагийн талаар**

***“Монгол Улсын төрөөс баримтлах соёлын бодлого”-ын шинэчилсэн төслийг Улсын Их Хуралд өргөн барихаар шийдвэрлэв.***

“Монгол Улсын төрөөс баримтлах соёлын бодлого”-ын шинэчилсэн төслийг боловсруулж, Засгийн газрын 2010 оны 12 дугаар сарын 8-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр шийдвэрлүүлсний дээр “Соёлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай”, “Соёлын өвийг хамгаалах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төсөл, Монгол Улсын соёл, урлагийг 2011-2020 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөөний төслийг боловсруулаад байна.

***"Түүхэн үйл явдлын ой, тэмдэглэлт өдрийг тэмдэглэх, гавьяат үйлстнийг алдаршуулах, дурсгалыг нь мөнхжүүлэх журам"-ыг хэрэгжүүлж эхэллээ.***

Засгийн газрын 1998 оны 234 дүгээр тогтоолоор баталсан "Түүхэн үйл явдлыг тэмдэглэх, төр, нийгмийн зүтгэлтэн, гавьяат үйлстнийг алдаршуулах, дурсгалыг нь хүндэтгэх ажлыг зохион байгуулах журам", Засгийн газрын 2004 оны 163 дугаар тогтоолоор баталсан "Тэмдэглэлт өдрүүдийн жагсаалт, тэмдэглэлт өдрийг тэмдэглэх журам"-ыг нэгтгэж, нэмэлт, өөрчлөлт оруулан боловсруулж, "Түүхэн үйл явдлын ой, тэмдэглэлт өдрийг тэмдэглэх, гавьяат үйлстнийг алдаршуулах, дурсгалыг нь мөнхжүүлэх журам" болгон Засгийн газрын 2010 оны 172 дугаар тогтоолоор батлуулан мөрдүүлж байна. Энэхүү журмаар Монголын түүхэнд холбогдох онцгой болон түүхэн үйл явдал, тэмдэглэлт өдрийг тус бүрээр тодорхойлон зааж, тэдгээрийг хэзээ, хэрхэн тэмдэглэх асуудлыг журамласны зэрэгцээ байгууллага, гавьяат үйлстний ойг тэмдэглэх хугацааны давтамжийг тодорхой болгов. Мөн аймаг, нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал орон нутгийн байгууллагыг, Засгийн газар орон нутгийнхаас бусад байгууллагыг гавьяат үйлстний нэрэмжит болгох шийдвэр гаргаж байхаар журамласан болно.

Энэ чиглэлээр эх орончдын өдрийг тэмдэглэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх, "Шадар ван Чингүнжавын мэндэлсний 300 жилийн ойг тэмдэглэх тухай" Засгийн газрын тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах, төрийн шагналт, гавьяат багш, академич Ш.Лувсанванданы мэндэлсний 100 жилийн ойг тэмдэглэх, нийслэлийн Баянгол дүүргийн герман хэлний гүнзгийрүүлсэн сургалттай ерөнхий боловсролын 38 дугаар сургуулийг Германы алдарт эрдэмтэн Александр фон Хумбольдтын нэрэмжит болгох, Дэлхийн 2 дугаар дайн дууссаны болон 1945 оны чөлөөлөх дайны ялалтын 65 жилийн ой, монгол хүн сансарт ниссэний болон хамтарсан нислэгийн 30 жилийн ойг тэмдэглэх зэрэг асуудлыг тус тус боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлээ.

***Монголчуудын өв соёлыг дэлхийд өндөр үнэллээ.***

Монгол Улсаас нэр дэвшүүлсэн "Монгол Үндэстний баяр–Наадам", "Монгол үндэстний хөөмэйн урлаг", "Бүргэдийн ан буюу Шувуучлахуй"-г ЮНЕСКО-гийн Хүн төрөлхтний соёлын биет бус өвийн жагсаалтад бүртгэлээ. Энэ нь монголчуудын өв



соёлыг дэлхийд өндөр үнэлсэн хэрэг юм. "Монгол гэрийн урлал", "Монгол хувцасны уламжлалт урлал", "Монгол цам", "Лимбэ, бишгүүрийн битүү амьсгаа", "Монгол уран

бичлэг”, “Уран нугаралт” зэрэг 10 төрөл, зүйлийг соёлын биет бус өвд бүртгүүлэхээр өргөдөл, баримт бичиг, материалыг бэлтгэж ЮНЕСКО-д хүргүүлээ.

### ***Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийн тоо 593-д хүрэв.***

Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийн жагсаалтад нэмэлт оруулах асуудлыг боловсруулан Засгийн газрын Засгийн газрын 2010 оны 103 дугаар тогтоолоор батлууллаа. Ингэснээр манай улс 593 түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлтэй боллоо. Хархорум, Хөшөө цайдам музейг шинээр байгуулж, үйл ажиллагааг эхлүүлээ.

### ***Анх удаа гадаад оронд хүүхэлдэйн жүжигчдийг багаар нь бэлтгэж эхлэв.***

2010-2011 оны хичээлийн жилд ОХУ-ын Пермь хотын бүжгийн дунд сургуульд бүжгийн жүжигчин мэргэжлээр 12 хүүхдийг, Санкт-Петербург хотын театр, урлагийн академид хүүхэлдэйн жүжигчин мэргэжлээр 10 хүнийг, дуурийн дуучин, хөгжимчин мэргэжлээр тус бүр 2, мэргэжил дээшлүүлэгч 2, нийт 28 оюутныг шинээр элсүүлэн сургаж эхэллээ. Монгол Улсад хүүхэлдэйн жүжигчин бэлтгэх суурь бааз байхгүй тул манай улсаас ийнхүү анх удаа гадаад оронд хүүхэлдэйн жүжигчдийг багаар нь бэлтгэж байна.

### ***Монголын соёл, урлагийн гадаад сурталчилгааг өргөжүүлэв.***

Монгол Улсын Соёлын өдрүүдийг 2010 оны 11 дүгээр сарын 11-14-нд Казахстан улсын нийслэл Астана хотод, мөн сарын 14-нөөс 18-ны өдрүүдэд ОХУ-ын нийслэл Москва болон Санкт-Петербург хотод амжилттай зохион байгууллаа.



Соёлын өдрүүдийн хүрээнд Монголын кино өдрүүд явуулах, гэрэл зургийн болон хүүхдийн гар зургийн үзэсгэлэн гаргах, урлагийн мастеруудын тоглолт хийх арга хэмжээг зохион явууллаа. Мөн Монголын соёлын өдрийг 2010 оны 5 дугаар сарын 2-9-нд БНХАУ-ын ӨМӨЗО-ы Хөх хотноо зохион байгуулав. Энэ үеэр Монгол орон, монголчуудын аж байдлыг харуулсан гэрэл зургийн үзэсгэлэн, Монголын кино өдрүүд, зохиолчдын уулзалт, хил залгаа аймгуудын

урлагийн тоглолт, хүүхдийн урлагийн өдрүүд, уран зургийн үзэсгэлэн, соёл, урлагийн мэргэжлийн багш нарын туршлага солилцох өдрүүд болон нээлт, хаалтын тоглолт бүхий 10 гаруй арга хэмжээг амжилттай зохион байгууллаа.

АНУ-д зохион байгуулж буй “Чингис хаан” үзэсгэлэнг 2010 оны 5-10 сард Сан Хосе хотын Техникийн музейд амжилттай зохион байгуулж, 170000 хүнд үйлчилсэн бөгөөд 2011 оны 2 сараас Сингапурт гаргахаар бэлтгэж байна.

### ***Солонгосын соёлын жилийг Монгол Улсад зохион байгуулав.***

Монгол Улс, БНСУ-ын хооронд дипломат харилцаа тогтоосны 20 жилийн ойг тохиолдуулан 2010 онд Солонгосын соёлын жилийг Монгол Улсад зохион байгуулахаар

хоёр тал тохиролцсоны дагуу уг арга хэмжээг 2010 оны 3 дугаар сарын 12-ноос 10 дугаар сарын 26-ны хооронд зохион явууллаа. Солонгосын жилийн арга хэмжээний хүрээнд Солонгосын кино өдрүүд, нөхөрсөг барилдаан, солонгосын тамирчдын таеквондогийн үзүүлэх тоглолт, Солонгосын орчин үеийн урлагийн хамтлаг, ардын урлагийн тоглолт, үндэсний хувцасны загварын үзүүлэх тоглолт зэрэг олон арга хэмжээг зохион байгуулж олны хүртээл болголоо.

### ***Олон Улсын “Алтаргана-2010” наадмыг амжилттай зохион байгуулав.***

Буриадын соёл, урлаг, спортын Олон Улсын “Алтаргана-2010” наадмыг 2010 оны 7 дугаар сарын 21-23-нд Улаанбаатар хотноо зохион байгуулав. Наадамд Оросын Холбооны Улсын Москва хот, Буриад улсын 14 район, Улан-Үд хот, Эрхүү муж, Өвөр байгалийн хязгаар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Өвөр Монголын Өөртөө Засах Орны Шинэхээн хошуу, Монгол Улсын Улаанбаатар хот, Төв, Дорнод, Хэнтий, Сэлэнгэ,



Булган, Дархан-Уул, Орхон, Хөвсгөл аймгаас нийтдээ 1700 гаруй зочин, төлөөлөгч, ардын авъястан, тамирчид оролцлоо. “Алтаргана-2010” наадмын үеэр 15 төрлийн бэсрэг наадам, уралдаан тэмцээн зохион байгуулсан бөгөөд эдгээрээс ОХУ-ын Буриад улс 23 медаль, ОХУ-ын Өвөр байгалийн хязгаар 18 медаль, ОХУ-ын Эрхүү муж 10 медаль, Улаанбаатар 10 медаль, БНХАУ-ын ӨМӨЗО-ын Хөлөнбуйр аймаг 4 медаль, Хэнтий аймаг 3 медаль, Дорнод аймаг 6 медаль, Орхон аймаг 1 медаль, Сэлэнгэ 1 медаль, Төв аймаг 1 медаль, Өмнөговь аймаг 1

медаль хүртэн олон авъястан, манлайлагч тодрон наадамчин олны талархал хүлээсэн юм.

### ***Азийн урлагийн 25 дахь удаагийн Олон Улсын үзэсгэлэн зохион байгуулав.***



Азийн урлагийн 25 дахь удаагийн Олон Улсын үзэсгэлэн”-г 2010 оны 9 дүгээр сарын 14-нөөс 17-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгууллаа. Энэхүү Олон Улсын үзэсгэлэнд Ази тивийн 12 орны 160 гаруй мэргэжлийн зураач, уран бүтээлч оролцсон юм. Энэхүү үзэсгэлэнд оролцсон уран бүтээлчдийн бүтээлийг нийтэд сонирхуулах, сурталчлах зорилгоор тэдгээрийн бүтээлээр дэглэсэн үзэсгэлэнг Улаанбаатар хотноо 2 сарын хугацаагаар ажиллуулав. хүртээл болголоо.

### ***Зарим номын сангийн тоног төхөөрөмжийг шинэчилж, номын баяжилт хийв.***

БСШУ-ны сайдын 2010 оны 573 дугаар тушаалаар яам болон нийтийн номын сангуудад 5,3 сая төгрөгийн номын хангалт хийхээр шийдвэрлэсний дээр “Цахим номын

сан” төслийн хүрээнд Боловсролын хөгжлийн хөтөлбөрийн санхүүжилтээр Ерөнхий Боловсролын 37 сургууль, Мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн 6 төвд 387.0 мянган, ам долларын тоног төхөөрөмж, программ хангамж бүхий техник хэрэгслийг нийлүүлж, сургалт зохион байгуулж, хүлээлгэн өглөө. Мөн Азийн сангаас хувийн 40 их, дээд сургууль, Улаанбаатар хотын 9 дүүргийн соёлын төв, 6 уншлагын төвд 12,000 ам долларын номын баяжилт хийх ажлыг зохион байгууллаа.



2010 оны төсвийн хөрөнгө оруулалтаар төв, орон нутгийн Соёл, урлагийн 7 байгууллага (Булган аймгийн номын сан, музей, Говь-Алтай аймгийн "Алтай" чуулга, Увс аймгийн Хөгжимт жүжгийн театр, Хөвсгөл аймгийн Хөгжимт жүжгийн театр, Улаанбаатар хотоос Улсын филармони, Хүүхдийн номын ордон, Соёлын өвийн төв)-ийн үйлчилгээнд зориулж УАЗ-1206 маркийн автомашин олгов.

### ***Зөөврийн номын сангийн үйлчилгээг эхлүүлэв.***

Боловсрол, соёл, шинжлэх ухааны 2010 оны 158 дугаар тушаалаар "Зөөврийн номын сан ажиллуулах аргачлал"-ыг батлан гаргаснаар алслагдсан нутаг дэвсгэр, хотын



захын хорооллын иргэд, хүүхэд багчуудад номын сангийн явуулын үйлчилгээг хүргэх боломж бүрдлээ. 2010 оны хөрөнгө оруулалтаар Хүүхдийн номын ордон, Булган аймгийн төв номын санд, Дэлхийн банкны READ

төслийн шугамаар Монгол Улсын Үндэсний номын санд тус тус автомашин олгон 20 гаруй байгууллага, хороо, сумын 3000 гаруй хүнд 1925 нэрийн номоор үйлчлэв.

### ***Олон улсын уралдаан, наадамд өндөр амжилт гаргасан уран бүтээлчдийг урамшуулан шагнав.***



Оросын Холбооны Улсын Москва хотод зохиогдсон М.Глинкийн нэрэмжит олон улсын дуурийн дуулаачдын уралдаанд нэгдүгээр байр эзэлсэн Дуурь, бүжгийн эрдмийн театрын гоцлол дуучин С.Мөнгөнцэцэгт 29,000,000.0 /хорин есөн сая/ төгрөг, мөн уралдаанд хоёрдугаар байр эзэлсэн Соёл, урлагийн их сургуулийн оюутан Ч.Энхтайванд 24,000,000.0 /хорин дөрвөн сая/ төгрөг, Монакагийн Вант Улсын Монте-Карло хотноо зохиогдсон олон улсын циркчдын "Premere

рампе” наадмаас хүрэл алиалагч хүртсэн уран 9 нугараачдад нийт 34,000,000.0 /гучин дөрвөн сая/ төгрөг, БНХАУ-ын Учао хотод зохиогдсон олон улсын циркчдын наадмаас хүрэл медаль хүртсэн уран 4 нугараачид нийт 34,000,000.0 /гучин дөрвөн сая/ төгрөг, бүгд 121,0 /зуун хорин нэгэн сая/ төгрөгийн мөнгөн шагнал олгуулахаар Засгийн газрын 70 дугаар тогтоолоор шийдвэрлүүлж, уран бүтээлчдэд зохих мөнгөн шагнал олгов.

## **Дөрөв. Шинжлэх ухаан, технологийн талаар**

***Шинжлэх ухаан, технологийн бодлого, эрх зүйн зарим баримт бичгийг боловсруулав.***

Сүүлийн жилүүдэд улс орны хөгжлийн бодлогыг тодорхойлсон стратегийн томоохон баримт бичгүүд болон салбарын Мастер төлөвлөгөө, Монгол Улсад Үндэсний инновацийн тогтолцоог хөгжүүлэх хөтөлбөр зэрэг батлагдсан, шинжлэх ухаан, технологи, инновацийн талаархи дэлхийн болон бүс нутгийн орнуудын хөгжлийн чиг хандлагад өөрчлөлт гарч, мэдлэгт суурилсан эдийн засгийн үндэс суурийг тавих явдал манай орны эдийн засгийн хөгжлийн нэн тэргүүнд шийдвэрлэх асуудлын нэг болоод байгаа бодит шаардлагад нийцүүлэн ШУТ-ийн талаар төрөөс баримтлах бодлогын болон Инновацийн тухай хуулийн төслийг шинэчлэн боловсруулав. ШУТ-ийг эдийн засаг, нийгмийн хөгжлийн шаардлагад нийцүүлэн хөгжүүлж, Монгол Улсын аюулгүй байдал, тогтвортой хөгжлийг хангах, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх гол хүчин зүйл болохуйц түвшинд хүргэх зорилгыг дэвшүүлэн ШУТ-ийг хөгжүүлэх бодлогын зарчим, чиглэлийг тодорхойлж, хэрэгжүүлэх арга хэмжээг томъёолон эдгээр баримт бичгийн төсөлд тусгасан болно.

***Монгол Улсын шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх тэргүүлэх чиглэлийг анх удаа тодорхойлон баталгаажуулав.***

“Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого”, Засгийн газрын 2008-2012 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэл, цөм технологийг улс орны хөгжлийн үе шатны зорилтуудтай уялдуулан тодорхойлж, хөрөнгө, хүчийг төвлөрүүлэхээр тусгагдсан зорилтын дагуу Монгол Улсын шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх тэргүүлэх чиглэл, цөм технологийн жагсаалтын төслийг “Шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэл, цөм технологийг тодорхойлох, тодотгол хийх журам”-д нийцүүлэн боловсруулж, Засгийн газрын 2010 оны 173 дугаар тогтоолоор батлуулан хэрэгжүүлж эхлээд байна. Монгол Улсын шинжлэх ухаан, технологийг 2010-2014 онд хөгжүүлэх тэргүүлэх чиглэлийг дор дурдсанаар манай орны эдийн засгийн тэргүүлэх чиглэлүүдтэй уялдаж байгаа болно:

- ❖ Монгол хүний хөгжил, амьдралын чанар
- ❖ Байгалийн нөөцийн ашиглалт, хамгаалалт
- ❖ Хөдөө аж ахуйн эрчимжүүлэлт
- ❖ Өндөр технологи, мэдээллийн технологийн хэрэглээ.

Эдгээр чиглэлийн хүрээнд 15 цөм /түлхүүр/ технологийг хөгжүүлэн үр дүнг ашиглахад чиглэгдсэн судалгаа, боловсруулалтын ажлыг хэрэгжүүлэхээр тодорхойлоод байна. Ийнхүү улс орны эдийн засгийн хөгжлийг түргэтгэх, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, технологийн аюулгүй байдлыг хангахад чиглэгдсэн шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэл, цөм технологи жагсаалт батлагдан хэрэгжиж эхэлсэн нь

эрдэм шинжилгээний ажлыг нийгэм, эдийн засгийн хөгжлийн зорилтод нийцүүлэх, түүнд зарцуулж байгаа хөрөнгийн үр өгөөжийг дээшлүүлэх нөхцөл бүрдүүллээ.

***Шинжлэх ухаан, технологийн төсөл, сэдэвт ажил хэрэгжүүлэх журмыг шинэчлэв.***

“Шинжлэх ухаан, технологийн төсөл, сэдэвт ажил хэрэгжүүлэх журам”-ыг шинэчлэн боловсруулж, Засгийн газрын 2010 оны 36 дугаар тогтоолоор батлуулав. Журамд эрдэм шинжилгээний ажлын захиалгыг оновчтой болгох, сонголтыг сайжруулах, гүйцэтгэлийн чанар, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, төсөл захиалагч, гүйцэтгэгч, санхүүжүүлэгчдийн хүлээх үүрэг хариуцлагыг өндөржүүлэх зэрэг өнөөгийн тулгамдсан олон асуудлыг шийдвэрлэх арга хэрэгслийг тодорхойлон тусгасан болно. Судалгааны ажил хэрэгжүүлэхэд баримтлах энэхүү журмыг яамны болон холбогдох байгууллагуудын цахим хуудсанд байршуулан эрдэмтэн судлаачид, төрийн байгууллага болон үйлдвэрлэгчид хүргэлээ. Энэхүү журмыг хэрэгжүүлж эхэлснээр төсөл, сэдэвт ажил хэрэгжүүлэх үйл ажиллагааны сонгох, шалгаруулах, гүйцэтгэх, санхүүжүүлэхэд тавих шаардлагыг дээшлүүлэх, эрдэм шинжилгээний ажлын хэрэгжилтийн явц, үр дүнгийн хяналтыг сайжруулах, эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэхэд зарцуулж байгаа хөрөнгийн үр ашгийг нэмэгдүүлэхэд бодитой ахиц дэвшил гарна.

***Шинжлэх ухаан, технологийн салбарын менежментийн шинэчлэлийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлж эхлэв.***

Шинжлэх ухааны академитай хамтран “Шинжлэх ухаан, технологийн салбарын менежментийн шинэчлэлийг хэрэгжүүлэх төлөвлөгөө”-г боловсруулж, “Шинжлэх ухааны салбарыг дэмжих зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2010 оны 174 дүгээр тогтоолоор батлуулан хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулж байна. Энэхүү төлөвлөгөө нь шинжлэх ухааны байгууллагуудын бүтэц зохион байгуулалтыг боловсронгуй болгох, тэдгээрийн үйл ажиллагааны үр өгөөжийг дээшлүүлэх, мэргэжлийн судлаачдын болон лаборатори, туршилтын баазын хангамжийг нэмэгдүүлэх зэрэг олон чухал асуудлыг агуулж байгаа бөгөөд зарим арга хэмжээ амжилттай хэрэгжиж эхлээд байна.

***Оны шилдэг бүтээл шалгаруулах журмыг шинэчлэв.***

Шилдэг бүтээлийг дэвшүүлэх, тэдгээрийг үнэлэх үзүүлэлтүүд, шалгаруулах аргачлал, олгох шагнал зэрэгтэй холбогдсон өөрчлөлтийг шинээр нэмж тусгах замаар “Шинжлэх ухааны оны шилдэг бүтээл шалгаруулах журам”-ыг шинэчилсэн найруулгын хэлбэрээр боловсруулж, БСШУ-ы сайдын тушаалаар батлуулан хэрэгжүүлж эхлэв. Шинэчлэн боловсруулсан журамд шилдэг бүтээлд тавигдах шаардлага, мөн бүтээлийг хэрхэн дүгнэж, байр эзлүүлэх, шагналын хэмжээ ямар байх зэрэг асуудлыг тодорхой тусгасан болно.

***Залуу судлаачдад БСШУ-ы сайдын нэрэмжит грант олгох журмыг батлан мөрдөж эхэллээ.***

Шинжлэх ухааны салбаруудаар жил бүр зохион байгуулагдаж олон арван залуу судлаачдыг хамардаг Хүрэл тогоотын семинарыг өргөтгөн, зохион байгуулалтыг сайжруулж, уг семинарт оролцон шалгарсан судлаачдад Сайдын нэрэмжит грант олгож байх зарчмыг баримтлан одоо мөрдөгдөж байгаа Монголын залуу эрдэмтэн, судлаачдын “Хүрэл тогоотын семинар” эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулах журам”, “Эрдэм шинжилгээний залуу ажилтан нарт сайдын нэрэмжит судалгааны грант олгох журам”-ыг нэгтгэн “Залуу судлаачдад БСШУ-ы сайдын нэрэмжит грант олгох журам”-ыг болгон шинэчилж БСШУ-ы сайдын тушаалаар баталгаажууллаа. Энэхүү журмыг мөрдөж эхэлснээр грантад нэр дэвшигчдэд тавигдах шаардлага нийтлэг болж, шалгаруулалтын шат дамжлага цөөрч, олгох грантын тоо нэмэгдэх ач холбогдолтой юм. Энэхүү журмын дагуу энэ онд 10 залуу судлаачид сайдын нэрэмжит грант олголоо. Мөн шинжлэх ухаан, технологийн салбарын хүний нөөцийг бэхжүүлэх, залуу эрдэмтдийг тогтвор суурьшилтай ажиллуулах, тэдний судалгааны ажлын үр дүнг үйлдвэрлэл, хэрэглээнд нэвтрүүлэх зорилгоор 2010 онд анх удаа БСШУ-ы Сайдын нэрэмжит “Залуу доктор”-ын грант олгохоор зарласны дагуу 25 залуу эрдэмтэн төсөл боловсруулж ирүүлснээс 6 төслийг шалгаруулж тус бүр 10 сая төгрөгийн грант олгов. Шилдэг залуу судлаач болон залуу докторуудад эдгээр



грантыг олгосноор тэдэнд судалгааны ажилдаа улам дадлагажиж үр дүн гаргах, гаргасан үр дүнгээ үйлдвэрлэл, хэрэглээнд нэвтрүүлэх боломжийг олгож байгаа төдийгүй нийт залуу судлаачдад үр дүнтэй ажиллах урам зориг, хүсэл тэмүүлэл өгч байгаа чухал арга хэмжээ юм.

### ***Монгол Улсын нутагт археологи, палентологийн хайгуул, малтлага, судалгаа хийх журмыг шинэчиллээ.***

Монгол Улсын нутагт археологи, палентологийн хайгуул, малтлага, судалгаа хийх журам, Монгол Улсын нутагт археологи, палентологийн хайгуул, малтлага, судалгаа хийх зөвшөөрөл олгох, түүнд хяналт тавих мэргэжлийн зөвлөлийн ажиллах журмыг шинэчлэн боловсруулж БСШУ-ы сайдын 2010 оны 222 дугаар тушаалаар мэргэжлийн зөвлөлүүдийн шинэчилсэн бүрэлдэхүүний хамт батлав. Журмуудад нэмэлт, өөрчлөлт оруулан шинэчлэн боловсруулснаар Монгол Улсын нутагт археологи, палентологийн хайгуул, малтлага, судалгаа хийх зөвшөөрөл олгоход тавигдах шаардлага тодорхой болж, түүх дурсгалын олдворыг хамгаалах, хадгалах нөхцөл сайжирч, хариуцлагын тогтолцоо боловсронгуй болох эрх зүйн орчин бүрдлээ.

### ***Хэрэглээний болон технологийн судалгаа, туршин нэвтрүүлэх ажилд эрдэм шинжилгээний санхүүжилтийн 60 хувийг зарцуулав.***

2010 онд салбарын санхүүжилт өмнөх оныхоос 1,4 тэрбум төгрөгөөр өссөн боловч Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд зааснаас даруй 7.5 дахин доогуур байна.

Суурь судалгаанд зарцуулах санхүүжилт буурч, инноваци, хэрэглээний судалгааны эзлэх хувийн жин өсөв. Инновацийн төслийн санхүүжилтэд 1.3 тэрбум төгрөг зарцууллаа. Хэрэглээний судалгаа болон технологийн судалгаа, туршин нэвтрүүлэх ажилд эрдэм шинжилгээний нийт санхүүжилтийн 60 гаруй хувийг зарцуулсан байна.

### ***Шинжлэх ухааны зарим байгууллагад лабораторийн нарийн багаж төхөөрөм нийлүүлэв.***

Лабораторийн тоног төхөөрөмжийг сайжруулахад 2009 онд 700 сая, 2010 онд 300 сая төгрөг зарцуулсан байна. ШУТ-ийн салбарт 2010 онд батлагдсан 300 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтыг ШУТИС-ийн Ой модны сургалт, судалгааны хүрээлэнд модны даацын бат, бэхийг шалгах төхөөрөмж, ШУА-ийн Хими, хими технологийн хүрээлэнд импульсийг өндөр даралтаар жигдрүүлэгч аппарат, ШУТИС-ийн Хүнс, биотехнологийн сургуульд хүнсний биотехнологийн инкубаторын тоног төхөөрөмж, ХААИС-ийн Мал эмнэлгийн хүрээлэнд пробиотик судалгааны иж бүрэн лабораторийн төхөөрөмж, ЭМЯ-ны харъяа Анагаах ухааны хүрээлэнд цусны ДНХ-ийн нуклеотидийн дараалал тодорхойлох тоног төхөөрөмж гэсэн 5 багцад хуваарилж, худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулав.

Уламжлалт анагаахын шинжлэх ухаан, үйлдвэрлэлийн нэгдлийн Уламжлалт эмийн үйлдвэрийн барилгын ажил дуусах шатандаа явж байна. Энэ үйлдвэр ашиглалтад орсноор монголын уламжлалт эм танг экспортлох, дэлхийд таниулан сурталчлах нөхцөл бүрдэнэ.

### ***Оны шилдэг бүтээлүүдийг тодрууллаа.***

Шинжлэх ухааны салбарт оруулсан хувь нэмэр, ач холбогдол, үйлдвэрлэл, үйлчилгээнд ашиглах боломжийг үндэс болгон тухайн онд үр дүн нь баталгаажсан шилдэг бүтээлийг “Шинжлэх ухааны оны шилдэг бүтээл шалгаруулах журам”-ын дагуу жил бүр шалгаруулан мөнгөн шагналаар шагнаж урамшуулдаг. Шинжлэх ухааны 2010 оны шилдэг бүтээлээр МУИС-ийн багш, доктор П.Зузаан “Байгалын материалын рентгенфлуоресценц, идэвхижлийн шинжилгээний онол, арга зүйн судалгаа” бүтээлээрээ тэргүүлж, 2010 оны шилдэг бүтээлийн шагнал болох 4 сая төгрөг, удаах байруудад ШУТИС-ийн доктор Г.Лхагваагийн “Хүн, хүний хөгжлийн шинэ үзэл баримтлал, энергийн хуулиуд”, Ж.Тэмүүжиний “Шаварлаг эрдсийг боловсруулж гаргасан нанобүтэцтэй материал, түүний хэрэглээ” цуврал бүтээл, Ч.Алтаннарын “Оновчлол ба оновчтой удирдлага”, тусгай байранд Г.Дагвацэрэн, Д.Хишгээ, Ж.Алдармаа нарын “Валмедин” эм, Д.Амарсайханы “Сансраас тандсан болон орон зайн мэдээг боловсруулах нийлмэл арга зүй”, доктор Ц.Аюурзаны “Компаний санхүү” зэрэг бүтээлүүд тус тус шалгарч 1-3 сая төгрөгийн мөнгөн шагнал хүртлээ.

### ***Гадаадын залуу эрдэмтдэд зориулсан зуны сургалтыг зохион байгуулав.***

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмжийн дагуу Монгол судлаач гадаадын залуу эрдэмтдэд зориулсан зуны сургалтыг жил бүр уламжлал болгон явуулдаг бөгөөд 2010 оны зуны сургалтыг 7 дугаар сард зохион байгууллаа. Сургалтын хөтөлбөрт тусгагдсаны дагуу Монгол судлаачдын эрдэм шинжилгээний хурлыг ҮП сарын 8-9-ны өдөр зохион байгуулав. Уг хуралд 6 орны 24 монголч эрдэмтэн, монголын 15

залуу эрдэмтэн оролцож 38 илтгэлийг хэлэлцлээ. Илтгэлүүдээс 1 дүгээр байрт БНХАУ-ын Ланжао хотын Баруун хойдын үндэстний их сургуулийн аспирант Булагийн “Алашаа монгол ардын дуун дахь тэмээн соёл хийгээд, холбогдох зан үйл” илтгэл, 2 дугаар байрт ОХУ-ын Өвөр Байгалийн Багшийн Их сургуулийн багш, доктор Булат Шойнжоновын “Буриад монголчуудын домог өгүүллэгийн тухай” илтгэл, 3 дугаар байрт Унгар улсын Будапештийн гар урлал судлаач, багш Томаш Кийшийн “Монгол эмээлийн хийц” илтгэл тус тус шалгаран сертификат, мөнгөн шагналаар шагнагдаж “Гадаадын шилдэг залуу монголч эрдэмтэн” өргөмжлөлийг хүртлээ. Зуны сургалтыг зохион байгуулснаар монгол судлаач гадаадын эрдэмтдийн залуу халааг бэлтгэх, тэдэнтэй хамтран ажиллах, тэднээр дамжуулан монголын түүх, соёл, өвөрмөц зан заншлыг дэлхийд таниулах боломж улам нэмэгдэж, залуу монголч эрдэмтдийн тоо жилээс жилд өсч байна.

### ***Инновацийн төсөл хэрэгжүүлэх анхны алхам хийлээ.***

Монгол Улсад Үндэсний инновацийн хөгжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд 2010 оноос эхлэн хэрэгжүүлэх инновацийн төслийн сонгон шалгаруулалтыг 2010 оны 6 дугаар сард зарлаж, эрдэм шинжилгэний байгууллага, их сургууль, аж ахуйн нэгж нэгж, иргэдээс эм, эмийн бэлдмэл үйлдвэрлэх чиглэлээр 7, техник, технологийн чиглэлээр 32, хөдөө аж ахуй, биологийн чиглэлээр 7, нийт 46 төсөл ирүүлснийг БСШУ-ы сайдын Шинжлэх ухаан, технологийн салбар зөвлөлөөр хэлэлцэн гаргасан дүгнэлтийг үндэслэн Уламжлалт анагаахын шинжлэх ухаан, технологи, үйлдвэрлэлийн нэгдлийн “Уламжлалт нийлмэл жорын найрлагад суурилсан биологийн идэвхт 21 нэрийн бэлдмэлийн эмнэл зүй, стандарт, технологийг нэвтрүүлэх”, ШУА-ийн Хими, хими технологийн хүрээлэн, “Монос” группийн хамтарсан “Хоёрдогч түүхий эдээс биологийн идэвхтэй бэлдмэл гарган авах нь” зэрэг 6 төслийг сонгон шалгаруулж 437.5 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр шийдвэрлэн холбогдох байгууллагуудтай гэрээ байгуулан ажлыг нь эхлүүлэв. Эдгээр төсөл 2013 он хүртэл хэрэгжих бөгөөд үйлдвэрлэл, үйлчилгээнд тодорхой үр дүнгүүд нэвтэрч, эдийн засгийн үр ашгаа өгөх болно. Түүнчлэн биотехнологи, нанотехнологийн чиглэлээр хэрэгжүүлж байгаа дэвшилтэт технологийн төслүүдийн хэрэгжилтийн явц, үр дүн, санхүүгийн зарцуулалтын байдалтай танилцан дүгнэлт гаргах ажлын хэсэг байгуулан ажиллуулж түүний дүгнэлтийг үндэс болгон 25 төслийг 2010 онд үргэлжлүүлэн хэрэгжүүлэх, 7 төслийг 2009 оноор дуусгавар болгон үр дүнг хүлээн авахаар БСШУ-ы сайдын 2010 оны 172 дугаар тушаалаар шийдвэрлэв.

Манай яам ХХААХҮЯ, ЭМЯ-тай хамтран жил бүр салбарын өмнө тулгамдсан




тодорхой нэг асуудлыг шийдвэрлэхэд хамтран ажиллахаар тохиролцов. Ингэхдээ үр дүн нь богино хугацаанд эдийн засгийн эргэлтэд орж, улс орны хөгжилд хувь нэмэр оруулахуйц инновацийн төслийг сонгож, тухайн судалгаа, инновацийн ажлын үр дүнг байнгын хэрэглээ болгох үйлдвэр, бизнесийн байгууллагатай хамтран хэрэгжүүлэх зорилгоор инновацийн төслийг хамтран хэрэгжүүлэхээр тохиролцож, Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэнгийн “Барилгын дулаалгын хонины ноосон материал үйлдвэрлэх технологи,

тоног төхөөрөмж, жишиг үйлдвэр”, Монос группийн “Хавдрын эсрэг үйлдэл бүхий “Эллипин” шинэ эмийн бэлдмэлийг үйлдвэрлэл болон эмчилгээнд нэвтрүүлэх” төслийг хэрэгжүүлэхэд түншлэлийн гэрээ байгуулж, хамтарч ажиллахаар тохиролцсон нь инновацийн төслийг хамтран санхүүжүүлэх боломжийг олгож, асуудлыг шийдвэрлэх шинэлэг арга хэмжээ болж байна. Эдгээр төслийг хэрэгжүүлэхэд ХХААХҮЯ 100 сая, Монос групп 60 сая, ШУТС 160 сая төгрөгөөр тус тус санхүүжүүлэн хамтран хэрэгжүүлж эхлээд байна.

Төр, их сургууль, эрдэм шинжилгээний байгууллагын оролцоотойгоор хамтран хэрэгжүүлэх 8 инновацийн төслийн саналыг МУИС, СУИС, ЭМШУИС ирүүлснийг БСШУ-ы сайдын Шинжлэх ухаан, технологийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэн шийдвэрлэж, БСШУ-ы сайдын тушаалаар баталгаажуулав. Төслүүдийн хэрэгжилтэд ШУТС-гаас 355 сая төгрөг зарцуулна. Эдгээр төслөөс МУИС-ийн эрдэмтэд Эрдэнэт УУГ-тай хамтран 400 сая гаруй төгрөгийн санхүүжилтээр 4 дэд төслийг хэрэгжүүлэхээр гэрээ байгуулсан нь их сургууль, үйлдвэр, аж ахуйн нэгжийн хамтын ажиллагааг цаашид хөгжүүлэхэд ач холбогдолтой арга хэмжээ боллоо. ЭМШУИС-ийн эрдэмтдийн баг “Чихрийн шижин өвчнийг эсээр эмчлэх нь” инновацийн төслөөр эсийн эмчилгээний аргыг зөвхөн чихрийн шижин эмгэгийн эмчилгээнд ашиглаад зогсохгүй цаашид төрөл бүрийн хавдрууд, ургийн гажигуудын эмчилгээ, нөхөн сэргээлт болон эсийн баяжмалын төрөл бүрийн био-бэлдмэлүүдийг бэлтгэж гаргах бүрэн боломж нээгдэх юм. Энэхүү шинэ технологийг амжилттай нэвтрүүлснээр манай иргэд чихрийн шижин өвчний эмийн бус эмчилгээг эх орондоо хямдхан хийлгэх боломжтой бүрдэнэ.

### ***Оросын Холбооны Улсын Шинжлэх ухааны академийн Сибирийн салбартай хамтран ажиллах Протокол байгуулав.***

Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Оросын Холбооны Улсын



Шинжлэх ухааны академийн Сибирийн салбар хоорондын хамтран ажиллах тухай Протокол байгуулав. Талууд энэхүү Протоколын хүрээнд эрдэм шинжилгээ ажилтан бэлтгэх, хамтарсан үзэсгэлэн зохион байгуулах, археологийн хайгуул, малтлага, угсаатны зүйн судалгаа хийхээр тогтов. Мөн шинэ дэвшилтэт технологийг хөгжүүлэх, хамтарсан судалгааны үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэх зорилгоор “Монгол малын махны чанар, бүтцийн судалгаа, экспортын мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэх технологи”, “Нүүрс боловсруулж, зарим нэр төрлийн бүтээгдэхүүн гарган авах судалгаа, технологи”, “Нядалгааны малын дайвар бүтээгдэхүүнийг гүн боловсруулах технологи”, “Малын тэжээл үйлдвэрлэл- туршилт” төслийг хоёр Тал хамтран санхүүжүүлэхээр боллоо.

### ***“Шинжлэх ухаанд суурилсан хөгжил” сэдэвт зөвлөгөөнийг зохион байгуулав.***

2010 оны 10 дугаар сарын 7-ны өдөр Төрийн ордонд зохион байгуулав. Зөвлөгөөнд яам, агентлаг, эрдэм шинжилгээний байгууллага, их, дээд сургуулийн



сарын 7-ны өдөр Төрийн ордонд зохион байгуулав. Зөвлөгөөнд яам, агентлаг, эрдэм шинжилгээний байгууллага, их, дээд сургуулийн төлөөлөл-60 гаруй төлөөлөгч оролцлоо. Зөвлөгөөнд Монгол Улсын Ерөнхий сайд С.Батболд оролцож манай улсын эдийн засгийн хөгжилд шинжлэх ухаан, технологийн гүйцэтгэх үүрэгтэй холбогдуулан салбарын үр ашигтай үйл ажиллагаа, шинжлэх ухаан, үйлвэрлэлийн холбоог сайжруулахын зэрэгцээ цөөн хүн амтай, эмзэг эдийн засаг бүхий манай улсын хувьд технологийн агууламж өндөртэй, бүс нутаг, улмаар дэлхийн зах зээлд

өрсөлдөхүйц бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд эрдэмтэн, судлаачид онцгой анхаарах, бүх зүйлийг шинээр хийх бус хөгжилтэй орны зарим технологийг нутагшуулан ашиглах нь үр дүнд түргэн хүрэх нэг арга гэдгийг онцолж, шинжлэх ухааны салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, одоогоор боловсруулаад байгаа технологийн бүтээлүүдээс нэвтрүүлэхэд анхаарах чиглэл өглөө.

### ***“Шинжлэх ухаан, технологи-2010” үзэсгэлэн зохион байгуулав.***

Энэхүү үзэсгэлэнг 2010 оны 11 дүгээр сарын 22-24-ний өдрүүдэд Хүүхдийн номын ордонд зохион байгууллаа. Үзэсгэлэнд төрийн болон хувийн өмчийн 60 гаруй эрдэм шинжилгээний байгууллага, их сургууль, аж ахуйн нэгжийн сүүлийн 2 жилийн хугацаанд хийсэн судалгаа, боловсруулалтын ажлын үр дүн болох бүтээгдэхүүн, технологи олон



нийтэд дэлгэн үзүүлж ажлаа тайлагналаа. Энэ жилийн үзэсгэлэнд манай эрдэмтэн судлаачид шинэ соргог бүтээл олныг тавьж үзэгчид, хэвлэл, мэдээллийн анхаарлыг татаж чадсанаараа өмнөх үзэсгэлэнгүүдээс онцлог байв. Үзэсгэлэнгийн үеэр шилдэг бүтээгдэхүүн, технологи шалгаруулж, өргөмжлөл, мөнгөн шагналаар шагналаа. Дарханы Ургамал, газар тариалангийн сургалт, эрдэм шинжилгээний хүрээлэнгийн “Зусах зөөлөн буудайн Дархан-144 сорт” бүтээл тэргүүллээ. Энэ бүтээл нь 2008-2010 онд гүйцэтгэсэн “Үр тарианы таримлын шинэ сорт” ШУТ-ийн төслийн үр дүнд бүтээгдэн

Улсын сорт сорилын комиссын шийдвэрээр Монгол Улсын тариалангийн бүсэд нутагшсан сортоор батлагдсан бөгөөд энэ сорт өмнө нутагшсан Бурятская-34 сорттой адил хугацаанд боловсордог, налалт, үрийн асгаралт, ган, халуунд тэсвэртэй, ургацын чадавхи өндөртэй /33,4 ц/га/, Бурятская-34 сортоос 3,7 ц/га давуу ургацтай.

Удаах байруудад ШУТИС-ийн доктор Ү.Сүхбаатарын “Edubook буюу Зөөврийн компьютер”, АӨХСТ-ийн доктор Б.Сангидоржийн “Харшил оношлох өвөрмөц аллергенүүд ба эмчилгээний аллерген вакцин”, ШУА-ийн Информатикийн хүрээлэнгийн

доктор Ч.Аварзэдийн “Улаанбаатар хотын гэрэлтүүлгийн төвлөрсөн хяналт удирдлагын системийн техник болон программ хангамжийн шийдэл”, МУИС-ийн Мэдээллийн технологийн сургуулийн доктор Ч.Лодойравсалын “Автомашинны байршил илрүүлэгч”, ШУА-ийн Технологийн инкубаторын доктор Ч.Батсүхийн “Хүнсний цуврал бүтээгдэхүүн” шалгарч өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнагдав.

### ***“Эрдэмтдийн үг” цуврал лекцийг эхлүүлэв.***

Шинжлэх ухааны мэдлэгийг түгээн дэлгэрүүлж эрдэмтдийн үгийг олон нийтэд хүргэх нь Монгол орныхоо цаашдын хөгжил, дэвшлийг хангах, хүн ардын оюуны амьдралыг төлжүүлэх, соён гэгээрүүлэх, иргэний боловсролыг дээшлүүлэхэд чухал ач холбогдолтой юм. Иймээс БСШУЯ, ШУА-аас “Эрдэмтдийн үг” мэдлэг түгээх, хөгжлийн тухай цуврал лекц зохион байгуулахаар шийдвэрлэж, эхний лекцийг “Монголоо хөгжүүлэхийн тулд эхлээд Монголоо мэдэцгээе” сэдвээр зохион байгууллаа. Энэхүү лекцийг Олон улсын монгол судлалын холбооны ерөнхийлөгч, Монгол Улсын хөдөлмөрийн баатар, академич Ш.Бира уншлаа. Эрдэмтдийн үг лекцийн талаар Монгол телевиз, Монголын радиогоор 4 удаа өргөн нэвтрүүлэг явагдаж олон түмэнд хүрсэн болно. “Эрдэмтдийн үг” цувралын 2 дахь удаагийн лекцийг ХААШУА-ийн гишүүн, шинжлэх ухааны доктор, профессор Д.Минжигдорж “Мал аж ахуй хөгжлийн тулгамдсан асуудал” сэдэвт лекц уншаад байна.

### ***Электрон номын сан байгуулан ажиллууллаа.***



Шинжлэх ухаан, технологийн сангийн дэргэд электрон номын сан нээж ажиллууллаа. Шинжлэх ухааны мэдээллийн архивт цаасан хэлбэрээр хадгалагдаж байсан манай эрдэмтэн, судлаачдын хийж гүйцэтгэсэн шинжлэх ухаан, технологийн төслийн үр дүнгийн тайлан, бусад мэдээллийг цахим хэлбэрт оруулан нийтийн хүртээл зорилгоор бий болгосон энэхүү номын сан нь судалгаа, шинжилгээний үр дүнг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэх, олон нийтэд танилцуулах, сурталчлахад чухал ач холбогдолтой арга хэмжээ боллоо. Энэ номын сан нь шинжлэх ухааны дэлхийд нэр хүндтэй сэтгүүл унших, эрдэмтэн судлаачдын бүтээлтэй танилцах нөхцөл боломжоор хангагдсан уншлагын танхимтай юм.

### ***Гадаад оронтой хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж байна.***

БСШУЯ-наас ОХУ-ын Суурь судалгааны сантай хамтран 2010 оноос эхлэн 15 төсөл, ОХУ-ын Хүмүүнлэгийн шинжлэх ухааны сантай хамтран 11 төсөл хэрэгжүүлэх, мөн эрдэм шинжилгээний 3 хурал зохион байгуулах, 5 хайгуул, судалгаа хийх, 1 бүтээл туурвихаар харилцан тохиролцож БСШУ-ы сайдын 2010 оны 220 дугаар тушаалаар баталгаажуулан, эдгээр ажлыг хэрэгжүүлэх гэрээг байгуулснаар хамтарсан судалгааны ажлууд хэрэгжиж эхлээд байна. 2010 онд Шинжлэх ухаан, технологийн сан (ШУТС)-гаас эдгээр төсөлд 100 сая төгрөгийн санхүүжилт олгов. Мөн ШУТС-гаас Тайваны ШУТ-ийн хороотой хамтран 2010 оноос эхлэн хэрэгжүүлэх төслийн сонгон шалгаруулалтыг зохион

байгуулж, эрдэм шинжилгээний 3 төсөл хэрэгжүүлэх, 1 симпозиум зохион байгуулахаар шийдвэрлэсний дагуу гэрээ хийлээ. Хамтын судалгааны хүрээнд хийсэн археологийн хайгуул, малтлагаар энэ онд том, жижиг нийлсэн 8000 гаруй олдвор олоод байна. Тухайлбал, Монгол Улсын их сургуулийн эрдэмтэд Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Улаанзуухаас хүрлийн үеийн зарим ховор олдвор олжээ. Эдгээрийн заримыг дараах зургаас үзнэ үү.



“Улаан зуух”-аас илэрсэн археологийн олдворууд

Мөн Нүүдлийн Соёл Иргэншлийг Судлах Олон Улсын Хүрээлэн 2010 онд “Эртний нүүдэлчдийн бичиг үсгийн дурсгалын хайгуул судалгаа” төслийн хүрээнд хоёр шинэ дурсгал олсон байна.



Шинэ олдсон Хятаны их бичигт гэрэлт хөшөө

**Нэгдүгээрт,** Дорноговь аймгийн Эрдэнэ сумын нутаг Бүлээн хэмээх газраас Хятаны их бичигт гэрэлт хөшөөг анх оллоо. 183x53 см хэмжээтэй хөшөөнд 7 мөр Хятан их бичгээр бичиж, наран зүг харуулан 1058 онд босгосон энэ хөшөө нь бүрэн тайлж чадаагүй Хятан их бичгийг уншихад цоо шинэ хэрэглэгдэхүүн болно гэж судлаачид үзэж байна. Тусгайлан байгуулсан хятан их бичигт гэрэлт хөшөө манай нутгаас урьд олоогүй байсны хувьд шинэ ховор дурсгал юм.



Шинэ олдсон үйсэн номууд

**Хоёрдугаарт;** Булган аймгийн Дашинчилэн сумын нутаг Хар бух балгаснаас 60 орчин хуудас хусны үйсэн дээр бичсэн ном илрүүлэн олоод байна. Эдгээр үйсэн номууд нь XVII зууны эхэн үед хамаарах бөгөөд тухайн үед монголд бурхны шашин хэрхэн дэлгэрч, Түвд хэлнээс ном орчуулж, бас монгол лам нар өөрсдөө монгол хэлээр зохиол туурвин, тарааж байсныг гэрчлэх баримт юм. Үйсэн ном бол монголчуудын ном хэвлэлийн

урлагийн онцгой, биеэ даасан нэгэн төрлийн хувьд маш үнэ цэнтэй дурсгал юм. Үйсийг хэрхэн боловсруулж, цаас мэт нимгэн, бас уян хатан болгон дээр ном бичиж байсан технологийг одоо болтол бүрэн тайлж чадаагүй байгаа өнөөгийн нөхцөлд уг дурсгал нь судалгааны шинэ хэрэглэгдэхүүн болж байгаагаараа онцгой ач холбогдолтой. Тийнхүү Монгол-Японы эрдэмтэд нэг хэсэг үйсэн номыг үрэгдэх аюулаас аварч чадсан нь энэ төслийн нэг чухал үр дүн болсон байна.

## ***Манжуурын үзэсгэлэнд оролцов.***

БНХАУ-ын Манжуур хотод 2010 оны 7 дугаар сард зохион байгуулагдсан Монгол-Хятад-Оросын “Шинжлэх ухаан, үйлдвэрлэл-өндөр технологи” үзэсгэлэн яармагт манай улсын сургалт, үйлдвэрлэл, шинжлэх ухааны 16 байгууллагын 30 гаруй төлөөлөгчийг оролцуулж, судалгаа, шинжилгээний ажил, бараа бүтээгдэхүүнээ танилцууллаа. Төлөөлөгчид БНХАУ, ОХУ-ын ижил чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагуудтай хамтран ажиллах, аргачлал солилцох, хамтарсан судалгаа хийх, мэргэжилтэн солилцох зэрэг асуудлаар хамтын ажиллагааны гэрээ хэлэлцээр байгуулав. Түүнчлэн Монгол орны “Үлэг гүрвэл, тэдгээрийн орчин” сэдэвт үзэсгэлэнг Испани улс, БНХАУ-ын “Шанхайн Экспо-2010”, ОХУ-ын Улаан-Үүд хотноо зохион байгуулсан Дэлхийн монголчуудын чуулга уулзалтын үеэр тус тус гаргаж, Палеонтологийн шинжлэх ухааны ололт амжилтыг сурталчиллаа.

## ***Олон улсын шагнал хүртэв***

ШУА-ийн Палеонтологийн төвийн захирал, академич Р.Барсболд эртний амьтан ургамлын судалгааны олон улсын хүрээнд шинэ чиглэл, үзэл баримтлал, үндэслэл гаргаж, сээр нуруутны палеонтологид онолын ач холбогдолтой томоохон хувь нэмэр оруулсан эрдэмтэнд олгодог А.С.Ромер, Ж.Ж.Симпсоны нэрэмжит шагналыг хүртлээ. Гуравдагч орны (TWAS) академиудын залуу эрдэмтний 2010 оны шагналыг химийн салбарт ШУА-ийн Хими, хими-технологийн хүрээлэнгийн ЭША доктор А.Минжигмаа, физикийн салбарт ШУА-ийн Физик технологийн хүрээлэнгийн ажилтан доктор Ч. Содбилэг нар тус тус хүртлээ. Ийнхүү манай эрдэмтдийн бүтээлийн чанар чансааг олон улсын хэмжээнд өндөр үнэллээ.

## **Тав. Санхүү, хөрөнгө оруулалтын талаар**

***Салбарын санхүүгийн нэгдсэн тайлан балансыг гаргаж стандарт үнэлгээ авлаа.***

БСШУ-ы салбарын байгууллагуудын 2009 оны санхүүгийн тайлан балансыг нэгтгэж түүнд эдийн засгийн шинжилгээ хийв. Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын багцын санхүүгийн байдлын 2009 оны тайлангаар нийт 2191 нэгжийн үлдэгдлийг тусгав. Салбарын нийт хөрөнгө 1,181,555.0 сая төгрөг болж 2008 оноос 724,727.3 сая төгрөгөөр өслөө. Нийт хөрөнгийн 12 хувь буюу 138,621.7 сая төгрөгийг эргэлтийн хөрөнгө, 88 хувь буюу 1,042,933.2 сая төгрөгийг үндсэн хөрөнгө эзэлж байна. Нийт авлага өмнөх оноос 11,090.6 сая төгрөгөөр өссөн үзүүлэлттэй гарав. Авлагын 98 хувь буюу 66,609.5 сая төгрөгийг Төрийн сангийн байгууллагуудын авлага эзэлж байна. Нийт бараа материалын 13 хувь нь түүхий эд материал, 81.5 хувь нь хангамжийн материал, 20.2 хувь нь мал амьтад, 3.5 хувь бусад бараа материал байна. Засгийн газрын 2008 оны 167 дугаар тогтоолыг үндэслэн Сангийн сайдын 2009 оны 135 дугаар тушаалаар батлагдсан аргачлалын дагуу 2009 онд үндсэн хөрөнгөнд дахин үнэлгээ хийж, үндсэн хөрөнгийг бүртгэлд тусгасан болно. Салбарын нийт үндсэн хөрөнгө 1,042,933.2 сая төгрөг болж байна. Нийт хөрөнгийн 628.4 сая төгрөгийг биет бус хөрөнгө эзэлж байна. Үндсэн хөрөнгийн анхны үнэ 1,959,526.0 сая төгрөг, элэгдэл 916,592.8 сая төгрөг байна. Нийт өглөгийн 88 хувь буюу 11,227.3 сая төгрөгийн өглөгийг харъяа байгууллагуудын өр эзэлж байна. Өрийг төрлөөр авч үзвэл ихэнх өглөг буурсан бөгөөд бусад зардлын тооцооны

өглөг 992.7 сая төгрөг, урьдчилж орсон орлого 3,413.2 сая төгрөгөөр өссөн байна. Үндэсний аудитын газраас БСШУ-ы салбарын 2009 оны санхүүгийн тайлангийн нэгтгэлд хийсэн үнэлгээгээр 2008 оны үр дүнгээ бататгаж стандарт үнэлэлт авлаа.

### ***Салбарын 2010 оны урсгал болон хөрөнгийн зардлын төсвийн хэрэгжилтийг зохион байгуулав.***

Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль болон Нэгдсэн төсвийн тухай хууль, Боловсролын тухай хууль, Соёл, урлагийн тухай хууль, Шинжлэх ухаан, технологийн тухай хууль, Засгийн газрын үйл ажиллагааны 2008-2012 оны хөтөлбөр, Нийгэм, эдийн засгийг 2010 оны хөгжүүлэх үндсэн чиглэл, Боловсролын мастер төлөвлөгөө, 2010 оны төсвийн тухай хуулийн хүрээнд 2010 оны төсвийн хэрэгжилтийг зохион байгуулж ажиллалаа.

Ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэг, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүдийн хүүхдийн болон дотуур байрны хоол, үдийн цай, тэтгэлэгийн хэмнэлтийг зарцуулах тухай Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Сангийн сайдын 560/276 дугаар хамтарсан тушаалын дагуу БСШУЯ-ны хэмнэлтийн дансанд 8,5 тэрбум төгрөгийг нэгж байгууллагуудаас төвлөрүүлж, салбарын хэвийн үйл ажиллагааг хангуулах зорилгоор өр төлбөрийг барагдуулах ажилд 5,2 тэрбум төгрөг зарцууллаа.

Засгийн газрын 2010 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн ээлжит хуралдаанаар улсын хэмжээнд болон Говь-Алтай аймагт гарч байгаа вирус гепатит өвчний дэгдэлт ихсэж байгаа<sup>1</sup> болон Улаанбаатар хотын гэр хорооллын сургууль, цэцэрлэг, бусад аймагт өвчлөл их гарч байгаа учир холбогдох арга хэмжээг яаралтай авахыг Эрүүл мэндийн болон Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдад даалгасан. Үүний дагуу Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Сангийн сайдын 2010 оны 533/292 дугаар хамтарсан тушаалын дагуу боловсролын байгууллагын орчины эрүүл ахуйг хангах ажлыг эрчимжүүлэх, гар ариутгалын бодис, төхөөрөмжийг суурилуулах зардлыг санхүүжүүлэхэд 950.6 сая төгрөгийг боловсролын салбарын хэмнэлтийн данснаас зарцууллаа.

Боловсролын тухай хуулийн 43.1.4, 43.1.7 дугаар заалтад тус тус заасны дагуу хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай тасралтгүй таван жил ажилласан болон тэтгэвэртээ гарах багш, ажилтнуудад олгох тэтгэвэр тэтгэмжийн зардалд сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудад 952,3 сая төгрөг, ерөнхий боловсролын сургуулийн салбарт 4322,5 сая төгрөг, нийт тус хуулийн заалтын дагуу 5274,8 сая төгрөгийг төлөвлөж олгууллаа.

“Улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшил олгох тухай” Засгийн газрын 2008 оны 54 дүгээр тогтоолоор ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэгийн багш, ажилтнуудын үр дүнгийн урамшуулалд 15,1 тэрбум төгрөгийг улирал бүр Боловсрол, соёл, шинжлэх ухааны болон Сангийн сайдын хамтарсан тушаал гаргаж ерөнхий боловсролын сургуулийн 42730 ажилтан, үүнээс 25946 багш, хүүхдийн цэцэрлэгийн 16462 ажилтан, үүнээс 4098 багшид зохих урамшууллыг олгов.

---

<sup>1</sup> Вирус гепатит А өвчин Улаанбаатар хот, Хэнтий, Говь-Алтай, Дорноговь, Өвөрхангай, Дархан-Уул, Хөвсгөл аймагт голомтлон гарч байна. Он гарсаар Улаанбаатар хотод энэ өвчнөөр 380 хүүхэд өвчилсөн. Говь-Алтай аймагт энэ өвчний 384 тохиолдол бүртгэгдсэний 272 нь 9 дүгээр сарын 1-нээс 10 дугаар сарын 13-ны хооронд гарсан байна.

### Тэтгэвэр, тэтгэмжид зарцуулсан мөнгө (сая.төг)



### Үр дүнгийн урамшуулалд зарцуулсан мөнгө (сая.төг)

Улирал	Хүүхдийн цэцэрлэг	Ерөнхий боловсролын сургууль	Хүснэгт 1
			Нийт
1 улирал	3,765.3	1,275.2	5,040.5
2, 3 улирал	3,768.3	1,275.2	5,043.5
4 улирал	3,768.3	1,275.2	5,043.5

Сургалтын төрийн сангийн их, дээд сургуулийн суралцагчдад зориулсан 2010 оны 39,0 тэрбум төгрөгийн гүйцэтгэлийг хангууллаа. Дотоодын оюутан, магистрант, докторантад 3,8 тэрбум төгрөг, Засгийн газрын гэрээгээр гадаадад суралцагчдад 5,5 тэрбум төгрөг, зарим суралцагч (нэн ядуу, малчин, 3 суралцагч)-ын зардалд зориулж 10,0 тэрбум төгрөг, оюутны замын зардалд 0,6 тэрбум төгрөг, сумдад төрийн захирагааны ажилтан бэлтгэх зардалд зориулж 0,3 тэрбум төгрөг, Төрийн албан хаагчийн нэг хүүхдийн гэр бүлээс суралцагчдын зардалд 8,0 тэрбум төгрөг, төрийн бус өмчийн МСҮТ-ийн суралцагчдын зардалд 4,8 тэрбум төгрөг, МСҮТ-д суралцагчдад сар тутам тэтгэлэг олгох зардалд зориулж 6,2 тэрбум төгрөг тус тус төлөвлөж зарцууллаа.

2010 онд 10630 оюутны орон нутагтаа ирж очих замын зардлыг төрөөс хариуцахад 393,8 сая төгрөгийн санхүүжилт хийлээ.

Боловсролын тухай хуулийн 40.1-д “Төрийн өмчийн боловсролын сургалтын байгууллагыг тогтмол болон нормативт зардлаар санхүүжүүлнэ”, Засгийн газрын 2008 оны 49 дүгээр тэмдэглэлд “Үүсгэн байгуулагчийн хувьд хариуцах төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагын тогтмол зардал, хөрөнгө оруулалт болон нэг удаагийн мөнгөн тэтгэмжийг 2009 оноос эхлэн жил бүр улсын төсөвт тусган санхүүжүүлж байх” гэсэн заалтуудыг үндэслэн 2010 онд төрийн өмчийн 24 их, дээд сургуулийн тогтмол зардалд шаардагдах 4,0 тэрбум төгрөг, багш нарын тэтгэвэрт гаргахад нь олгох нэг удаагийн тэтгэмжид 504,0 сая төгрөг тус тус зарцууллаа.

2011 онд Хүний хөгжил сангаас “Хишиг хувь хүртээх” зориулалтаар Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа их, дээд сургууль, коллежийн өдрийн ангид суралцаж байгаа 150 гаруй мянган оюутны сургалтын төлбөрт 82,5 тэрбум төгрөг зарцуулахаар Монгол улсын Засгийн газрын тогтоолоор батлууллаа.

***Боловсролын салбарын байгууллагын төсвийн төлөвлөлтөд баримтлах дундаж нормативуудыг шинэчлэн батлуулав.***

Монгол Улсын “Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль”-ийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2 дах заалт, “Боловсролын тухай хууль”-ийн 40 дүгээр зүйлийн 40.2, 40.3 дахь заалт, “Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль”-ийн 23 дугаар зүйлийн 23.1.1, 23.1.2 дахь хэсгийг тус тус үндэслэн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн бага, дунд, ахлах анги, мэргэжлийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын нэг хүүхдэд ногдох хувьсах зардлын дундаж норматив, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын дотуур байрны хувьсах зардал, ерөнхий боловсрол, мэргэжлийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын дотуур байранд амьдрах нэг хүүхдийн хоногийн хоолны зардлын хэмжээ батлах тухай Засгийн газрын 2010 оны 12 дугаар сарын 29-ны өдрийн 342 дугаар тогтоолоор батлууллаа. Шинэчилсэн тогтоолд Төрийн албан хаагчдын цалин хөлсийг 2010 оны 10 дугаар сараас 30 хувь нэмэгдүүлсэн Засгийн газрын 2010 оны 239 дүгээр тогтоолоор батлагдсан цалин хөлсний өсөлт, бараа үйлчилгээний зардлын сүүлийн хоёр жилийн үнийн өсөлтийг одоогийн зах зээлийн үнэ ханшаар тооцоолж гаргасан зэрэг өөрчлөлтүүдийг оруулан тооцсон болно.

1. Сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхэд нэг хүүхдэд ногдох хувьсах зардлын дундаж нормативыг тогтоолоо. Сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхэд зарцуулах хувьсах зардлын нормативийг цэцэрлэгт ажиллах нийт ажиллагчдын цалинг 2010 оны 10 сараас нэмэгдүүлсэн Засгийн газрын 2010 оны 239 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтад “Сургуулийн өмнөх болон бага дунд боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагуудын төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн доод жишиг ТҮБД-4 “-т заасан сүлжээний цалингаар тооцож түүнээс бодогддог мэргэжлийн зэрэг, орон нутгийн нэмэгдэл, ур чадварын нэмэгдэл гэх мэт нэмэгдэл хөлс, нэмэгдлүүдийг багтаан цалингийн зардал, ажил олгогчийн төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг тооцоолон гаргалаа. Энэ нь Засгийн газрын 2009 оны 7 дугаар сарын 1-ний өдрийн 190 дүгээр тогтоолд заасан нормативаас 30 гаруй хувиар өсч байгаа бөгөөд аймгийн төвөөс бусад сумын цэцэрлэгт 617.5 мянган төгрөг, аймгийн төвийн цэцэрлэгт 503.0 мянган төгрөг, нийслэлийн цэцэрлэгт 499.7 мянган төгрөг болж байна.

Бараа үйлчилгээний бусад хувьсах зардалд бичиг хэрэг, шуудан холбоо, албан томилолт, хичээл практик, эм, нормын хувцас, цэвэрлэгээний материал, төлбөр хураамж болон бусад урсгал засвар, биеийн тамир, урлагийн арга хэмжээ, шагнал урамшуулал зэрэг зардлуудыг багтаан 2009, 2010 оны хэрэглээний үнийн индексийн өсөлтөөр нэмэгдүүлэн тооцоход нэг хүүхдэд ногдох зардал дундажаар 40.2 мянган төгрөг болов. Төлөвлөлтийн суурь бүлэг дүүргэлтийг байршлаас нь хамааруулан 20-28 байхаар тооцооллоо.

2.Бага, дунд боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчдад зарцуулах хувьсах зардлын дундаж нормативыг тогтоов. Бага, дунд боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид зарцуулах хувьсах зардлын дундаж нормативт багшийн цалингийн зардал, ажил олгогчийн төлөх нийгмийн даатгалын шимтгэл, бараа үйлчилгээний бусад хувьсах зардлыг багтаан ЕБС-д бага, дунд боловсрол эзэмшүүлэхэд зарцуулах багшийн цалингийн зардлыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2006 оны 236, 2007 оны 298, 2009 оны 301, 2010 оны 201 дүгээр тушаалуудаар батлагдсан сургалтын төлөвлөгөөнд үндэслэн тооцсон болно.

Сургалтын төлөвлөгөөгөөр бүлэгт заах ёстой нийт цагаас, тухайн бүлэгт стандартыг хангахад хэдэн багш шаардлагатайг тооцож, бүлгийн цалингийн зардлыг төлөвлөв. Нэг талаас төлөвлөлт зөв, нөгөө талаас бүлгийг журамд зааснаар зохион байгуулж, хичээлийн хуваарийг сургалтын төлөвлөгөөний дагуу зохиосон бол багшийн цалингийн эх үүсвэр, цалингийн зардал хоёр ойролцоогоор тэнцэх ёстой юм.

Засгийн газрын 2010 оны 239 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтад заасан үндсэн цалингаар тооцоход баг, сум, аймаг, нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн нэг хүүхдэд ногдох багшийн цалингийн зардал дунджаар 224.2 мянган төгрөг болов. Багшийн цалингийн зардлын дээд хязгаар багийн бага сургуульд 358.3 мянган төгрөг, доод хязгаар нийслэлийн бүрэн дунд сургуульд 153.2 мянган төгрөг болж байна. Бараа, үйлчилгээний бусад хувьсах зардлыг Үндэсний статистикийн хорооноос гаргасан өргөн хэрэглээний барааны үнийн өсөлтийг одоогийн зах зээлийн үнэ ханштай харьцуулан тооцоход нэг хүүхдэд ногдох зардал дунджаар 16.4 мянган төгрөг боллоо.

3. Ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын дотуур байрны нэг хүүхдэд зарцуулах хувьсах зардлын дундаж нормативыг батлуулав. Дотуур байранд амьдрах нэг хүүхдэд зарцуулах хувьсах зардлын норматив нь цалингийн зардал, ажил олгогчийн төлөх нийгмийн даатгалын шимтгэл, бараа үйлчилгээний бусад хувьсах зардлаас бүрдэнэ. Дотуур байрны цалингийн зардалд дотуур байрны хүмүүжүүлэгч багш, тогооч, гал тогооны туслах, манаач, жижүүр, үйлчлэгчийн цалинг Засгийн газрын 2010 оны 239 дүгээр тогтоолоор батлагдсан үндсэн цалин, нэмэгдэл, нэмэгдэл хөлсийг тооцон төлөвлөхөд дунджаар 199.5 мянган төгрөг болж байна. Дотуур байрны бусад хувьсах зардалд зөөлөн эдлэл солих, ариутгалын бодис цэвэрлэгээний материал, дотуур байрны урсгал засвар, эмийн зардал зэргийг багтааж Үндэсний статистикийн хорооноос гаргасан өргөн хэрэглээний барааны үнийн өсөлтийг одоогийн зах зээлийн үнэ ханштай харьцуулан тооцоход нэг хүүхдэд ногдох зардал дунджаар 13.3 мянган төгрөг болов.

4. Мэргэжлийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын нэг суралцагчид зарцуулах хувьсах зардлын дундаж нормативыг тогтоов. “Боловсролын тухай” хуулийн 40.3 дахь хэсэг, “Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай” хуулийн 23.1.1, 23.1.2 дахь заалтыг үндэслэн МСҮТ-ийн боловсролын үйлчилгээний төсвийн төслийг боловсруулахад шаардагдах “Мэргэжлийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж норматив”-ыг тооцохдоо 2010 оны 10 дугаар сарын 1-ээс Төрийн албан хаагчдын цалинг 30 хувиар нэмэгдүүлэхээр тооцсон, 2010 оны батлагдсан төсвийг Үндэсний статистикийн хорооноос гаргасан хэрэглээний үнийн улсын индексийг 2010 оны 5 дугаар сарыг өмнөх оны мөн

үетэй харьцуулсан харьцаагаар буюу 11.6 хувиар өсгөн, дунджаар 476.8 мянган төгрөг байхаар тооцсон.

5. Дотуур байрны хүүхдийн хоолны зардлын нормативыг шинэчлэв. Ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын дотуур байрны хүүхдийн хоногийн хоолны зардлын нормативыг 2008 оноос хойш өсгөх эдийн засгийн боломж бололцоо бүрдэхгүй, төсвийн орлогын хүрэлцээ дутмаг байсан. Дотуур байрны хүүхдийн хоолны нормативыг хүнсний барааны зах зээлийн дундаж үнийн өсөлтөөр тооцоход 6-10 насны хүүхдийн хоолны зардалд хоногт 1713.0 төгрөг, 11-14 насны хүүхдийн хоолны зардалд 1893.0 төгрөг, 15-19 насны хүүхдийн хоолны зардалд 2091.0 төгрөг зарцуулахаар байна. Хоолны зардлыг төлөвлөх, хуваарилах, зарцуулахдаа насаар нь ангилах боломжгүй тул дундажлан 6-19 насны хүүхдийн хоногийн хоолны зардлын дунджийг тооцоход нэг хүүхдэд 1932 төгрөг зарцуулахаар байна. Улсын төсвийн орлогын бүрдэлт боловсролын хэрэгцээг хангаж дийлэхгүй байгаа одоогийн нөхцөлд хүүхдийн хоногийн хоолны илчлэгийн 80 хувийг улсын төсвөөс хангахаар нормативыг тооцож хоногт нэг хүүхдэд 1545 төгрөг зарцуулахаар 2011 оны төсвийн төслийг боловсруулж батлуулсан болно.

### ***Салбарын төсөв, санхүүгийн уялдаа холбоог сайжруулах зорилгоор бүртгэлийн цахим тогтолцоог бий болгов.***

Энэхүү бүртгэлийн цахим системийг онлайн /веб зохиох/ хэлбэрт оруулан нийт ажилтан, албан хаагчид ашиглах боломжтой болгож, мэдээллийн санг баяжуулах үйл ажиллагааг тасралтгүй явууллаа. Боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарын 16502 ажилчдын мэдээлэл /овог, нэр, ажилласан жил, регистрийн дугаар, цалингийн шатлал, тэтгэвэр тэтгэмж авч байсан эсэх/-ийг нэмж бүртгэн нийт 26002 ажилчдын мэдээлэл, 764 сургуулийн сурагчдын мэдээлэл /сургууль тус бүрээр суралцдаг сурагчдын тоог анги тус бүрээр, бүлгийн тоо/-ийг нэмж бүртгэн нийт 2298 сурагчийн мэдээлэл, шинээр МСҮТ-ийн 9787 сурагчийн мэдээлэл /анги бүлэг, овог нэр, нас хүйс, регистрийн дугаар/, МСҮТ болон их, дээд сургуулийн мэргэжлийн индексийн 900 мэдээлэл /салбар, салбарын код, мэргэжлийн түвшин, мэргэжлийн чиглэл/, барилгын хөрөнгө оруулалтын 2010 оны төсвийн хууль, 2010 оны төсвийн хуулийн нэмэлт, өөрчлөлт, 2011 оны хуулийн хавсралтад баталсан 299 барилгын 498 мэдээлэл /төсөл арга хэмжээний нэр, хүчин чадал, төсөв өртөг, тухайн онд санхүүжих дүн, хэрэгжүүлэх хугацаа, гүйцэтгэгч, гэрээний дүн, ажлын явц/, барилгын санхүүжилтийн 322 мэдээлэл /санхүүжсэн дүн, огноо/, 203 барилгын их засварын хөрөнгө оруулалтын мэдээлэл /төсөл арга хэмжээний нэр эх үүсвэр, төсөвт өртөг, гүйцэтгэгч, гэрээний дүн, ажлын явц/, барилгын 97 хүсэлт шинээр нэмж нийт 510 барилгын хүсэлтийн мэдээлэл /хүсэлтийн нэр, дүн, огноо, хүсэлт гаргагч, одоогийн байдал, шийдвэрлэсэн байдал/, их засварын 294 хүсэлт шинээр нэмж нийт 640 их засварын хүсэлтийн мэдээлэл, тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтын мэдээлэл бүхий өгөгдлийн сан бүрдүүлэв. Энэхүү цахим санг Яамны шинэчилсэн цахим хуудас ашиглалтад орох үед нийтэд ашиглах боломж бүрдэнэ.

2010 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгасны дагуу Улсын төсвийн болон гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн барилга угсралтын 97, их засварын 196, тоног төхөөрөмжийн 78 тендерийн нэр, дугаар, үнэлгээний хороо байгуулагдсан огноо, тендер зарласан огноо, төсөвт өртөг, эх үүсвэр, ХАА-нд мөрдөх журам, гэрээний дүн зэрэг нийт 371 бичлэг мэдээлэл, үнэлгээний хорооны гишүүдийн

617 бичлэг мэдээлэл, тендерт оролцсон компаний үнийн санал, тендерийн баталгаа, шалгарсан болон шалгараагүй оролцогчдод хүргүүлсэн бичгийн агуулга, огноо зэргийг агуулсан 761 бичлэг мэдээллийн сан бүрдэв.

***Салбарын төсвийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, шинэ барилга, өргөтгөл, их засварын ажлыг гүйцэтгэх үйл ажиллагааг зохион байгууллаа.***

Боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарын 2010 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан сайдаар батлуулж хэрэгжүүлэв. Төлөвлөгөөний дагуу 50 барилга угсралтын ажлын гүйцэтгэгч шалгаруулах тендер зарлаж 49-ийн нь гүйцэтгэгчийг тодруулан ажлыг нь эхлүүлж, 1 барилгын ажлын гүйцэтгэгчийг шалгаруулах ажил хийгдэж байна. Салбарын эх засварын ажлуудыг аймаг, нийслэлийн Засаг дарга нар болон байгууллагад нь эрх шилжүүлэн гүйцэтгүүлж нийт 201 сургууль, цэцэрлэг, соёлын төв, музей, дотуур байр, спорт заал, мэргэжил сургалтын төв, шинжлэх ухааны байгууллагуудын барилга байгууламжийг бүрэн засварлаж дуусгав. Мөн Азийн хөгжлийн банкны “Боловсролын хөгжлийн хөтөлбөр” төслийн хөрөнгөөр 10 их засварын ажил, Дэлхийн банкны “Бүх нийтийн боловсролыг үр дүнд түргэн хүргэх санаачилга” түншлэлийн төслөөс 32 их засварын ажлын гүйцэтгэгч тодруулах тендер зарлаж гэрээ байгуулж ажлыг нь бүрэн дуусгаад байна.

Одоогийн байдлаар 45,8 тэрбум төгрөгийн санхүүжилт Монгол Улсын Төрийн сан дахь БСШУЯ-ны хөрөнгө оруулалтын данснаас хийгдээд байна. Энэ нь нийт 75,4 тэрбум төгрөгийн 61.0 хувь болж байна. Харин хөдөө, орон нутагт эрх шилжүүлсэн 27,0 тэрбум төгрөгийг хасаж тооцвол (48.4 тэрбум төгрөг) 95.0 хувийн санхүүжилтийн гүйцэтгэлтэй байгаа ба нийт 71,8 тэрбум төгрөгийн санхүүжилт хийгдээд байгаа нь улсын хэмжээнд салбарын санхүүжилт 95.0 хувьтай байна. Мөн барилга угсралтын ажлын гүйцэтгэл 90.0 хувьтай, их засварын ажлын гүйцэтгэлийн хувь 100.0 хувьтай байна. Улсын төсвийн хөрөнгөөр 2010 онд ерөнхий боловсролын 11 сургуулийн хичээлийн байрыг шинээр ашиглалтад оруулж, суудлын тоог 3848-аар, 9 дотуур байрыг ашиглалтад оруулж, орны тоог 1045-аар, 29 цэцэрлэгийн барилгыг ашиглалтад оруулж, орны тоог 2628-аар, 14 соёлын төвийн барилгыг ашиглалтад оруулж, суудлын тоог 3210-аар, 2 спорт заалыг



ашиглалтад оруулж, талбайг 504 м2 нэмэгдүүлээд байна. Мөн улсын төсвийн хөрөнгөөр нийт 201 сургууль, цэцэрлэг, соёлын төв, дотуур байр, спорт заалны барилга байгууламжийг шинэчлэн засварлаж сургалтын болон үйлчилгээний орчинг сайжруулаад байна. Мөн Азийн хөгжлийн банкны “Боловсролын хөгжлийн хөтөлбөр-3” төслийн

санхүүжилтээр 1,323.5 сая төгрөгөөр ерөнхий боловсролын сургуулийн 8 хичээлийн байрыг бүрэн засварласан байна.

Энэ бүхний дүнд цэцэрлэгийн хамран сургалт 3,4 хувиар, бага боловсролын хамран сургалт 0,2 хувиар, суурь боловсролын хамран сургалт 0,1 хувиар тус тус өссөн нь хөрөнгө оруулалтын ажлын нэг гол үр дүн болж байна.


### ***Боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарт улсын төсвийн хөрөнгөөр бараа худалдан үйл ажиллагааг зохион байгууллаа.***

2010 онд улсын төсвийн хөрөнгөөр бараа худалдан авах ажлын төлөвлөгөө /Сангийн яаманд хүргүүлсэн байдлаар/-нд 10,2 тэрбум төгрөгийн 57 бараа худалдан авахаар тусгагдсан юм. Үүний 38-ийг орон нутагт эрх шилжүүлэн гүйцэтгэв. Нийт 10,1 тэрбум төгрөгийн худалдан авалт хийж, тоног төхөөрөмжөө түгээв. Эдгээрийн зарим томоохноос дурдвал, боловсролын байгууллагуудад тоног төхөөрөмж, тавилга нийлүүлэх 770,5 сая, ерөнхий боловсролын сургуульд компьютер, тоног төхөөрөмж нийлүүлэх 958,2 сая, сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудын тавилга, тоног төхөөрөмж худалдан авах 629,0 сая, шинээр ашиглалтад орсон боловсролын байгууллагуудад тавилга, хэрэгсэл, тоног төхөөрөмж худалдан авах 532,5 сая, ерөнхий боловсролын сургуулийн болон дотуур байрны тавилга, тоног төхөөрөмж худалдан авах 669,4 сая, СӨБ болон ЕБС-ийн гал тогооны тоног төхөөрөмж худалдан авах 847,0 сая, ерөнхий боловсролын сургуулийн багш нарт зөөврийн компьютер худалдан авах 947,5 сая, ерөнхий боловсролын сургуулийн хөгжим, биеийн тамирын хичээлийн хэрэглэгдэхүүн худалдан авах 375,5 сая, Кембрижийн хөтөлбөрөөр хичээллэх лаборатори сургуульд тавилга, тоног төхөөрөмж, үндэсний бөхийн хэрэглэгдэхүүн худалдан авах 124,3 сая, соёлын салбарт компьютер, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл, хөгжим, автомашин худалдан авах 1,1 тэрбум, шинжлэх ухааны салбарын лабораторийн тоног төхөөрөмж нийлүүлэх 287,7 сая төгрөгийн ажил зэрэг олон арга хэмжээг зохих журмын дагуу тендер зарлан гэрээ байгуулж гүйцэтгэв.

### ***Салбарын 2011 оны төсвийн төслийг боловсруулан батлуулав.***

Монголын ард түмэнд боловсрол, соёл, шинжлэх ухаан, технологийн үйлчилгээг хүргэх асуудлыг төрийн бодлогын хүрээнд дэвшүүлэн тавьсан Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2011 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан зорилтуудыг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 2011 оны Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын төсвийн багцын зарлага нийтдээ 655,3 тэрбум төгрөгөөр батлагдлаа. Үүний 586.9 тэрбум төгрөг нь сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсрол, мэргэжлийн боловсрол, дээд боловсролын үйлчилгээнд, 48.9 тэрбум төгрөг нь мэргэжлийн тайзны урлаг, музей, номын сан, соёлын төвийн үйлчилгээнд, 19.5 тэрбум төгрөг нь шинжлэх ухаан, технологийн үйлчилгээнд тус тус зарцуулагдахаар батлагдлаа. Үүнийг дараахь зургаар харуулав.

**Боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарын  
нийт төсөв /тэрбум төгрөгөөр/**



2011 оны төсвийн зарлагын хязгаараас 132.2 тэрбум төгрөгөөр нэмэгдсэний 56.9 тэрбум төгрөг нь шинэ барилга барих, барилгын их засвар, тоног төхөөрөмжийн нийлүүлэлтэд, 75.3 тэрбум төгрөг нь урсгал зардалд зарцуулагдахаар байна. Үүний 60.5 тэрбум төгрөг боловсролын салбарт, 8.0 тэрбум төгрөг соёл, урлагийн салбарт, 6.7 тэрбум төгрөг нь шинжлэх ухаан, технологийн салбарт ногдож байна.

Соёл, урлаг, шинжлэх ухаан, технологийн салбарын 2011 оны төсөв Монгол Улсын түүхэнд байгаагүй хэмжээгээр өслөө. Тухайлбал, соёл, урлагийн салбарын урсгал зардал 2010 онд 25.4 тэрбум төгрөг, 2010 оны төсвийн тодотголоор 28.2 тэрбум төгрөг, 2011 онд 34.5 тэрбум төгрөг болж өслөө. Шинжлэх ухаан, технологийн салбарын урсгал төсөв 2010 онд 14.7 тэрбум төгрөг байсан бол 2011 онд өмнөх жилээс 3.9 тэрбум төгрөгөөр өсч, 18.6 тэрбум төгрөг боллоо. Ингэж төсвийг төлөвлөсөн нь тухайн салбарын байгууллагуудын өмнөө тавьсан зорилго, стратегийн зорилтуудыг хангахад ихээхэн дэмжлэг болохоос гадна тэдгээрийн үйлчилгээг сайжруулах, ажлын үр дүнг нэмэгдүүлэхэд шийдвэрлэх ач холбогдолтой юм. Гэхдээ төсөв нэмэгдэхийн хэрээр үйл ажиллагааны үр дүнгийн үзүүлэлтийн чанар сайжрах ёстой. Ирэх онд соёл, урлагийн салбарын байгууллагуудын төсөв өмнөх жилүүдийнхээс өсч, Монголын ард олны тус салбараас буюу төрөөс хүртэх үйлчилгээний чанар сайжрах зам нээгдлээ

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2011 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрт боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарт тусгагдсан зорилтуудыг биелүүлэх хүрээнд 2011 оны төсөв хэрэгжинэ.

Боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарын барилга, их засвар, тоног төхөөрөмжийн 2011 онд зарцуулах хөрөнгө оруулалтын нийт хэмжээ 87119,4 сая төгрөг ба барилга, их засварын хөрөнгө оруулалтын хэмжээ 80932,9 сая төгрөг, тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт 6186,5 сая төгрөгөөр батлагдаад байна. Боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарт хөрөнгө оруулалт тасралтгүй өсч 2011 онд Улсын

төсвийн хөрөнгө оруулалтаар 87119.4 сая төгрөг батлагдсан болно. Энэ нь өмнөх 2010 оны хөрөнгө оруулалтаас 13 хувиар, 2009 оны хөрөнгө оруулалтаас даруй 48 хувиар тус тус өссөн байна.

2011 онд шинээр сургуулийн 18 барилгыг ашиглалтад оруулж, суудлын тоог 8768-аар, цэцэрлэгийн 21 барилгыг ашиглалтад оруулж, орны тоог 2145-аар, дотуур байрны 5 барилгыг ашиглалтад оруулж, орны тоог 720-оор, соёлын төвийн 7 барилгыг ашиглалтад оруулж, суудлын тоог 1920-оор тус тус нэмэгдүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. Мөн салбарын барилга байгууламжид 10,8 тэрбум төгрөгөөр засвар шинэчлэл хийж сурах орныг сайжруулж, 6,2 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл нийлүүлж сургалтын материаллаг баазыг нэмэгдүүлэх болно.

## **Зургаа. Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний талаар**

***Боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарын статистикийн 10 мэдээллийг нэгтгэн боловсруулж гаргалаа.***

1. 2009-2010 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургууль төгсөгчдийн статистикийн мэдээллийг батлагдсан албан ёсны маягтын дагуу нэгтгэж, 2010 оны 8 дугаар сарын 2-ны өдрийн 8/4642 тоот албан бичгээр Үндэсний статистикийн хороонд хүргүүлэв. 2009-2010 оны хичээлийн жилд улсын хэмжээнд бага боловсролыг 50195, суурь боловсролыг 54148, бүрэн дунд боловсролыг 36081 суралцагч тус тус эзэмшин төгссөн байна.

2. Мэргэжлийн боловсрол эзэмшин төгсөгчдийн мэдээг нэгтгэж, 2010 оны 10 дугаар сарын 1-ний өдрийн 8/6300 тоот албан бичгээр Үндэсний статистикийн хороонд хүргүүлээд байна. 2009-2010 оны хичээлийн жилд мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн 63 төвд 14836 сурагч суралцаж төгссөнөөс 48.8 хувь буюу 7137 нь эмэгтэй сурагч байна. Нийт төгсөгчдийн 14.1 хувь буюу 2094 сурагч дараагийн шатны сургуульд дэвшин суралцсан бөгөөд тэдний 11.8 хувь буюу 247 нь мэргэжлийн боловсрол, 18.8 хувь буюу 395 нь дипломын боловсрол, 69.4 хувь буюу 1452 нь бакалаврын боловсрол эзэмшихээр элссэн байна.

3. 2009-2010 оны хичээлийн жилд их, дээд сургууль, коллеж төгсөгчдийн статистикийн мэдээллийг албан ёсны мэдээллийн маягтын дагуу нийт 19 үзүүлэлтээр нэгтгэн гаргаж, 2009 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн № 8/5923 тоот албан бичгээр Үндэсний хөгжил шинэтгэлийн хороонд хүргүүллээ. 2009-2010 оны хичээлийн жилийн статистикийн мэдээгээр манай улсад дотоодын 141 дээд боловсролын сургалтын байгууллага албан ёсоор бүртгэгдсэнээс 139 сургууль төгсөлт хийж, статистикийн мэдээлэлд бүрэн хамрагдлаа. Гадаадын их сургуулийн салбар сургуулийн ихэнх нь үүсгэн байгуулагч улсын их сургуулиудад төгсөлтөө хийж, тухайн улсынхаа дипломыг олгодог тул энэ мэдээнд хамрагдаагүй болно.

2009-2010 оны хичээлийн жилд нийт 34211 суралцагч сургуулиа төгссөн нь өнгөрсөн онтой харьцуулахад 1.2 мянгаар нэмэгджээ. Энэ нь магистрын зэргээр төгсөгчдийн өсөлтөөс хамаарч байна. Төгсөгчдийн боловсролын зэргийн бүтцийг авч үзвэл нийт төгсөгчдийн 1675 нь буюу 4.9 хувь нь дипломын дээд, 28899 буюу 84.5 хувь нь бакалаврын, 3501 буюу 10.2 хувь нь магистрын, 136 буюу 0.4 хувь нь докторын

зэрэгтэй төгсөгч байна. Нийт төгсөгчийг эзэмшиж байгаа мэргэжлийн чиглэлээр нь ангилан авч үзвэл: 14.7 хувь нь боловсрол, 10.2 хувь нь хүмүүнлэг, 41.3 хувь нь нийгэм, эдийн засаг, 5.4 хувь нь байгалийн ухаан, 11.7 хувь нь техник-технологи, 2.4 хувь нь ХАА, 8.2 хувь нь эрүүл мэнд, нийгмийн халамжийн салбарт хамаарч байна. Үүнийг өмнөх хичээлийн жилтэй харьцуулбал боловсрол, эрүүл мэндийн салбарын хувийн жин 1.0 орчим хувиар тус тус өсч, нийгэм, эдийн засгийн салбарын эзлэх хувь 3.0 орчим хувиар буурчээ. 2001 оноос хойш боловсрол, байгалийн ухаан, техник-технологи, анагаах ухааны чиглэлээр төгсөгчдийн тоо аажмаар өсч байгаа ч эдгээр салбарын нийт дүнд эзлэх хувь хэмжээ нь дорвитой нэмэгдэхгүй байна. Иймд дээд боловсрол эзэмшихээр суралцагчдын тоо жил ирэх тусам өсч байгаатай холбогдуулан их, дээд сургууль, коллежид мэргэжлийн тэргүүлэх чиглэлээр түлхүү элсэлт авах, Сургалтын төрийн сангаас олгох сургалтын зээл, буцалтгүй тусламжийг ялгавартай тогтоох бодлогыг цаашид тууштай хэрэгжүүлж, бодит үр дүнд хүргэх зорилт тавьж байна.

4. Соёл, урлагийн салбарын 2009 оны статистикийн мэдээллийг батлагдсан албан ёсны мэдээллийн болон захиргааны мэдээллийн маягтын дагуу нийт 482 үзүүлэлтийн дагуу хүлээн авч хянан, нэгтгэн боловсруулж, албан ёсны мэдээллийн дүнг 2010 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн 8/1231 тоот албан бичгээр Үндэсний статистикийн хороонд хүргүүлээ. Ингэснээр соёл, урлагийн салбарын статистикийн мэдээллийн сан шинээр баяжиж, Үндэсний статистикийн хорооноос жил тутам гаргадаг “Монгол Улсын статистикийн лавлах” номд тус салбарын 2009 оны мэдээлэл тусгагдах боломжтой болсон юм. Соёл, урлагийн салбарын 2009 оны статистикийн мэдээлэлд Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа мэргэжлийн урлагийн 36 байгууллага, 38 музей, 368 нийтийн номын сан, 340 соёлын төв, ордон, 52 кино үзвэрийн цэг болон кино үйлдвэрлэлийн байгууллага хамрагдсан бөгөөд эдгээр соёл, урлагийн байгууллагуудаар давхардсан тоогоор нийтдээ 8.6 сая хүн үйлчлүүлсэн нь өнгөрсөн онтой харьцуулахад 0.7 сая хүнээр буурсан байна. Энэ нь улс орон даяар гахайн цар тахал ханиад гарч, хэсэг хугацаанд хөл хорио тогтоосонтой холбоотой байна.


5. Шинжлэх ухааны салбарын 2009 оны статистикийн мэдээллийг батлагдсан албан ёсны мэдээллийн маягтын дагуу нийт 246 үзүүлэлтээр хүлээн авч нэгтгэн боловсруулж, албан ёсны мэдээллийн дүнг 2010 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн өдрийн 8/1594 тоот албан бичгээр Үндэсний статистикийн хороонд хүргүүлээ. Ингэснээр ШУТ-ийн салбарын статистикийн мэдээллийн сан шинээр баяжиж, Үндэсний статистикийн хорооноос жил тутам гаргадаг “Монгол Улсын статистикийн лавлах” номонд тус салбарын мэдээлэл тусгагдах боломжтой боллоо. 2009 оны статистикийн мэдээнд төрийн өмчийн 50 эрдэм шинжилгээний байгууллага, 7 их сургууль, төрийн бус өмчийн 9 эрдэм шинжилгээний байгууллага, 2 их сургууль хамрагдсан нь өнгөрсөн жилийнхтэй харьцуулахад 4 байгууллагаар нэмэгдэж, хамрах хүрээ нь өргөжлөө. Эдгээр байгууллага нь Засгийн газрын тогтоолоор 2009 онд шинээр байгуулагдсан ШУА-ийн харьяа Загас үржүүлгийн эрдэм шинжилгээний төв, мөн онд шинээр үүсгэн байгуулагдсан хувийн хэвшлийн Усны судалгаа, хөгжлийн хүрээлэн болон төрийн бус өмчийн Орхон, Отгонтэнгэр их сургуулиуд юм.

6. Сургуулийн өмнөх болон бага, дунд, мэргэжлийн боловсролын салбарын 2009 оны төсвийн зардлын гүйцэтгэл, сургалтын орчны статистик мэдээг батлагдсан албан ёсны мэдээллийн маягтын дагуу 1632 байгууллагаас хүлээн авч нэгтгэн 2010 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн 8/2108 тоот албан бичгээр, дээд боловсролын салбарын

2009 оны төсвийн зардлын гүйцэтгэлийн статистикийн мэдээллийг батлагдсан албан ёсны мэдээллийн ДБ-6 маягт, үзүүлэлтийн дагуу нэгтгэн 2010 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн 8/2159 тоот албан бичгээр Үндэсний статистикийн хороонд тус тус хүргүүлээ. Дээд боловсролын салбарын мэдээнд төрийн өмчийн 42 сургууль, мөн төрийн бус өмчийн 95, гадаадын 4 салбар сургууль, нийт 141 дээд боловсролын сургалтын байгууллага хамрагдлаа. Мөн дээд боловсролын сургалтын байгууллагуудын 2009-2010 оны хичээлийн жилийн сургалтын орчны статистикийн мэдээллийг батлагдсан захиргааны мэдээллийн ДБ-11 маягт, үзүүлэлтийн дагуу нэгтгэн боловсруулж, “Боловсрол, соёл, урлаг, шинжлэх ухаан, технологийн салбарын 2009-2010 оны хичээлийн жилийн статистикийн мэдээллийн эмхтгэл (II)-д оруулж хэвлүүлээ. Дээрх мэдээллийг шинээр оруулснаар боловсролын салбарын статистикийн мэдээллийн сан баяжиж байгаа төдийгүй, иргэдэд энэ талаарх мэдээллээр нээлттэй үйлчлэх боломжтой боллоо.

7. 2010-2011 оны хичээлийн жилийн эхний хагас жилийн сургуулийн өмнөх боловсролын салбарын мэдээг албан ёсны батлагдсан 11 маягтаар, бага дунд боловсролын салбарын мэдээг албан ёсны 7 болон захиргааны 29 маягтаар тус тус гаргаж, 2010 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 8/7350, 8/7349 тоот албан бичгээр Үндэсний статистикийн хороонд хүргүүлээ. 2010-2011 оны хичээлийн жилд улсын хэмжээнд 839 цэцэрлэг үйл ажиллагаа явуулж, түүнд 157,1 мянган хүүхэд хамрагдаж байгаагийн 122,1 мянга нь үндсэн бүлгээр, 35,0 мянга нь хувилбарт сургалтаар сургуулийн өмнөх боловсрол эзэмшиж байна. Цэцэрлэгийн тоо өмнөх хичээлийн жилийнхээс 25-аар, СӨБ-д хамрагдах хүүхдийн тоо 15.1 мянгаар тус тус өссөн байна. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад 16659 ажилчид ажиллаж байгаагийн 4651 нь үндсэн багш байна. Үүнийг өмнөх хичээлийн жилийн үзүүлэлттэй харьцуулахад ажилчдын тоо 923-аар, багшийн тоо 186-аар тус тус өсчээ.

2010-2011 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын 751 сургуульд нийт 512213 суралцагч өдрөөр суралцаж байна. Ерөнхий боловсролын сургуулийн тоо өнгөрсөн хичээлийн жилийнхээс 4-өөр, суралцагчдын тоо 9,8 мянгаар тус тус буурсан байна. Ерөнхий боловсролын нийт сургуулийн 81.1 хувь нь төрийн өмчийн, 18.9 хувь нь төрийн бус өмчийн сургууль байна. Тэдгээрийн 72.6 хувь нь хөдөөд үйл ажиллагаа явуулж байна. Нийт суралцагчдын 94.7 хувь нь төрийн өмчийн сургуульд суралцаж байгаа бөгөөд суралцагчдын тоог өнгөрсөн жилийнхтэй харьцуулахад 0.4 пунктээр өссөн байна.



бөгөөд суралцагчдын тоог өнгөрсөн жилийнхтэй харьцуулахад 0.4 пунктээр өссөн байна.

2010-2011 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуульд нийт 44143 ажилтан, ажиллагчид ажиллаж байгаагийн 26358 нь үндсэн багш байна. Ажиллагчдын тоо өмнөх

хичээлийн жилийнхээс 1173-аар, үндсэн багшийн тоо 288-аар тус тус өссөн байна.

8. Мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн 63 төвд 46,0 мянган суралцагч суралцаж байна. Энэ үзүүлэлтийг өмнөх жилтэй харьцуулахад суралцагчдын тоо 1.4 мянгаар өссөн байна. МСҮТ-д 19438 суралцагч шинээр элсэн орсон бөгөөд 13168 буюу 24.6 хувь нь ерөнхий боловсролын сургуулийн суурь боловсрол эзэмшин төгсөгчид, 2827 нь бүрэн дунд боловсрол эзэмшин төгсөгчид байна.

9. Дээд боловсролын салбарын 2010-2011 оны хичээлийн жилийн эхний хагасын статистикийн мэдээллийг батлагдсан албан ёсны мэдээллийн ДБ-1, ДБ-2, ДБ-3, ДБ-5, захиргааны мэдээллийн ДБ-7, ДБ-8, ДБ-9, ДБ-10, ДБ-12, ДБ-13 маягтын дагуу хүлээн авч хянан нэгтгэн боловсруулж, албан ёсны статистикийн мэдээллийн дүнг 2010 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 8/7175 тоот албан бичгээр Үндэсний статистикийн хороонд хүргүүлээ. Өнгөрсөн хичээлийн жилд Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн 15 дугаар тогтоолоор төрийн өмчийн 42 сургуулийг 16 болгон өөрчлөн зохион байгуулсан бөгөөд төрийн бус өмчийн 7 сургууль татан буугдах буюу бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлтөд орсноор дээд боловсролын сургалтын байгууллагын тоо 146 байснаа 113 болов. Төрийн өмчийн 16, төрийн бус өмчийн 92, гадаадын 5 их сургуулийн салбар сургууль байгаагийн 100 нь Улаанбаатар хотод, 13 нь хөдөө орон нутагт байрлаж байна. Энэ хичээлийн жилд нийт суралцагчдын тоо 170126 болж, өмнөх хичээлийн жилээс 5353-аар нэмэгдлээ. Үүнд бакалавр (4.0 мянга), магистр (1.4 мянга), доктор (0.3 мянга)-ын зэргээр суралцагчдын тоо өсч, дипломын дээд (0.4 мянга) боловсролын зэргээр суралцагчдын тоо буурсан байна.

10. Сургуулийн өмнөх боловсрол, бага, дунд, мэргэжлийн болон дээд боловсролын салбарын 2008-2009 оны зарим үзүүлэлт (багш, суралцагчдын тоо, хүйс, суралцагчдын насны ангилал, суралцаж байгаа мэргэжлийн чиглэл, төгсөгчдийн тоо, хүйс ба мэргэжлийн чиглэл, гадаад орнуудаас суралцаж байгаа оюутны тоо, санхүүжилтийн эх үүсвэр, зардал)-ийг ЮНЕСКО-гоос ирүүлсэн асуулгын UIS/E/2010A, UIS/E/2010B, UIS/E/2010C маягт, аргачлалын дагуу гаргаж, цахим шуудангаар хүргүүлэн уг мэдээг хүлээж авсан тухай хариу авлаа. Ингэснээр Монгол Улсын боловсролын салбарын гол үзүүлэлтүүд ЮНЕСКО болон олон улсын бусад байгууллагын албан ёсны мэдээлэлд нэгтгэгдэн бусад орны үзүүлэлтүүдтэй харьцуулах боломж бүрдэж байна.

11. “Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай” хууль батлагдан гарсантай холбогдуулан мэргэжлийн болон техникийн боловсролын салбарын статистик мэдээллийг олон улсын нийтлэг стандарт, арга зүйд нийцүүлэх зорилгоор албан ёсны статистикийн 7, захиргааны 10 маягтыг албан ёсны 7, захиргааны 14 маягт болгон маягтын зураглал, зааварчилгааг шинэчлэн боловсрууллаа. Ингэснээр мэргэжлийн боловсрол, сургалтын холбогдох хууль, тогтоомж, Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого болон бусад хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хянан зохицуулах, ЮНЕСКО-ийн шугамаар олон улсын хэмжээнд гаргадаг мэдээлэлтэй ижил төстэй мэдээллийг гаргах боломж бүрдэж байгаа юм.

12. “Боловсрол, соёл, урлаг, шинжлэх ухаан, технологийн салбарын 2008-2009 оны хичээлийн жилийн статистикийн мэдээллийн эмхтгэл (II) 180 ширхэг, боловсролын салбарын 2009-2010 оны хичээлийн жилийн статистикийн мэдээллийн эмхтгэл (I)” номыг 300 ширхэг хувь хэвлүүлж, яамны аппаратын ажилтан, холбогдох байгуулагуудад түгээлээ. Мөн “Боловсролын салбарын 2009-2010 оны хичээлийн жилийн статистикийн мэдээллийн эмхтгэл (I)” номыг 300 ширхэг, “Боловсрол, соёл, урлаг, шинжлэх ухааны

салбарын 2009 он, 2009-2010 оны хичээлийн жилийн статистикийн эмхтгэл (II)” номыг 200 ширхэг, “Статистикийн мэдээлэл-2010”-ийг 500 хувь, “Боловсролын салбарын 2009-2010 оны хичээлийн жилийн статистикийн мэдээллийн эмхтгэл (I)” номыг англи хэл дээр хөрвүүлэн хэвлүүлж, яамны аппаратын ажилтнууд болон бусад хэрэглэгчдэд тус тус хүргүүлээд байна.

### ***Салбарын зарим үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өглөө.***

1. Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогод сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын салбарын чиглэлээр тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийлээ. Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын салбарын чиглэлээр тусгагдсан 21 арга хэмжээний хэрэгжилтээс үзэхэд сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт 18.9, 6 настай хүүхдийн хамрагдалт 11.8 хувиар хувиар тус тус өссөн, ерөнхий боловсролын сургуулийн охид, хөвгүүдийн тооны харьцаа аль ч түвшинд тогтвортой байгаа, сургуулийн гадна байгаа хүүхдээс сургуульд буцаж орсон хүүхдийн тоо, эрэгтэй хүүхдийн боловсрол эзэмшилтийн хувь, “Үдийн цай” хөтөлбөрт хамрагдалт, түүнд зарцуулах төсөв, багш нарын мэргэжил дээшлүүлэхэд зарцуулсан зардал зэрэг суурь оноос өссөн үзүүлэлттэй арга хэмжээ олон байна. Анхаарах шаардлагатай зарим асуудал байна. Багш мэргэжлээр төгсөгчдийг ажлын байраар хангах, ялангуяа, багшийн сонгон шалгаруулалтыг нээлттэй, шударга зохион байгуулах, дотуур байрын барилгын норм, дүрмийг шинэчлэх, БАМ-ын дотуур байрын чанар, ашиглалтын хугацааг харгалзан зориулалтын байраар хангах, стандартын бус барилгыг шинэчлэх талаар бодлогын түвшинд анхаарах, малчин өрхийн 2-5 насны хүүхдийн судалгааг орон нутгийн засаг захиргааны байгууллагын оролцоотой гаргаж байх, Албан бус боловсрол, зайны сургалтын үндэсний төвд түшиглэн бичиг үсэг үл мэдэгч болон бага, суурь боловсрол эзэмшиж буй иргэдийн мэдээллийг жил бүр нэгтгэн гаргаж байх, энэ талаарх мэдээллийн санг бүрдүүлэх ажлыг зохион байгуулах шаардлагатай байгаа нь харагдлаа.

2. Үндэсний хөгжлийн цогц бодлогод соёл, урлагийн салбарын чиглэлээр тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтэд эхний шатны үнэлгээ хийж, Үндэсний хөгжил шинэтгэлийн хороонд хүргүүлээ. Соёлын салбарын төсвийн санхүүжилтийн хэмжээг бууруулахгүй, байнга өсгөн нэмэгдүүлэх чиглэл баримталснаар 2010 онд соёл, урлагийн салбарын төсөв 32,9 тэрбум төгрөгөөр батлагдсан нь цогц бодлого хэрэгжүүлэх гарааны жил 2006 оны төсөвтэй харьцуулбал 2,7 дахин, 2009 оны төсөвтэй харьцуулбал 1,1 тэрбум төгрөгөөр илүү батлагдсан байна. Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 64 дүгээр тогтоолоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг “Соёл, урлагийн хороо”-г байгуулсан нь соёл, урлагийн салбарын удирдлагын тогтолцоог бие даалгах талаар зохион байгуулалтын хувьд авсан чухал арга хэмжээ болсон юм.

Орон нутгийн соёлын үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэхэд төр засгаас анхаарч, сумдын соёлын төвийн орон тоог 5 болгож, энэ арга хэмжээнд зориулан 2008 оноос жил бүр 445.0 орчим сая төгрөгийг улсын төсөвт тусгаж байна. Энэ шийдвэрийн үр дүнд малчид, иргэдэд хамгийн ойр байдаг сумдын соёлын төвийн үйлчилгээний хүртээмж, чанарыг дээшлүүлэх өргөн боломжийг буй болгосон боловч номын сан, музей, урлагийн байгууллагаар үйлчлүүлэгчийн тооны өсөлтөд хараахан нөлөөлж чадаагүй байгаад дүгнэлт хийх хэрэгтэй байна.

3. Эдийн засаг, нийгмийг 2010 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийн III улирлын гүйцэтгэлд хяналт-шинжилгээ хийв. 2010 оны үндсэн чиглэлд тусгагдсан 58 арга хэмжээний биелэлт III улирлын байдлаар 60.35 хувьтай байв. Цаашид төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ болон ЗГҮАХ, ЭЗНХҮЧ-ийн зорилтуудыг биелүүлэхэд бүх түвшинд анхаарч, хэрэгжилтийн явцыг эрчимжүүлэн ажиллах нь зүйтэй байна.

4. Засгийн газрын 2009 оны 1 дүгээр тогтоолоор батлагдсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарын чиглэлээр тусгагдсан 32 зорилтын 129 арга хэмжээг тус яам хариуцан хэрэгжүүлж байна. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт 44,4 хувьтай байлаа. Хөтөлбөрийн тайланг эцэслэхэд 1,8 жил үлдэж байгаа бөгөөд зарим арга хэмжээг эхлээгүй, 30 хувийн биелэлттэй 46 арга хэмжээ байгаад цаашид анхаарах шаардлагатайг харууллаа.

5. Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор батлан гаргасан “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр”, “Англи хэлний боловсролын үндэсний хөтөлбөр”, Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын багш бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”, “Бичиг үсгийн боловсролын үндэсний хөтөлбөр”, “Зайны сургалтын үндэсний хөтөлбөр”, “Морин хуур, уртын дуу”, “Түүх, соёлын дурсгалыг хамгаалах, сэргээн засварлах хөтөлбөр”, “Монгол хөөмий”, “Монгол бий биелгээ” зэрэг үндэсний хөтөлбөрүүдэд хяналт-шинжилгээ хийж, 2010 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн 2/1810 тоот албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэв.

Бага, дунд боловсролын салбарт хэрэгжиж буй үндэсний хөтөлбөрийн биелэлт 86.4 хувьтай байна. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэргүй байдал нь түүний хэрэгжилтэд нөлөөлж байна. Гэсэн хэдий ч хөрөнгө шаардагдахгүй зарим арга хэмжээ түвшин бүрт амжилттай хэрэгжиж байна. Цаашид хөтөлбөрийн зорилтод тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг хянах, хугацаа хоцорч байгаа зарим ажлыг эхлүүлэх, түүний үр дүнгийн мэдээлэл, хяналт-шинжилгээний тогтолцоог бий болгох, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, төлөвлөлтийн хэрэгжилт, үр дүнгээр холбогдох байгууллагын ажлыг дүгнэж ажиллах шаардлагатай байна. Түүнчлэн орон нутгийн засаг захиргааны идэвх санаачилга, дэмжлэг туслалцаа хангалтгүй байгаад анхаарч, байгууллага хоорондын уялдаа холбоо нэгдмэл үйл ажиллагааг сайжруулахад анхаарах шаардлагатай байгааг хяналт-шинжилгээний дүн харуулав.

6. Аймаг, нийслэлийн Засаг даргатай төсвийн ерөнхийлөн захирагчийн байгуулсан 2009 оны үр дүнгийн гэрээнд хяналт-шинжилгээ хийж, дүнг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэв. Аймаг, нийслэлийн Засаг даргатай байгуулсан үр дүнгийн гэрээ, Боловсрол, соёлын газруудын үйл ажиллагааны дүгнэлтээс үзэхэд Боловсролын үндсэн зорилт болсон иргэдийг бүх түвшинд хамран сургах, сургуулийн гадна байгаа хүүхдүүдийг сургалтад хамруулах, завсардалтыг бууруулах, цэцэрлэгийн багшийн хангамжийг нэмэгдүүлэх, орон нутгийн соёлын төв, театр, сургууль, цэцэрлэгийг мэргэжлийн багш, мэргэжилтнээр хангах, сургалтын чанарыг сайжруулах, боловсрол, соёлын байгууллагад оруулсан хөрөнгө оруулалтын чанар, үр ашгийг дээшлүүлэхэд бүх шатны Засаг даргын Тамгын газар, Боловсрол, соёлын газар, боловсрол, соёлын үйлчилгээг хүртэгч, хэрэглэгч байгууллага, нийт иргэн, эцэг, эхийн хүчин чармайлтыг нэгтгэн сайжруулах хэрэгтэй болохыг хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн харуулав.

7. Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны 2009 оны бүтээгдэхүүн нийлүүлэх үр дүнгийн гэрээний биелэлт, яамны 2009 оны үйл ажиллагааны тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүллээ. Яамны үйл ажиллагааны бодлогын зорилтын хэрэгжилтийн үр дүнгийн үнэлгээний дундаж 4.26, бодлогын зорилтын хэрэгжилтийн зохицуулалтын үнэлгээний дундаж 4.48, байгууллагын үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээний дундаж 4.74, байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлын үнэлгээ 5.0, үйл ажиллагааны үр дагаврын үнэлгээгээр 4.48, ерөнхий дундаж оноогоор 4.59, үр дүнгийн үнэлгээгээр 92.0 хувьтай гарсан нь тус яам өнгөрсөн онд хангалттай сайн ажилласныг харуулж байна.

8. Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2008 оны 337 дугаар тушаалаар баталсан аймаг, нийслэлийн Боловсрол, соёлын газрын үйл ажиллагааг үнэлэх журамд заасан шалгуур үзүүлэлтийг баримтлан Боловсрол, соёлын газрын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүнг аймгийн Засаг дарга нар, Боловсрол, соёлын газарт хүргүүллээ. 2009 оны үйл ажиллагааны дүнгээр шалгарсан Дархан-Уул, Завхан, Орхон, Дорнод, Увс аймаг, Улаанбаатар хот дээгүүр оноотой, Ховд, Хэнтий, Баян-Өлгий, Говьсүмбэр, Хөвсгөл аймгийн Боловсрол, соёлын газар доогуур үнэлгээтэй дүгнэгдлээ. Үнэлгээний дүнгээс үзэхэд аймаг, нийслэлийн Боловсрол, соёлын газрын дийлэнх нь 2009 онд дэвшүүлсэн зорилтоо хэрэгжүүлж, 80-94 хувийн гүйцэтгэлтэй ажилласан байна. Туршлага, сургамж болох жишээ, нийтлэг дутагдал, цаашид сайжруулах чиглэлээр 8 зүйл бүхий зөвлөмж гаргаж мэдээлэв.

9. Эрдэм шинжилгээний байгууллагуудын үйл ажиллагааны тайланд холбогдох шалгуур үзүүлэлтийн дагуу хяналт-шинжилгээ хийлээ. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээс үзэхэд шинжлэх ухаан, технологийн эрдэм шинжилгээний зарим байгууллага тайлангаа ирүүлээгүй, тайлан нэгтгэл нь оновчгүй, хугацаа алдах нийтлэг дутагдал гарч байна. Цаашид шалгуур үзүүлэлтүүдийг зөв тодорхойлох, мэдээ, тайлангаа хугацаанд нь ирүүлэх талаар анхаарч ажиллахыг зөвлөлөө.

10. 2009-2010 оны хичээлийн жилийн зорилтод сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын талаар дэвшүүлсэн зорилтын хэрэгжилтийн байдалд хяналт-шинжилгээ хийлээ. Хичээлийн жилийн зорилтын хүрээнд аймаг, орон нутагт авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, тухайлбал, сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын салбарын чиглэлээр дэвшүүлсэн 15 зорилтын хэрэгжилт 82.0 хувьтай байна. Зорилтын дийлэнх нь 90-30 хувьтай байгаа нь төлөвлөсөн арга хэмжээ бүрэн төгс хэрэгжээгүйг харуулж байна. Гэвч 2009-2010 оны хичээлийн жилд дэвшүүлсэн зорилт сургууль завсардалтын хувийн жинг бүүруулахаас бусад нь тодорхой түвшинд хэрэгжсэн байна.

11. Сургуулийн өмнөх боловсролын хувилбарт сургалт, гэр цэцэрлэгийн хамралтын байдалд хяналт-шинжилгээ хийлээ. Хүүхэд бүрийг цэцэрлэгээр дамжуулан сургуулийн өмнөх боловсрол олгох боломжгүй байгаа өнөөгийн нөхцөлд хөдөөгийн алслагдсан сум, багийн малчдын хүүхдийг сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамруулах боломжийг бүрдүүлж байгаад энэхүү хувилбарт сургалтын ач холбогдол оршиж байна. Бага насны хүүхдийн хөгжилд анхаарч, тэднийг сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд олноор хамруулах нь бага боловсролын хамран сургалтад нөлөөлөөд зогсохгүй хүүхдийг сургууль завсардахаас сэргийлэх чухал арга хэмжээ болох юм.

Сургуулийн өмнөх боловсролын хувилбарт сургалтын хэрэгжилтээс үзэхэд цаашид дараах зүйлд анхаарах шаардлагатай байна.

1.Хувилбарт сургалтыг зохион байгуулахад шаардагдах нэмэлт унаа тээврийн, ном гарын авлага худалдан авах болон хүүхдийн хичээлийн хэрэглэл, ариун цэврийн хэрэгслийн зардлыг төсөвт тусгах;

2.“Гэр цэцэрлэг”, ”явуулын багшийн” үйлчилгээг сум, багт хичээлийн жилийн турш буюу урт хугацаагаар зохион байгуулах боломжийг бүрдүүлэхэд орон нутгийн зүгээс дэмжлэг үзүүлэх;

3.Нүүдлийн бүлгийн хүүхдийн хоол хүнсний хангамж, нөөц, хадгалалтад анхаарах, үүний тулд бага оврын хөргөгч, хөлдөөгчтэй болгох;

4.Хувилбарт сургалтын удирдлага, төсөв, санхүүжилт, төлөвлөлт, зохион байгуулалт, эцэг эхийн оролцоог нэмэгдүүлэх арга зам, хүүхдийн хөгжлийг үнэлэх, оношлох, хөгжүүлэх сургалтын агуулга, арга зүйн сургалтыг орон нутаг санаачлан зохион байгуулах.

12. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчийн хичээлийн ирц, сурлагын амжилтад нөлөөлөх байдалд хяналт-шинжилгээ хийлээ. Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн ирц, тэдний сурлагын амжилтын хоорондын харилцан хамаарлыг илрүүлэх нь цаг хугацаа, хүн хүч шаардсан, судалгаа, шинжилгээний өргөн хүрээнд хийгдэх ажил авч, өнөөгийн нөхцөл байдал, нөөц бололцоонд тулгуурлан 9 аймгийн 38 сумдын сургуулийн зарим багш, сурагчидтай уулзан ярилцлага хийх, тэднээс санал асуулга авах, журнал, бусад баримт бичигтэй танилцах зэрэг үйл ажиллагааны хүрээнд сурлагын амжилтад нөлөөлөх хүчин зүйлийг бага боловч тодруулан гаргасан болно.

Суралцагчийн хичээлийн ирц тэдний сурлагын амжилтад нөлөөлөх эсэхийг магадлах үүднээс зарим сумдын сургуулийн 4, 8, 10 дугаар ангийн сурагчдын монгол хэл, математик, биологи, түүх, физик, анги хэл, орос хэлний хичээлийн үнэлгээ, шалтгаантай болон шалтгаангүйгээр тасалсан цагийг SPSS, EXCEL программ ашиглан боловсруулалт хийж, түүний хамаарлыг харьцуулан гаргав. Нийт 1335 сурагч, үүнээс 4 дүгээр ангийн 330, 8 дугаар ангийн 684, 10 дугаар ангийн 321 сурагчийн шалтгаантай болон шалтгаангүйгээр тасалсан 1671 цагийн таслалтыг авч үзэв. Нийт хамрагдсан сурагчийн 384 нь хичээл шалтгаангүй тасалсан бөгөөд тэдгээрийн 20.6 хувь нь А, В, 79.4 хувь нь С, D, F үнэлгээтэй дүгнэгдсэн байна. Шалтгаангүй хичээл таслалт нь сурагчийн сурлагын амжилтад бага боловч нөлөөлж байгаа нь дээрх байдлаас харагдаж байна.

13. Ерөнхий боловсролын сургуулийн насны хүүхдийн төлөвшилд хичээл болон хичээлээс гадуурх ажлын нөлөөллийг орон нутгийн хүрээнд судалж, Булган, Орхон, Архангай, Төв аймаг, нийслэлийн Баянзүрх, Чингэлтэй дүүргийн ерөнхий боловсролын сургуулийн 1900 сурагч, 85 багш, 38 нийгмийн ажилтан, 40 эцэг эх, 100 ажилчдыг хамрууллаа. Энэхүү ажлын хүрээнд ерөнхий боловсролын сургуулийн насны хүүхдийн төлөвшлийг түүнд нөлөөлж буй хүчин зүйлс, хичээлээс гадуурх сургалтын ажлын үр дүнтэй уялдуулан судалсан болно. Судалгааны ажлын дүнд хичээлээс гадуурх сургалтын ажлын агуулга, бүтэц, зохион байгуулалт нь тухайн насны хүүхдийн хэрэгцээ сонирхолд нийцсэн эсэхээс гадна тэдний төлөвшилд үзүүлэх нөлөөллийг тодруулсны

зэрэгцээ нийгмийн орчинд биеэ авч явах байдал, өөрийн болон бусдын өмнө хүлээх хариуцлага, ёс суртахууны хэм хэмжээ болох тэдний төлөвшлийн ерөнхий хандлагыг гаргасан болно. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын хөгжил, төлөвшилд хичээлээс гадуурх сургалтын ажлын үзүүлэх нөлөөллийг авч үзсэн нь энэхүү үйл ажиллагааны үр дүнг сайжруулахад зохих шатны байгууллагын дэмжлэг оролцоог нэмэгдүүлэх ач холбогдолтой юм.

14. Бага, суурь, бүрэн дунд боловсролын дүйцсэн сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийлээ. Дүйцсэн хөтөлбөрийн сургалтын явцад хийсэн хяналт-шинжилгээний дүнгээс үзэхэд сургууль завсардсан, сургуульд огт ороогүй хүүхдэд тухайн түвшний боловсрол эзэмшүүлж, дараагийн шатны их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн-сургалт үйлдвэрлэлийн төвд үргэлжлүүлэн суралцах, ажил, мэргэжлийн чиг баримжаатай болох боломжийг тэдэнд олгож байгаад энэхүү сургалтын давуу тал оршиж байна. Цаашид БСШУ-ы сайдын 2007 оны 362 дугаар тушаалаар батлагдсан “Бага, суурь, бүрэн дунд боловсролын дүйцсэн сургалт явуулах журам”-ыг шинэчлэн сайжруулах, сургалт зохион байгуулагч байгууллагын эрх үүргийг тодорхой болгох, сумын Засаг дарга, аймаг, нийслэлийн Боловсрол, соёлын газрын үүрэг, оролцоо, хяналтыг нэмэгдүүлэх, албан бус боловсролын асуудал хариуцсан мэргэжилтэн, Гэгээрэл төвийн арга зүйч, багш нарыг дүйцсэн хөтөлбөрийн сургалтыг зохион байгуулах арга зүйд сургах, багш нарын мэргэжлийг дээшлүүлэх, тэднийг чадваржуулах, дүйцсэн сургалтыг нэгдсэн удирдлагаар хангах, тус сургалтад хамрагдаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургалтын үр дүнг тооцох боломжийг судлах, энэ нь багшийн ажлын үр дүнд нөлөөлөх эсэхийг шийдвэрлэх шаардлагатай байна.

15. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын сургалтын ажлаа төлөвлөх, зохион байгуулахдаа ажил олгогчдын эрэлт хэрэгцээг тусгасан байдал болон төгсгөгчдийн ажил эрхлэлт, сурах бичиг, сургалтын материалын хүрэлцээ хангамжийг сайжруулах талаар хэрэгжүүлж буй үйл ажиллагааны явц, үр дүнд шинжилгээ хийлээ. Мэргэжлийн боловсролын төвийг төгсгөгчдийн ажил эрхлэлтэд явцад хийсэн хяналт-шинжилгээний дүнгээс үзэхэд 2009-2010 оны хичээлийн жилд мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвд суралцагчдын 8,099 нь ажлын байраар хангагдсан байна. Мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн суралцагчдад ажил, мэргэжлийн чиг баримжаатай болох боломжийг олгоод зогсохгүй тэднийг ажлын байраар хангаж байгаад энэхүү сургалтын давуу тал оршиж байна.

16. Зарим яамдын эрдэм шинжилгээний төсөлт ажлын төлөвлөлт, гэрээлэлт, хэрэгжилт, үр дүнгийн ашиглалтад захиалагчийн гүйцэтгэж буй үүрэг, оролцоонд хяналт шинжилгээ хийлээ. Шинжлэх ухааны төслийг дэвшүүлэх, үр дүнг хүлээн авах, үйлдвэрлэлд нэвтрүүлэх асуудлыг яамдын үүрэгт тусгасан байна. Энэ үүргээ яамд Шинжлэх ухаан, технологийн зөвлөл дээрээ зохион байгуулан хэрэгжүүлж байна.

17. Хөдөөгийн театр чуулга, музей, номын сан, соёлын төвийн үйл ажиллагааны хүртээмж, үр нөлөө, түүний өнөөгийн байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, аймгуудын театр, чуулгын нийт 24 байгууллага, 368 номын сан, 39 музей, 149 орон нутгийг судлах танхим, 340 сумдын соёлын төвийн мэдээллийг аймаг, нийслэлийн Боловсрол, соёлын газраас авч, өмнөх жилүүдийн үйл ажиллагаатай харьцуулан жишиж үзэв. Хөдөөгийн театр чуулга, музей, номын сан, соёлын төвийн үйл ажиллагааны хүртээмж, үр нөлөө, түүний өнөөгийн байдалд хяналт-шинжилгээ, хийж, нэгтгэн дүгнэхэд

сүүлийн хоёр жилд соёлын төвийн орон тоо сум бүрт 5 болж нэмэгдсэн, улсын төсвийн дэмжлэг тогтвортой, хөрөнгө оруулалтын зардал өсч, үзэгчдийн суудлын тоо нэмэгдсэн сайн ажлууд цөөнгүй байна. Гэвч соёлын төв, музей, номын сангаар үйлчлүүлэгчдийн тоо буурч байгаад дүгнэлт хийж ажиллах хэрэгтэй байна. Хөдөөгийн соёл урлагийн байгууллагын мэргэжлийн боловсон хүчний хангалт дутмаг, өмнөх хүрсэн түвшингээсээ ухарсан статистик гарч байна. Иймд тэдгээрийг системтэй сургалтаар боловсрол, чадварыг нь сайжруулах, мэргэжлийг нь тасралтгүй дээшлүүлж байх тогтолцоог буй болгох хэрэгтэй байна.

***Салбарын мэдээллийн сүлжээний хангамж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх талаар зарим арга хэмжээ авч хэрэгжүүллээ.***

БСШУЯ, Азийн хөгжлийн банкны “Боловсролын шинэчлэл төсөл”, Токиогийн технологийн институтийн шинжлэх ухааны мэдээллийн тооцоолох төвтэй хамтран 2010 оны 11 дүгээр сарын 11, 12-нд зохион байгуулсан “Боловсролын салбарт мэдээлэл, харилцаа холбооны технологийг нэвтрүүлэх нь” сэдэвт сургалт семинарын үеэр олон улсын бага хурлаар боловсролын салбарт мэдээллийн технологийг нэвтрүүлэх бодлогын баримт бичгийн эхний хувилбарыг хэлэлцүүлэв. “Боловсролын салбарын шинэчлэл” болон “Санхүүгийн хямралын үед эмзэг бүлгийн иргэдэд боловсролын үйлчилгээг хүргэх” төслүүдийн хүрээнд хэрэгжих Боловсролын төлөвлөлт, удирдлага, төсвийг сайжруулах ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангах ажлын хэсгийг БСШУ-ны сайдын 2010 оны 521 дугаар тушаалаар байгуулан ажиллаж байна. Тус ажлын хэсгийн хуралдаанаар дээрх баримт бичгийг хэлэлцүүлсэн бөгөөд энэхүү бодлогын баримт бичиг нь боловсролын салбарт мэдээллийн технологийг нэвтрүүлэх 5 жилийн хугацаатай стратеги төлөвлөгөө юм.

Мэдээллийн технологид суурилсан боловсрол, соёл, шинжлэх ухааны үйлчилгээний нэгдсэн систем байгуулах үндэслэлийг стратеги төлөвлөгөөнд тусган Мэдээлэл, шуудан харилцаа холбоо, технологийн газраас 5 жилийн хугацаатай хэрэгжүүлэхээр боловсруулж байгаа “Цахим засаглалын мастер төлөвлөгөө” бодлогын баримт бичгийн төсөлтэй уялдуулан ажиллаж байна. “Төрийн байгууллагуудын дэд бүтцийг сайжруулах” төслийн хүрээнд Мэдээллийн технологид суурилсан боловсрол, соёл, шинжлэх ухааны үйлчилгээг иргэний бүртгэл, нийгмийн халамж, нийгмийн даатгал, төрийн сан зэрэг томоохон сүлжээтэй холбох саналыг боловсруулав. UNESCO–ийн Монголын үндэсний комисстой хамтран хэрэгжүүлж байгаа “Боловсролын нээлттэй эх”-ийн судалгааны багийн гишүүд олон улсын нээлттэй их сургуулиудийн судалгааг хийж, 2010 оны 10 дугаар сарын 14, 15-нд хэлэлцүүлэг зохион байгуулав. Мөн “Нээлттэй сургууль байгуулах боломж нөхцөл” сэдвээр зөвлөлдөх уулзалт зохион байгуулж, UNESCO–ийн Монголын үндэсний комисст тайлангаа хүргүүлээд байна.

Боловсролын салбарын мэдээллийн нэгдсэн сүлжээг үүсгэх ажлын бэлтгэл болгон Боловсролын өгөгдлийн төвийг яаман дээр байгууллаа. Тус төв нь 6 ширхэг application server, 2 ширхэг data server-тэй, 30 ТВ мэдээлэл хадгалах боломжтой юм. Мөн уг ажлын хүрээнд МХС ТӨК-тай шинэчлэн байгуулсан тоон урсгалын гэрээний дагуу 21 аймагт 21 E1, 44 суманд 22 E1 тоон урсгал шаардлагатай болсон бөгөөд одоо ашиглаж байгаа МХС ТӨК дээр байрлах Cisco 7606 рүтэр дээр 8 портын 4 E1–ийн карт байгаа нь нийтдээ 32 E1–ийн урсгал гаргах боломжтой тул БСШУ-ны сайдын 2010 оны 355 дугаар тушаалаар үүнд шаардагдах 30.0 сая төгрөгийн асуудлыг шийдвэрлэв. МХС ТӨК дээр

байрлах Cisco 7606 рүтэр дээр 8 портын 3 карт худалдан авах ажлыг яамны Төрийн нарийн бичгийн даргын 2010 оны 230 дугаар тушаалаар байгуулагдсан үнэлгээний хороо гүйцэтгэсэн болно. Мөн Боловсролын нэгдсэн сүлжээний төвийг Эрдэмнэт сүлжээний төв дээр төвлөрүүлж, үйл ажиллагааг тогтмолжуулах, өргөтгөл хийх талаар удирдах зөвлөлийн хурлыг зохион байгууллаа. Энэхүү сүлжээний төв нь Боловсролын салбарын мэдээллийн нэгдсэн сүлжээний дэд бүтцийг хариуцан ажиллах бөгөөд өгөгдөл нь шинээр байгуулагдсан яамны өгөгдлийн төв дээр байрлах юм.

Боловсролын салбарын удирдлага мэдээллийн шинэ систем Open EMIS программыг туршихын тулд программыг монгол хэлээр хөрвүүлэх, өөрийн орны боловсролын системд нийцүүлэх, гарын авлага боловсруулах зэргээр бэлтгэл ажлыг ханган Улаанбаатар, Дархан, Эрдэнэт, Төв аймгийн бүсийн удирдлагын сургалтыг 5 дугаар сарын 24-нөөс 26-ны өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгууллаа. Сургалтад 89 хүн оролцлоо. Тус сургалтаар программд мэдээлэл оруулах, бүртгэх, нэгтгэх ажлыг туршсан бөгөөд туршилтын үед гарсан алдаа дутагдыг нэгтгэн UNESCO-д хүргүүлэхийн сацуу Монгол талын зөвлөхүүдтэй хамтран программын засварыг хийж байна. Мөн Улаанбаатар хотын Баянзүрх дүүрэгт дата операторын сургалтыг зохион байгуулж, 44 хүнийг хамруулав. Баянзүрх дүүргийн сургууль, цэцэрлэгийн 2009-2010 оны хичээлийн жилийн мэдээллийг системд орууллаа. Түүнчлэн энэ ажлын хүрээнд сургалтад дээрх аймаг, дүүргийн 130 сургууль, 1200 багш, 18000 сурагчийн мэдээллийг системд оруулаад байна. Туршилтын үр дүнг тухай бүрд нь UNESCO-д хүргүүлэн ажиллаж байна. Дээрх туршилтаас үүдэн төслийн багийнхан Open EMIS программыг Монгол Улсын боловсролын системд тохируулан засварлах ажлаа дуусч, программ хангамжийг орчуулж эхлээд байна. Энэхүү программ хангамж нь систем болж, хараахан нэвтэрч чадаагүй, хугацаа хойшлогдсон нь ЮНЕСКО-ийн ажлын төлөвлөлтөөс хамаарсан болно

МХС ТӨК-аас тоон урсгалын үнэ бууруулсантай холбогдуулан БСШУЯ-ны удирдлагууд МХС ТӨК-ий удирдлагуудтай энэ оны 2 дугаар сард уулзалт зохион байгуулсан бөгөөд энэхүү уулзалтаар 2Mbps-ийн E1 урсгалыг бага хурдаар олон аймаг, сумд хуваан хэрэглэж байсан тоон урсгалыг өөрчлөн аймаг бүр 2Mbps хурдаар, сумын төвд 1Mbps-ийн хурдтай тоон урсгал түрээслэн ашиглахаар тохиролцлоо. Үүнээс үүдэн Улаанбаатар хот, аймгийн төвийн сургуулиудын шилэн кабелийн сувагчлалын, хөдөө орон нутгийн тоон урсгалын гэрээг МХС ТӨК-тай шинэчлэн байгуулав. Мөн сургуулиудын интернэт үйлчилгээний гэрээг MCS.COM ХХК, Орбитнэт ХХК-тай тус тус шинэчлэн байгуулан ажиллаж байна. Түүнчлэн Улаанбаатар хот болон 21 аймгийн төв, 44 суманд боловсролын дэд бүтэц нэрээр улсын төсвийн хөрөнгөөр байгуулсан шилэн кабелийн дэд бүтэц нь БСШУЯ –ны нэр дээр байгаа бөгөөд түүний ашиглалт үйлчилгээ, хяналт хамгаалалтыг нь бүрэн хариуцахад хүндрэлтэй байгаатай холбогдуулан дэд бүцийн хөрөнгийг төрийн компани болох МХС ТӨК–д хүлээлгэн өгөх саналыг Төрийн өмчийн хороонд хүргүүлээд байна. Энэхүү шалтгааны улмаас Улаанбаатар хотын 71, 13 дугаар сургууль болон нисэх, яармагийн чиглэлийн сургуулиуд, Баянгол дүүргийн Боловсролын хэлтэс, 38, 64, 113 дугаар сургуулиудын шилэн кабель гэмтсэнийг MCS электроникс ХХК–аар засварлууллаа.

Бага, суурь, бүрэн дунд боловсролын дүйцсэн хөтөлбөрийн 124 модулийн эхийг АББЗСҮТ-ийн [www.nfde.mn](http://www.nfde.mn) web.сайтад байршуулаад байна. Энэхүү модулийг манай улсын хэмжээнд ашиглагдаж байгаа хамгийн бага хурдтай интернетийн орчинд хүлээн авах боломжтой хийсэн нь давуу талтай болно. Эдгээр модуль нь бага, суурь, бүрэн

дунд боловсролын түвшинд албан бус боловсролын “Гэгээрэл” төвүүдэд суралцаж байгаа болон энэ чиглэлээр судалгаа хийж буй сонирхсон иргэдэд хэрэглэх боломжтой юм. Энэ сайтад орох хэрэглэгч чөлөөтэй бүртгүүлэх эрхтэй юм. Түүнчлэн дүйцсэн сургалтын хөтөлбөрийн 124 модулийг CD хэлбэрт оруулан 500 хувь хэвлэн орон нутаг хүргүүлээд байна. CD-ны онцлог нь компьютерийн анхан шатны мэдлэгтэй хүмүүс ашиглах бүрэн боломжтой юм. Мэдээллийг цахим хэлбэрээр цуглуулах арга зүйд сургах чиглэрээр сургалт зохион байгуулж, аймаг, сумдын албан бус боловсролын төвийн багш нарыг хамруулж, бага, суурь бүрэн дунд боловсролын дүйцсэн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх, онлайн хэлбэрээр сургалт явуулах арга зүйд сургалаа. Дүйцсэн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх, цахим мэдээллийн бааз цуглуулах серверийг Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Дата төвд байршууллаа. Онлайн сургалтын агуулгыг хэрхэн баяжуулах талаар аймаг, нийслэлийн Боловсрол, соёлын газрын арга зүйчдэд зориулсан сургалтыг 2010 оны 11 дүгээр сард зохион байгуулж, нийт 30 хүнийг хамрууллаа.

Яамны дата төв байгуулсантай холбоотой дотоод сүлжээг шилэн кабелиар татаж, интернэт тараах төхөөрөмжийг дата төвийн шинэ төхөөрөмж рүү шилжүүлэн байршуулж, түүний тохиргоо, нэгдсэн системийн тохиргоог хийгээд байна. Байгууллагын нууцыг хамгаалах зорилгоор энэхүү системийн хүрээнд цахим шуудангийн үйлчилгээ, дотоод мессенжер болон хэрэглэгчийн нууц үгийг 30 хоноод сольж байхаар тохируулав. Цахим хуудсыг шинэчлэх хөрөнгийн асуудлыг Боловсролын төвлөрсөн арга хэмжээний төсвөөс санхүүжүүлэхээр БСШУ-ы сайдын 2010 оны 163 дугаар тушаалаар шийдвэрлэв. Гүйцэтгэгч байгууллагыг яамны Төрийн нарийн бичгийн даргын 2010 оны 117 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг сонгон шалгаруулсан бөгөөд шалгаруулалтад тэнцсэн Метавайс ХХК-тай 10/04 тоот гэрээ байгуулан ажиллаж байна. Одоогийн байдлаар цахим хуудасны загвар бэлэн болсон бөгөөд программчилж дуусаад [www.edu.gov.mn](http://www.edu.gov.mn) хаяг дээр байрлуулаад байна. Шинээр нэмэгдэх мэдээ мэдээллийг хуучин цахим хуудастай хамтад нь байршуулж байна. Энэ цахим хуудас нь үндсэн цахим хуудаснаас гадна Боловсрол,соёл, шинжлэх ухаан, танин мэдэхүй чиглэлийн 3 интерактив хуудастай юм.

### ***Салбарын үйл ажиллагааг мэдээлэх, сурталчлах талаар багагүй ажил хийлээ.***

Салбарын онцлог үйл ажиллагааны талаарх нийт 109 удаагийн үйл явдлыг 15 телевиз, өдөр тутмын 12 сонин, 4 гол сайтаар давхардсан тоогоор 3379 удаа олон нийтэд мэдээлээд байна. Салбарын шинэчлэлтэй холбоотой төрийн өмчийн их, дээд сургуулийн бүтцийн өөрчлөлт, оюутны хотхон байгуулах, Кембриджийн стандартыг нэвтрүүлэх, цэцэрлэгийн барилгыг канад технологиор барих, соёлын өвийг хадгалах, хамгаалах тэдгээрийг ЮНЕСКО-д бүртгүүлэх зэрэг асуудлыг олон нийтэд тайлбарлан таниулахад анхаарч ажиллалаа. Энэ ажлын дүнд иргэд, олон нийт дээрх үйл ажиллагааны талаар бодит зөв ойлголттой болсон юм.

Хэвлэл мэдээллийн 14 байгууллагатай салбарын үйл ажиллагааг сурталчлах гэрээ байгуулан ажиллаж байна. Гэрээний үр дүнд салбарын мэдээллийг олон нийтэд хүртээмжтэй, түргэн шуурхай, тасралтгүй үнэн зөв, бодитойгоор хүргэх нөхцөлийг бүрдүүлж байна. Салбарын цаг үеийн онцлог үйл явдлын талаар 62 удаа хэвлэлийн бага хурал зохион байгууллаа. Боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарын асуудлаар

зохион байгуулж байгаа хэвлэлийн бага хурлыг дийлэнх мэдээллийн хэрэгсэл тогтмол сурвалжилж, олон нийтэд хүргэх ажиллагаа тогтмолжоод байна.

“Салбарын онцлох 10 үйл явдал”, Багш нарын баярт зориулсан сонины нүүрийг тус тус бэлтгэж, “Өнөөдөр”, “Зууны мэдээ”, “Үндэсний шуудан” сонинд нийтлүүлэн салбарын ажлыг олон нийтэд үнэн зөв мэдээллийг хүргэж ажиллалаа. Тухайлбал, “Өнөөдөр” сонины 2010 оны 1 дүгээр сарын 4-ний өдрийн №001, 2010 оны 2 дугаар сарын 5-ны өдрийн № 030-031, “Зууны мэдээ” сонины 2010 оны 1 дүгээр сарын 4-ний өдрийн №01, 2010 оны 2 дугаар сарын 5-ны өдрийн №030, “Үндэсний шуудан” сонины 2010 оны 2 дугаар сарын 5-ны өдрийн №030 сонинд тус тус нийтлүүлээд байна. “Өдрийн сонин”-ы “Асуух эрхийн танхим” булангийн ярилцлагад сайд Ё.Отгонбаяр, Мэргэжлийн боловсролын газрын дарга М.Баасанжав, Ерөнхий боловсролын газрын дарга Д.Эрдэнэчимэг, Боловсролын үнэлгээний төвийн захирал Б.Энхбат нар оролцлоо.

Нийслэлийн 36 сургуулийн 14.0 мянган сурагчийг хамарсан “Бид эх орноороо бахархдаг” аяны тухай 20 минутын нэвтрүүлэг бэлтгэж, МҮОНТВ, UBS, TV-5, TV-25, TV-9 телевиз тус бүрт 2 удаа давталттайгаар 10 удаа нэвтрүүлээ.

Боловсрол, соёлын тулгамдсан асуудал” сэдэвт сургалт семинарыг 2010 оны 1 дүгээр сард зохион байгуулж, хэвлэл, мэдээллийн байгууллагын сэтгүүлчдийг оролцуулаа. Хэвлэл, мэдээллийн тухайн байгууллагын боловсрол, соёлын асуудал хариуцсан сэтгүүлчдийг салбарын мэдээллээр хангах, тэднийг тухайн салбарын чиглэлээр мэргэшүүлэхэд зохих үр дүнгээ өгөв.

DVD, фото болон бусад хэлбэрээр фондлох ажил хийгдлээ. Энэ ажлын хүрээнд фото болон дүрстэй мэдээллийн санг баяжуулан салбарын мэдээллийг төрөлжүүлж байна. Тухайлбал, мэдээллийг DVD хальсаар болон фото хэлбэрээр компьютерт, 14 DVD хальс, 100 гаруй фотог фондод хадгалж байна.

## **Долоо. Гадаад хамтын ажиллагааны талаар**

Боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарын хамтын ажиллагааг өргөтгөх чиглэлээр 2010 онд 12 улс оронтой 29 гэрээ, хэлэлцээр, санамж бичиг, төлөвлөгөө байгууллаа. Эдгээрийн 5 нь Засгийн газар хоорондын, 24 нь яам болон байгууллага хоорондынх байна. Байгуулсан баримт бичгийн заримаас дурдвал: Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын Боловсролын үнэмлэх, эрдмийн зэргийн гэрчилгээг харилцах хүлээн зөвшөөрөх тухай хэлэлцээрийг сэргээж, түүнд нэмэлт, өөрчлөх тухай протоколыг 2010 оны 6 дугаар сарын 1-ний өдөр байгуулсан. Протоколыг байгуулснаар хоёр тал ерөнхий боловсролын гэрчилгээ, тусгай мэргэжлийн дунд сургууль, дээд боловсролын сургуулиас олгосон үнэмлэх, эрдмийн зэргийн гэрчилгээг харилцан хүлээн зөвшөөрөх эрхзүйн таатай орчин бүрдэв.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 5 дугаар сард БНХАУ-д хийсэн айлчлалын үеэр “Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд 2010-2013 онд хэрэгжүүлэх соёлын солилцооны төлөвлөгөө” батлав. Энэхүү төлөвлөгөө ёсоор номын сан, музей, театр, цирк, балет, кино зэрэг соёл, урлагийн байгууллага хоорондын солилцоо, хамтын ажиллагааг харилцан дэмжих, соёл, урлагийн салбарын мэргэжилтэн, уран бүтээлчдийг харилцан солилцох, соёлын үнэт

зүйлсийг хадгалах, сэргээн засварлах чиглэлээр Хятадын талтай хамтран ажиллахаар тохиров. Мөн Монголын Соёлын өдрүүдийг Бүгд Найрамдах Хятад Ард Улсад, Хятадын Соёлын өдрүүдийг Монгол Улсад зохион байгуулах боломжийг судалж, харилцан Соёлын өдрүүдийг зохион байгуулах талаар Санамж бичиг байгуулахаар болов.

Соёлын төв харилцан байгуулах тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрт гарын үсэг зурав. Хэлэлцээрийн дагуу Талууд тус тусын Соёлын төвийг нөгөө Талынхаа нутаг дэвсгэрт байгуулахаар тогтсон. Монгол Улс дахь Хятадын Соёлын төвийн үйл ажиллагааг Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Соёлын яам хариуцах бөгөөд Бүгд Найрамдах Хятад Ард Улс дахь Монголын Соёлын төвийн үйл ажиллагааг манай яам хариуцна. Хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 248 дугаар тогтоолоор баталсан болно. БСШУ-ы сайдын Холбооны Бүгд Найрамдах Герман Улсад 2010 оны 2 дугаар сард хийсэн ажлын айлчлалын үеэр Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Германы Эрдмийн солилцооны алба хоорондын хамтарсан “Монгол-Германы хамтарсан тэтгэлэгт хөтөлбөр хэрэгжүүлэх хэлэлцээр” байгуулахаар тохирсон бөгөөд энэхүү хэлэлцээрт 2010 оны 6 дугаар сард гарын үсэг зурж баталгаажуулав.

БСШУ-ы сайдын Холбооны Бүгд Найрамдах Герман Улсад 2010 оны 2 дугаар сард хийсэн ажлын айлчлалын үеэр Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам,



Германы Эрдмийн солилцооны алба хоорондын хамтарсан “Монгол-Германы хамтарсан тэтгэлэгт хөтөлбөр хэрэгжүүлэх хэлэлцээр” байгуулахаар тохирсон бөгөөд энэхүү хэлэлцээрт 2010 оны 6 дугаар сард гарын үсэг зурж баталгаажуулав. Хөтөлбөрийг гурван жилийн хугацаанд хэрэгжүүлэх бөгөөд нийт 80 монгол оюутныг ХБНГУ-ын их, дээд сургуульд инженерийн болон байгалийн ухааны чиглэлээр суралцуулах юм. 2010-2011 оны хичээлийн жилд Монгол-Герман хамтарсан тэтгэлгийн хөтөлбөрийн хүрээнд 20 хүнийг /10

бакалавр, 10 магистр/ ХБНГУ-ын их, дээд сургуульд суралцуулахаар шийдвэрлэсэн бөгөөд энэ онд эхний 17 суралцагчийг сонгон шалгаруулж илгээлээ.

Монгол, Солонгосын Боловсрол, шинжлэх ухаан, технологийн хамтарсан комиссын хуралдааныг 9 дүгээр сарын 6-8-ны өдрүүдэд зохион байгуулав. Комиссын хуралдааныг Монголын талаас Монгол Улсын



Боловсрол, соёл, шинжлэх ухааны дэд сайд Ч.Куланда, Солонгосын талаас БНСУ-ын Боловсрол, шинжлэх ухаан, технологийн дэд сайд Ким Чан Гёон нар ахлав. Анхдугаар хуралдааны үеэр Талууд хүний хөгжил, байгалийн нөөцийн хамгаалалт, ашиглалт, хөдөө аж ахуй, өндөр технологи, мэдээллийн технологи салбаруудад хамтарсан төсөл хэрэгжүүлэх, өндөр мэргэшсэн судлаач бэлтгэх, нарийн мэргэжлийн эрдэмтэн, судлаач солилцох, эрдэм шинжилгээний бага хурал,

симпозиум, ярилцлага зохион байгуулах, эрдэм шинжилгээний байгууллагын лаборатори, туршилт, сорилтын баазыг бэхжүүлэх, инновацийн дэд бүтцийн элементүүдийг байгуулах зэргээр хамтран ажиллахаар болов. Хуралдааны үеэр Монгол-Солонгосын боловсрол, шинжлэх ухаан, технологийн форум, эрдэм шинжилгээний хурал зохион байгуулсан. Форумд боловсролын салбарын хамтын ажиллагаа, шинжлэх ухаан, технологи, инноваци, төр-эрдэм шинжилгээ-бизнесийн түншлэлийн талаар хэлэлцүүлэг хийв. Мөн хамтарсан хуралдааны үеэр Монгол, Солонгосын эрдэм шинжилгээний хурлыг тогтмол зохион байгуулж байхаар тохиролцон 2011 онд “Боловсрол, шинжлэх ухаан, технологийн судалгааны удирдлагын шинэчилсэн тогтолцоог бүрдүүлэх нь” сэдвээр Бүгд Найрамдах Солонгос Улсад зохион байгуулах тохиролцоонд хүрэв. Хуралдаанаар хоёр улсын боловсрол, шинжлэх ухаан, технологийн салбарын хамтын ажиллагааны явцын талаар харилцан санал солилцож, хоёр орны хамтын ажиллагааны хэтийн төлөвийн талаар хэлэлцэн, 2010-2012 онуудад хамтран ажиллах Протоколыг байгуулав. Энэхүү Протоколд Монгол, Солонгосын Боловсрол, шинжлэх ухаан, технологийн хамтарсан комиссын хуралдааныг 2 жилд нэг удаа Монгол Улс, БНСУ-д ээлжлэн зохион байгуулах ба боловсрол, шинжлэх ухаан, технологийн салбарт хамтран ажиллах шинэ чиглэл, хэлбэрүүдийн талаар санал дэвшүүлж, хэлэлцүүлэн дүгнэлт гаргаж байхаар тогтов.

2010 оны 7 дугаар сард “Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Бүгд Найрамдах Буриад Улсын Боловсрол, шинжлэх ухааны яам хоорондын 2011-2013 онд хамтран ажиллах тухай протокол”-д гарын үсэг зурав. Энэхүү Протоколд Талууд боловсрол, шинжлэх ухааны салбар дахь урт хугацааны, үр дүнд чиглэсэн харилцааг хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор хамтын ажиллагааны үндсэн чиглэлүүдийг тохирч, улсын болон орон нутгийн боловсролын салбарын удирдах байгууллага, мэргэжилтэн, эрдэм шинжилгээний ажилтанг харилцан солилцож байхаар тохиролцов.

## **Найм. Төрийн захиргааны удирдлагын талаар**

***Яамны 2010 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан баталж, хэрэгжилтийг зохион байгуулав.***

Салбарын эрх зүйн тогтолцоог бүрдүүлж байгаа хууль тогтоомж, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2009 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны үйл ажиллагааны дунд хугацаа /2009-2012 он/-ны төлөвлөгөө зэргийг үндэс болгон яамны үйл ажиллагааны 2010 оны төлөвлөгөөг боловсруулан Төсвийн ерөнхийлөн захирагч, яамны Ерөнхий менежерийн үр дүнгийн гэрээний хавсралт болгон батлуулж хэрэгжүүлэв. Төлөвлөгөөнд 8 ангийн 30 бүтээгдэхүүний хүрээнд 373 арга хэмжээг гүйцэтгэхээр тусгагдсан болно.

Төсвийн ерөнхийлөн захирагч, яамны Ерөнхий менежертэй байгуулсан үр дүнгийн гэрээ, яамны үйл ажиллагааны 2010 оны төлөвлөгөөг баримтлан Ерөнхий менежер нэгжийн менежерүүдтэй, нэгжийн менежер албан хаагч нартай үр дүнгийн гэрээ байгуулах ажлыг зохион байгуулав. Ийнхүү яамны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан бүх ажлыг хариуцах эзэнтэй болгож, хэрэгжилтийн явцад тогтмол хяналт тавьж ирлээ. Тухайлбал, яамны 2009 оны тайлангийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлгэн дүнгийн хамт Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт тогтоосон хугацаанд нь хүргүүлсэн болно. Түүнчлэн 2010 оны төлөвлөгөөний улирлын болон хагас жилийн биелэлтийн явцыг хамт олны, нэгжийн дарга нарын зөвлөлийн хуралд танилцуулж,

мэдээлэл хийн анхаарах зарим асуудлыг тодорхойлон газар, хэлтсийн дарга, ажилтнуудад Төрийн нарийн бичгийн дарга үүрэг даалгавар өгч байлаа. Нэгдүгээр улирлын төлөвлөгөөний явцыг гарган дүн шинжилгээ хийсний үндсэн дээр “Ажил эрчимжүүлэх, гүйцэтгэлийн хяналтыг сайжруулах тухай” Төрийн нарийн бичгийн даргын албан бичгийг газар хэлтсийн дарга нарт өгч төлөвлөгөөний биелэлтийн эхний улиралд биелэлт нь тааруу байгаа ажлыг хугацаанд нь биелүүлэх, хоцорч явааг нь шуурхай нөхөж гүйцэтгэх талаар нэгж дээрээ шүүн хэлэлцэж, хариуцсан мэргэжилтэн нарт зохих дэмжлэг тусалцаа үзүүлэх, шаардлага гарвал яамны удирдлагад танилцуулж шийдвэрлүүлэх арга хэмжээ авахыг даалгасан болно. Мөн яамны төлөвлөгөөт ажлын болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2010 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн II улирлын дүн, хугацаатай албан бичиг, иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлын биелэлтийг яамны ажилтнуудын зөвлөгөөнөөр хэлэлцүүлж хоцорч байгаа ажлын талаар анхааруулга, санамж өгөв. Яамны үйл ажиллагааны сар бүрийн мэдээллийг бэлтгэн Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт тогтмол мэдээлж ирсний зэрэгцээ түүнийг олон нийтэд нээлттэй, ил тод байлгах үүднээс яамны цахим хуудсанд байнга байршуулж байлаа. Яамны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийн дүнг нэгжийн дарга нарын зөвлөлийн хурлаар хэлэлцсэн дүнг үндэслэн “Ажлын зохион байгуулалт, хариуцлагын тухай” Төрийн нарийн бичгийн даргын 2010 оны 305 дугаар тушаал гаргаж газар, хэлтсийн дарга нарт дараахь үүрэг даалгавар өгсөн:

- ✓ Боловсрол, соёл, шинжлэх ухааны төсвийн Ерөнхийлөн захирагч, яамны Ерөнхий менежерийн 2010 оны үр дүнгийн гэрээ, үйл ажиллагааны төлөвлөгөө, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2010 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан арга хэмжээ бүрийн биелэлтийг нягтлан үзэж, хугацаа хоцорсон, хэрэгжилтийн явц, бодит үр дүн хангалтгүй байгаа ажлуудыг шуурхай гүйцэтгэх удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авч гүйцэтгэлийг бүрэн хангах;
- ✓ Нэгжийн төлөвлөгөөт ажлын гүйцэтгэлийг хангахад албан хаагчдад мэргэжлийн түвшний удирдлага, манлайллын дэмжлэг үзүүлэх, зөвлөгөө өгөх, нэгжийн улирлын болон сарын үйл ажиллагааны мэдээг биечлэн хянаж Төрийн захиргааны удирдлагын газарт хүлээлгэн өгөх үйл ажиллагааг хэвшүүлэх.

1. Мөн энэ тушаалаар яамны төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчдад дараахь зүйлийг үүрэг болгов:

- Дотоод, гадаадад томилолтоор ажиллах, эмнэлэгт хэвтэж эмчлүүлэх, ээлжийн амралт эдлэх хугацаандаа хариуцсан ажлаа орлон гүйцэтгэх ажилтныг Төрийн захиргааны удирдлагын газар болон нэгжийн даргатайгаа тохирох, холбогдох мэдээлэл, баримт бичгийг үлдээх зохион байгуулалтын арга хэмжээ авч хэвших;
- Гадаад оронд томилолтоор ажиллах хугацаандаа туршлага судалсан, танилцсан, сурч мэдсэн зүйлээ томилолтоос ирснээс хойш 7 хоногт багтаан дотоод сүлжээ ашиглан яамны хамт олонд мэдээлэх, нэгжийн дарга нарын зөвлөлийн хуралд танилцуулах ажлыг тогтмолжуулах;

- Хариуцсан ажлаа төлөвлөх, биелүүлэх, тайлагнах ажлыг салбарын хэмжээний эрх зүйн болон бодлогын баримт бичигт тулгуурлан мэргэжлийн түвшинд чанартай боловсруулах чадвараа тасралтгүй дээшлүүлэх;
- Яамны албан хэргийг холбогдох хууль тогтоомжоор тогтоосон стандартын дагуу хөтөлж хэвших, эрхэлсэн ажлын чиглэлээр эрх зүй, бодлогын баримт бичгийн үндсийг боловсруулах чадвараа байнга дээшлүүлж ажиллах;
- Байгууллагын албан бичиг, иргэдийн өргөдөл, гомдол, санал хүсэлтийг барагдуулахад харилцан зөвлөх, туслах замаар түүнд бодитой, үндэслэлтэй хариу өгч гүйцэтгэлийн тооцоог яамны бичиг хэрэгтэй тухай бүрд нь хийж байх үйл ажиллагааг чанд мөрдөж ажиллах;
- Нэгж, албан хаагчдын хооронд мэдээлэл солилцох, багаар ажиллах, байгууллагын соёлыг дээшлүүлэх, төрийн албаны ёс зүй манлайллыг хангахад албан хаагч бүр идэвх, санаачилга гарган ажиллах.

Мөн Төрийн захиргааны удирдлагын газрын даргад “ажлын идэвх, санаачилга хангалтгүй, зохион байгуулалтын тодорхой арга хэмжээ аваагүйгээс төлөвлөгөөт ажлыг хугацаанд нь чанартай, бүрэн хэрэгжүүлээгүй нэгжийн дарга, мэргэжилтэн нарт авах арга хэмжээний саналыг улирал тутам танилцуулж ажиллахыг үүрэг болгов.

Ийнхүү ажлын гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулах арга хэмжээ авсны үрээр 3 дугаар улирлын байдлаар 77.52 хувийн биелэлттэй байсан яамны төлөвлөгөөний гүйцэтгэл жилийн дүнгээр 91,98 хувь болж тавьсан зорилтоо үндсэн нь ханган биелүүллээ.

Яамны жилийн ажлыг дүгнэхдээ газар, хэлтсийн үйл ажиллагааны болон үр дүнгийн гэрээний биелэлтийн жилийн тайланг гаргуулж, нэгж тус бүрийн тайланг энэ оны 12 дугаар сарын 27-ны өдөр зохион байгуулсан яамны нийт хамт олны хурлаар хэлэлцүүлсэн нь нэгжүүдийн хооронд мэдээлэл солилцох, ажлаа оновчтой, товч тодорхой тайлагнах шинэ хэлбэрийн ажил боллоо.

Яамны ажлын төлөвлөгөөний биелэлтийг дараахь хүснэгтээр нэгтгэн гаргаж үзүүлэв:

Биелэлтийн хувь	Биелэлт /%/							Дүн
	0	10	30	50	70	90	100	
Арга хэмжээний тоо	1	1	14	11	23	47	268	365

Засгийн газрын 2009 оны 1 дүгээр тогтоолоор батлагдсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарын чиглэлээр тусгагдсан зорилт, үйл ажиллагааг яамны 2010 оны ажлын төлөвлөгөөнд тусган хэрэгжилтийг зохион байгуулахад анхаарч газар, хэлтэст тухай бүр чиглэл өгч зохион байгуулалтыг хангаж ажиллалаа. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 42 зорилтын хүрээнд нийт 129 арга хэмжээг тус яам хариуцан хэрэгжүүлэх бөгөөд эдгээрийн 125-ыг энэ онд хэрэгжүүлж байхаар төлөвлөгдсөн юм. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг хагас, бүтэн жилээр гаргаж Засгийн газрын Хэрэг

эрхлэх газарт, Эдийн засаг, нийгмийг 2010 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийг улирал тутам нэгтгэн гаргаж Үндэсний хөгжил шинэтгэлийн хороонд тус тус мэдээлж ирлээ. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан энэ онд хэрэгжилтийг дүгнэвэл зохих 125 арга хэмжээний биелэлт энэ оны эцсийн байдлаар 58.56 хувь байгаа нь хангалттай үзүүлэлт байна. Үүнийг дараахь хүснэгтээр нэгтгэн үзүүлэв:

	Биелэлт /%/							Дүн
	0	10	30	50	70	90	100	
Биелэлтийн хувь	0	10	30	50	70	90	100	58.56%
Арга хэмжээний тоо	5	9	19	47	38	5	12	125

Харин эдийн засаг, нийгмийг 2010 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан 60 арга хэмжээ байна. Үүний биелэлтийг дараахь хүснэгтээр үзүүлэв:

	Биелэлт /%/							Дүн
	0	10	30	50	70	90	100	
Биелэлтийн хувь	0	10	30	50	70	90	100	90.33%
Арга хэмжээний тоо	2	-	2	-	4	12	40	60

Түүнчлэн холбогдох байгууллагын хүсэлтийн дагуу Монгол Улсын Ерөнхий сайд С.Батболдын толгойлсон Засгийн газрын 1 жилийн хугацаанд тус яамнаас зохион байгуулж, хэрэгжүүлсэн ажлын тайланг гаргаж Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт, “МАН/МАХН/, АН-ын хамтран ажиллах гэрээний боловсрол, соёл, шинжлэх ухааны зорилтын хэрэгжилт” тайланг бэлтгэн УИХ дахь эдгээр намын бүлэгт, “УИХ-ын 2008 оны сонгуульд МАХН-аас оролцсон мөрийн хөтөлбөрийн 2009 оны биелэлт”-ийн тайланг гаргаж УИХ дахь МАХН-ын бүлэгт, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний гүйцэтгэл нь хангалтгүй байгаа боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарын зорилт, үйл ажиллагааны судалгаа, гүйцэтгэлийн 2010 оны хагас жилийн тайланг гаргаж Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт тус тус хүргүүлэв.

### ***Салбарын шагналын журмыг шинэчлэв.***

Боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарын шагналын журмыг шинэчлэн боловсруулж, “Журам, бүрэлдэхүүн батлах тухай” БСШУ-ы сайдын 2010 оны 451 дүгээр тушаалаар батлан, 2010 оны 12 дугаар сарын 1-ний өдрөөс хэрэгжүүлж эхэллээ. Уг журмаар салбарын тэргүүний ажилтан тэмдэг болон яамны шагналын болзол шалгуурт зарим тодорхой өөрчлөлт оруулж, шагналд нэр дэвшүүлэх, баримт бичиг бүрдүүлэх, түүнийг хүлээн авах, судлан шийдвэрлэх механизм, хугацааг тодорхой болгож, мэдээллийн сан бүрдүүлэх, цахим хэлбэрээр баримт авах боломжийг бий болгож, шагналын баримт бичгийг хуурамчаар бүрдүүлэх оролдлогыг хаах, бүрдүүлсэн тохиолдолд хариуцлага тооцох зохицуулалтыг шинээр бий болгов.

Тайлангийн хугацаанд салбарын зарим байгууллагын их, тэгш ой, багш нарын болон соёл, шинжлэх ухааны ажилтны өдөр, ахмад настны баярыг тохиолдуулан салбарын шагналд нэр дэвшүүлж ирүүлсэн хүмүүсээс “Боловсролын тэргүүний ажилтан” хүндэт тэмдгээр 1769, “Соёлын тэргүүний ажилтан” хүндэт тэмдгээр 388, “Шинжлэх ухааны тэргүүний ажилтан” хүндэт тэмдгээр 96, “Хүндэт Жуух бичиг-ээр 1112, “Тэргүүний ардын авьяастан” хүндэт тэмдгээр 195, “Үндэсний бичиг үсгийг дэлгэрүүлэгч” тэмдгээр 13 албан хаагч, иргэнийг шагнаж урамшуулав.

***Яамны хүний нөөцийн хөгжлийн стратеги төлөвлөгөө /2010-2015 он-г боловсруулан баталж, хэрэгжүүлж эхэллээ.***

Байгууллагын болон хүний нөөцийн менежментийн сурах бичиг, ном, гарын авлага болон дотоод, гадаадын ижил төстэй байгууллагын хүний нөөцийн хөгжлийн стратеги төлөвлөгөөг судалж, тэдгээрт дүн шинжилгээ хийх замаар яамны хүний нөөцийн хөгжлийн стратеги төлөвлөгөө боловсруулан баталж, Төрийн нарийн бичгийн даргын 2010 оны 264 дүгээр тушаалаар батлан хэрэгжүүлж эхэллээ. Энэхүү төлөвлөгөө батлагдсанаар яамны эрхлэх асуудлын чиг үүрэгтэй уялдан хүний нөөцийн хангалт, хөдөлгөөний зохицуулалтыг оновчтой болгох, албан хаагчдын сургалт, нийгмийн баталгааг хангах эрх зүйн орчин бүрдэж байгаа болно. Уг төлөвлөгөөний дагуу яамны хүний нөөцийн бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэх, яамны үйл ажиллагааны ил тод байдлыг хангах, аппаратын ажилтан нарыг гадаад, дотоодод сургалтад хамруулж мэргэжлийг нь дээшлүүлэх, ажилтан нарын ажлын байрны орчин нөхцөлийг сайжруулах, зарим ажилтны нийгмийн баталгааг хангах зорилгоор орон сууцтай болоход нь зориулж мөнгөн тусламж үзүүлэх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүллээ. Тухайлбал, яаманд ажиллуулах хүмүүсийн бүртгэл мэдээллийн санд 90 хүнийг бүртгэсний зэрэгцээ 1 албан хаагчийг докторын зэрэг хамгаалах шалгалт өгөх, 6 ажилтанд англи хэлний мэдлэгээ дээшлүүлэх сургалтын төлбөрийг буцалтгүй тусламжаар олгох, АНУ, Австрали Улсад тус бүр 1 ажилтныг мэргэжлийн нь дагуу магистрантурт суралцуулах, Удирдлагын академийн “ГАРАГ”-ийн сургалтад 1 мэргэжилтнийг суралцуулах, эрхэлсэн ажлын чиглэлээр давхардсан тоогоор дотоодын сургалтад 20, гадаадын сургалтад 38 албан хаагчийг хамруулах зэргээр ажилтан нарыг чадваржуулах арга хэмжээ авч хэрэгжүүлэв. Яамны албан хаагчдын өрөө тасалгааг засварлах, ус шүүгч, агаар цэвэршүүлэгч, зарим тавилгаар хангахад 10.6 сая, албан хаагчдын компьютерийг шинэчлэхэд 73.4 сая төгрөг, принтерийг шинэчлэхэд 8.8 сая, албан бичгийн хэрэгсэл, бичгийн цаас, принтерийн хор, хувилагчийн хор, факсын цаасаар хангахад 9.7 мянган төгрөгийг тус тус зарцууллаа. Уулзалтын болон хурлын өрөөг засч тохижуулав.

***Яамны албан хаагчдын хөдөлгөөний тайлан, тоо бүртгэлийн мэдээ, хөрөнгө оруулгын мэдүүлэг гаргах ажлыг зохион байгуулж холбогдох байгууллагад тогтоосон хугацаанд нь хүргүүлэв.***

Төрийн албаны зөвлөлийн шинэчилсэн программын дагуу Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны болон харьяа байгууллагын төрийн албан хаагчдын хөдөлгөөний тайлан, тоо бүртгэлийг 2009 оны жилийн эцсийн байдлаар гаргаж, Төрийн албаны зөвлөлд 2010 оны 2 дугаар сард хүргүүлсний зэрэгцээ яамны болон харьяа байгууллагын 149 төрийн албан хаагчийн 2009 оны хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд нь хүлээн авч, нэгдсэн мэдээ гарган 2010 оны 2 сард Авлигатай тэмцэх газарт илгээв. Хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд, үнэн зөв бөглөх талаар зөрчил гараагүй болно. Албан хаагчдын хөрөнгө орлогын мэдүүлгийг зохих журмын дагуу хадгалах, улирал бүрийн тайланг гарган Авлигатай тэмцэх газарт хүргэх арга хэмжээ авч ажиллалаа.

***Авилгаас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх 2010 оны төлөвлөгөөг батлан хэрэгжүүлэв.***

Холбогдох хууль тогтоомжийг дагуу боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарын авлигаас урьдчилан сэргийлэх, авлигатай тэмцэх 2010 оны төлөвлөгөөг боловсруулан “Төлөвлөгөө батлах тухай” Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2010 оны 88 дугаар тушаалаар батлан хэрэгжүүллээ. Төлөвлөгөөнд 6 зорилт, 4 зарчим, 59 арга хэмжээг тусган хэрэгжүүллээ. Журмын дагуу Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Авлигатай тэмцэх газарт энэхүү төлөвлөгөөг 2010 оны 3 сард хүргүүлсэн болно.

### ***Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэх асуудлын төлөвлөн гүйцэтгэлийг зохион байгууллаа.***

Салбарын үйл ажиллагаанд мөрддөг хууль тогтоомж, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, эдийн засаг, нийгмийг 2010 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, эрх бүхий байгууллагаас баталсан шийдвэр, холбогдох гэрээ, хэлэлцээр, яамны үйл ажиллагааны 2010 оны төлөвлөгөөг үндэслэн тус яамнаас 2010 онд Засгийн газрын хуралдаанаар 20 асуудал хэлэлцүүлэхээр төлөвлөж, хэрэгжилтийг хангах арга хэмжээ авлаа. Түүнчлэн Монгол Улсын Ерөнхий сайдын баталсан Засгийн газрын хуралдаанаар 2010 онд хэлэлцэх төлөвлөгөөнд Улсын Их Хурлаас даалгасан 1, Ерөнхийлөгчөөс даалгасан 1, Засгийн газрын хуралдаанаас даалгасан 6 асуудал тусгагдсан юм. Ийнхүү төлөвлөсөн асуудлаас 14 асуудлыг зохих журмын дагуу бэлтгэн хэлэлцүүлэв. Оны эцсийн байдлаар 4 асуудал Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хуралдаанд оруулахаар хүлээгдэж байгаа бөгөөд 8 асуудлыг хэлэлцүүлэх боломжгүй болсон учир хасуулах санал өгсөн болно. Төлөвлөгөөнд тусгагдаагүй боловч цаг үеийн шаардлагаар яамнаас санаачлан 22 асуудлыг нэмж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн зохих шийдвэр гаргуулсан байна.

### ***Төрийн бус байгууллагатай хамтын ажиллагаагаа өргөжүүлэв.***

Тайлангийн хугацаанд тус яам дор дурдсан төрийн бус байгууллагатай тодорхой чиглэлээр хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллалаа:

- 1.Иргэний нийгмийн зөвлөл /2009-2012 онд хамтран ажиллах Санамж бичиг /
- 2.Монголын багш нарын холбоо
- 3.Монголын оюутны холбоо
- 4.Багшийн хөгжлийг дэмжих нийгэмлэг
- 5.Монголын Урлагийн зөвлөл
- 6.Монголын уртын дууны холбоо
- 7.Ахмад багш нарын холбоо
- 8.Монголын бага, дунд боловсролын хөгжлийг дэмжих нийгэмлэг
- 9."Эмнести интернэйшл" ТББ
- 10.Монголын залуу эрдэмтэдийн холбоо
- 11.Монголын Скаутын холбоо.

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2010 оны 140 дүгээр тушаалаар салбарын хүрээнд үйл ажиллагаа явуулдаг төрийн бус болон Иргэний нийгмийн байгууллагатай хамтран ажиллах ажлыг зохицуулж, удирдлагаар хангах ажлын хэсгийг Боловсрол, соёл, шинжлэх ухааны дэд сайдаар ахлуулан ажиллав. Хамтын ажиллагааны хүрээнд зохион байгуулсан зарим ажлаас товчлон дурдвал: Багшийн хөгжлийг дэмжих нийгэмлэгтэй хамтран бүтээлч багш хөдөлгөөнийг 2010 оны 4 дүгээр

сарын 23-ны өдрөөс 5 дугаар сарын 22-ны өдөр хүртэл өрнүүлж, ЕБС-ийн багш нарын дунд уралдаан зарлаж, ирүүлсэн бүтээлийн төрөл бүрээр шалгаруулалт хийж, шалгарсан бүтээлээр Занабазарын нэрэмжит музейд 2 өдөр үзэсгэлэн гаргаж нийтийн хүртээл болгосон нь багш нарын ур чадварыг нийтэд сурталчилж, урам өгсөн ажил байлаа. Улаанбаатар хотын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилго бүхий “МӨРӨӨДЛИЙН СУРГУУЛЬ-НОГООН ТӨГӨЛ” байгуулах асуудлаар Солонгосын “Ногоон-Ази” ТББ-ын Монгол дахь төлөөлөгчийн газар, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, нийслэлийн Боловсролын газар, Монгол-Солонгосын хүүхэд залуучуудын хамтарсан байгаль хамгаалах сантай хамтран төслийн удирдамжийг боловсруулан хамтын үйл ажиллагаа явууллаа. Төслийн гурван талт санамж бичгийг 2010 оны 5 дугаар сарын 28-нд үзэглэж, төсөл 2010 оны 5-6 дугаар сард хэрэгжсэн юм. Тус яам төрийн бус байгууллагатай хамтран аймаг, нийслэлийн Боловсрол, соёлын газрын албан бус боловсролын аргазүйчдийн нэгдсэн сургалтыг явуулж, сургууль завсардсан болон сургуулийн гадна буй хүүхдүүдэд боловсрол нөхөн олгоход албан бус боловсролын багш нарын арга зүйд хүүхдийн эрхийг ханган ажиллахад анхаарах нь сэдвээр ярилцлаа. Улаанбаатар хотын бүх дүүргийн албан бус боловсролын багш нарыг нэгдсэн сургалтад 2010 оны 9 дүгээр сард хамрууллаа.

Хүний аюулгүй байдлын судалгааны төвтэй хамтран "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучуудын боловсролын хүртээмж, тэдний сурах орчин, нөхцөл байдлын талаарх судалгаа"-г хийлээ. Судалгааг хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучуудын боловсролын хүртээмж, тэдний сурах орчин, нөхцөл байдлын талаар судалгаа шинжилгээ хийж, судалгаанаас гарсан үр дүнг танилцуулах уулзалт, ярилцлагыг 2010 оны 6-12 дугаар сард зохион байгуулан хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучуудын боловсролын хүртээмж, сурах орчныг сайжруулах талаар бодлогын санал зөвлөмж боловсруулав.

“Эрдэмнэт сүлжээ” байгууллагатай хамтран “Нээлттэй сургалтын тогтолцоо” /Нээлттэй Их сургуулийг Монгол Улсад хөгжүүлэх боломж, нөхцөлийг судлах/ судалгааг нээлттэй их сургуулийг хөгжүүлэх талаар шийдвэр гаргагчид болон багш, сурган хүмүүжүүлэгчдийн мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх зорилгоор энэ оны 6-12 сард хийж дуусгаад байна. Морин хуур, уртын дууны холбоотой хамтран “Монгол ардын уртын дууны уламжлалт өв, ур чадварын судалгаа”-г хийж, монгол ардын уртын дууг хамгаалах Монгол Улс, БНХАУ-ын хамтарсан хорооны төлөвлөгөөний дагуу хээрийн шинжилгээний 10 судлаачийн бүрэлдэхүүнтэй анги БНХАУ-ын ӨМӨЗО-ы нутгаар уртын дууны судалгаа хийлээ. Судалгааны хоёр баг нийт 180 гаруй өвлөн тээгчтэй уулзаж Үзэмчин дуу, Барга дуу, Шилийн гол дуу, Ордос дуу, Гүр дуу, Алашаа хошууд дуу, Алашаа торгууд дуу, Алашаа халх дууны нийт 48 цагийн видео, 1.5 GB дуу бичлэг хийж, 20 гаруй GB фото зураг авч сан бүрдүүллээ. Монголын Үндэсний олон нийтийн радио, телевизтэй хамтран сар шинийн баярт зориулсан “Энх мэндийн хадаг” теле-концертыг зохион байгууллаа. Тус арга хэмжээнд ОХУ-ын Буриад, Халимаг, Тува, ӨМӨЗО-ны олон нийтийн телевизийн төлөөлөгчид болон уран бүтээлчид оролцсон юм.

***Яамны дотоод үйл ажиллагааны мэдээллийг он-лайн хэлбэрт шилжүүлж, дотоод мессенжер бий болгов.***

Яамны дотоод үйл ажиллагааны мэдээллийг он-лайн хэлбэрт 2010 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн шилжүүлснээр баримт бичиг, албан бичгийн төслийн хяналт,

үйл ажиллагааны явцын тайлагнал, нэгж, албан хаагчдын хоорондын мэдээ, мэдээллийг электрон хэлбэрээр түгээж байгаа нь ажилтан нарын ажлын бүтээмж дээшилж, цаг ашиглалт, мэдээлэл солилцох хурд сайжирч, бичгийн хэрэгслийн зардлыг хэмнэн эдийн засгийн үр ашиг гарах зэрэг дэвшил гарч байна.

### ***Салбарын хууль тогтоомжийн электрон мэдээллийн санг баяжуулав.***

Боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарын 1997-2010 оны улсын бүртгэлд бүртгэгдсэн нийтээр дагаж мөрдүүлэх дүрэм, журам, холбогдох төлөвлөгөө, хөтөлбөрийг интернэт хэлбэрт оруулан сан байгуулсан бөгөөд түүнийг мэдээллээр баяжуулах ажлыг тогтмол хийж байна. 2010 оны байдлаар энэ санд боловсролын салбарт мөрдөгдөх хууль-10, Ерөнхийлөгчийн зарлиг-1, Засгийн газрын тогтоол-23, сайдын тушаал-138, шинжлэх ухааны салбарын хүрээнд хууль-8, Ерөнхийлөгчийн зарлиг-2, Засгийн газрын тогтоол-13, сайдын тушаал-24, соёлын салбарын хүрээнд хууль-3, Засгийн газрын тогтоол-29, сайдын тушаал-38, Засгийн газрын албан даалгавар-1 нийт 290 бичлэг хийгдсэн байна. Тус эрх зүйн мэдээллийн үйлчилгээ үйлчлүүлэгчдэд хэрхэн хүрч ашиглагдаж байгааг мэдэх зорилгоор мэдээлэл тус бүрд зочилсон хэрэглэгчдийн хандалтын мэдээллийг автоматжуулав. Салбарын бодлогын газрын мэргэжилтнүүдээр дамжуулж уг цахим хуудасны хаяг <http://www.edu.gov.mn/>, хэрхэн ашиглах талаар интернэтээр, утсаар болон биеэр ирсэн хүмүүст тайлбарлан өгч мэдээлэл хүргэх ажлыг сурталчилж байна.

### ***Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлын тогтоол, Засгийн газрын тогтоол, хуралдааны тэмдэглэл, Ерөнхий сайдын захирамжийн хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулж биелэлтийг нэгтгэн гаргаж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт тогтмол мэдээлж ирлээ.***

2010 оны байдлаар Улсын Их Хурлын 1 тогтоолын 1 заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 3 зарлигийн 4 заалт, Монгол Улсын Ерөнхий сайдын 2 захирамжийн 2 заалт, Засгийн газрын 34 тогтоолын 71 заалт, Засгийн газрын хуралдааны 41 тэмдэглэлийн 51 заалтыг тус тус хяналтад авч хэрэгжилтийг зохион байгуулахад дэмжлэг үзүүлж, хяналт тавин ажиллалаа. Тогтоол шийдвэрийн хэрэгжилт жилийн эцсийн дүнгээр 93,4 хувьтай байна. Тогтоол, шийдвэрийн биелэлтийг хангуулах чиглэлээр яамны дотоод сүлжээгээр албан хаагчдад холбогдох тогтоол, шийдвэрийг хүргүүлэх, нэгжийн дарга нарт тухай бүр нь танилцуулах, яамны цахим хуудсанд байрлуулах арга хэмжээг тогтмол авч байлаа. Энэ онд яаманд ирсэн Ерөнхийлөгчийн зарлиг 4, Ерөнхий сайдын захирамж 20, Засгийн газрын тогтоол 75, Хуралдааны тэмдэглэл 66-г тогтоол, шийдвэрийн бүртгэлийн санд оруулж, баяжилтийг хийлээ.

### ***Албан бичиг, өргөдөл, гомдол, захидлын шийдвэрлэлтэд байнгын хяналт тавьж тайлан, мэдээг тогтоосон хугацаанд гаргаж, мэдээлж байлаа.***

Тайлангийн хугацаанд гаднын байгууллага, иргэдээс нийт 10544 албан бичиг, өргөдөл, гомдол, хүсэлт ирсний 5922 нь хариутай, 2832 нь шууд, 1790 нь өргөдөл, гомдол, хүсэлт байв. Ирсэн хариутай албан бичиг, өргөдөл, гомдол, хүсэлтийн тайланг 14 хоног, сараар гарган, мэргэжилтэн бүртэй шийдвэрлэлтийн талаарх тооцоо хийж, хяналтын картад тухай бүр тэмдэглэгээ хийж, хаалаа. Хариутай бичгийн 5654 буюу 95,4%, өргөдөл, гомдол, хүсэлтийн 1734 буюу 97.0 хувь нь шийдвэрлэгдэж, үлдсэн нь

хугацаа болоогүй судлагдаж байна. Энэ хугацаанд УИХ-ын гишүүдээс 413, Ерөнхийлөгчийн Тамгын газраас 50, Засгийн газар Хэрэг эрхлэх газраас 101, нийт 564 байгууллага, иргэний хүсэлт уламжлагдан ирсний 558 буюу 99.0 хувийг шийдвэрлэж, хариу өгсөн бөгөөд үлдсэн нь хугацаа болоогүй судлагдаж байна.

Засгийн газар Хэрэг эрхлэх газраас шийдвэрлүүлэхээр яаманд шилжүүлсэн албан бичиг, өргөдөл, гомдол, захидлыг түргэн шуурхай бүртгэн, холбогдох сайд, дарга нарт цаг алдалгүй танилцуулж, шийдвэрлэлтийн явцыг хяналтад авч, тайлан, мэдээг хугацаанд нь чанартай, үнэн зөв гарган хүргүүлэхэд гол анхаарлаа чиглүүлж ажилласны дүнд Засгийн газар, Хэрэг эрхлэх газраас яам, аймаг нийслэлийн Засаг даргын Тамгын газарт 2010 оны 1, 2, 3 дугаар улиралд ирүүлсэн захидал, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд өгсөн үнэлгээгээр “А” буюу 5.0 үнэлэгдсэн.

Яаманд иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, хүсэлтийн 24 цуврал танилцуулга, 12 тоймыг гарган сайд, дэд сайд, төрийн нарийн бичгийн дарга, нэгжийн дарга нарт танилцуулав. “Боловсрол, соёл, шинжлэх ухааны яаманд иргэдээс гаргасан өргөдөл, гомдол, санал, хүсэлт, мэдээллийг хүлээн авч шийдвэрлэх журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулан “Журам шинэчлэн батлах тухай” ТНБД-ын 2010 оны 290 дүгээр тушаалаар батлан яамны албан хаагчдад дотоод сүлжээгээр илгээж, судлуулан уг журмын хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдолд дурдагдсан асуудлын ихэнх хувийг өндөр хөгжилтэй орны магистрантур, докторантур, бакалаврт хоёр улсын болон тухайн орны Засгийн газрын гэрээ хэлэлцээр, Сургалтын төрийн сангийн зардлаар болон тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдан суралцах, дотоодын их, дээд сургууль, коллежид Сургалтын төрийн сангийн зээл, буцалтгүй тусламжид хамрагдан суралцах, боловсрол, соёл, урлагийн байгууллагын удирдах ажилтны ёс зүй, ажлын арга барилыг боловсронгуй болгох, боловсролын салбарт ажиллагсад үр дүнгийн урамшуулал олгогдохгүй байгаа, багш, сурган хүмүүжүүлэгчдийн цалин хөлсийг нэмэгдүүлэх, мэргэжил дээшлүүлэх, сурагч, оюутнуудын сургалтын төлбөрийн хэмжээг багасгах, тэтгэмж олгуулах, суралцаж төгссөн сургуулиа магадлан итгэмжлэгдсэн сургууль мөн эсэхийг тодруулах, гадаадын дунд сургуульд суралцаж байсан дүнг монголын ерөнхий боловсролын сургуулийн дүнтэй харьцуулан, түүнтэй дүйцүүлсэн тодорхойлолт гаргуулах, элсэлтийн шалгалт орон даяар явагдаж өнгөрсөнтэй холбогдон хүндэтгэх шалтгааны улмаас уг шалгалтад орж чадаагүй сурагчид аргагүй байдлаа дурдан дахин шалгалт өгөх, ажилд орох, орон сууцтай болох, орон сууцны зээлд хамрагдах, мөнгөн тусламж, эмчилгээний зардал, бүтээж туурвисан ном, хэвлэлээ олны хүртээл болгоход санхүүгийн дэмжлэг авах, олон улсын уралдаан, тэмцээнд оролцох замын зардал олгуулах зэрэг хүсэлт эзэлж байна.

Мөн иргэдээс тус яаманд гаргасан өргөдөл, гомдол, хүсэлтүүдэд хяналт-шинжилгээ хийсэн дүнгээс үзэхэд иргэдийн орон сууцны асуудлыг нь шийдвэрлэхэд зориулан мөнгөн тусламж, тэтгэмж, ажлын байраар хангуулах, сургалтын зориулалт бүхий байртай болоход хөрөнгийн дэмжлэг авах, амьдрал ахуйдаа болон эмчилгээнд зориулан их хэмжээний мөнгөн тэтгэлэг, өндөр хөгжилтэй орны магистрантур, докторантур, дотоодын их, дээд, сургууль, коллежид Сургалтын төрийн сангийн зардлаар суралцах зэрэг асуудлыг шийдвэрлэхэд хөрөнгө санхүүгийн болон хяналтын тооны хязгаараас үүдэн бэрхшээл тулгарсаар байна.

Иргэдээс биеэр ирж амаар болон утас, электрон шуудан, интернетийн холбоогоор дамжуулан ирүүлсэн санал, хүсэлтийг мэргэжилтэн бүр шуурхай хүлээн авч, хувийн бүртгэл хөтлөн, хариу өгөлтөд ажил хэрэгч хандахад зориулан тусгай бүртгэлийн дэвтрийг Төрийн захиргааны удирдлагын газраас санаачлан хэвлүүлж, албан хаагчдаар хөтлүүлж эхэлсэн бөгөөд иргэдэд цаг тухайд нь холбогдох хууль, дүрэм, журмыг үндэслэн бодитой хариу өгч, сарын эцэст баримт бичгийн стандарт, бүртгэл, хяналт хариуцсан мэргэжилтэнтэй тооцоо хийж, тэдний энэхүү үйл ажиллагааг үр дүнгийн гэрээ дүгнэхэд харгалзан үзэж байхаар журамлаад байна.

***Яамны үйл ажмллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах арга замыг тодорхойлон мөрдөж эхлэв.***

“Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлтийг яамны үйл ажиллагаанд хэрэглэх тухай” Төрийн нарийн бичгийн даргын 2010 оны 149 дүгээр тушаалаар яамны үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хангах арга замыг тодорхойлон холбогдох албан тушаалтанд тодорхой үүрэг даалгавар өгч хэрэгжилтийг зохион байгуулж ирлээ. Тухайлбал, төрийн бодлогын баримт бичиг болон нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг боловсруулахдаа холбогдох төрийн ба төрийн бус байгууллага, мэргэжлийн шинжээч, эрдэмтэн, судлаач, иргэдийн саналыг авч, үндэслэлтэй гэж үзвэл төсөлд тусгаж байх болон яамны үйл ажиллагаатай холбоотой хуулиар хориглосноос бусад мэдээллээр иргэдийг хүндрэл, чирэгдэлгүй хангах, иргэдийн санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг барагдуулах талаар хийсэн ажлын дүнг улирал тутам гарган дүгнэлт хийж яамны Нэгжийн дарга нарын зөвлөлийн хуралд илтгэж байхыг яамны газар, хэлтсийн дарга нарт үүрэг болгосны зэрэгцээ яамны эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл, тэдгээрийн хүрээнд хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, үр дүн, мөрдөж буй хууль тогтоомж, дүрэм, журам, заавар, албан хаагчдын овог, нэр, хариуцсан ажил, харилцах утас, иргэдийг хүлээн авах цагийн хуваарийг цахим хуудаст байршуулах, яамны хүний нөөцийн стратеги төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж батлуулах, яамны газар, хэлтсийн болон албан хаагчдын ажлыг дүгнэх шалгуур үзүүлэлт, аргачлалыг боловсруулан мөрдүүлэх, санхүүгийн үйл ажиллагааны өмнөх оны тайлан, тухайн жилийн төсвийн хуваарилалт, зарцуулалтын явц, дараа оны төсвийн төсөл, хууль тогтоомжоор зөвшөөрсөн үйлчилгээний хөлс, төлбөр, хураамжийн хэмжээ, түүнээс олсон орлого, ашиглалт, зарцуулалтын байдлыг хамт олон, иргэн, бусад байгууллага чөлөөтэй авах нөхцөлийг бүрдүүлэх, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь байгууллагын цахим хуудаст байршуулах замаар байгууллагын төсөв, санхүүгийн үйл ажиллагааг нээлттэй, ил тод байлгах, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан шийдвэрийг тухай бүр Хууль зүй, дотоод хэргийн яамаар хянуулан, улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлж, байгууллагын цахим хуудсаар мэдээлж байх, яамнаас гаргасан тушаал шийдвэрийг холбогдох нэгж, байгууллагад албан ёсоор хүргүүлж, хүлээн авсан эсэх талаар хариу мэдээлэл авах, бүртгэл хөтлөх үйл ажиллагааг хэвшүүлэхийг Төрийн захиргааны удирдлагын газрын даргад, боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарын төсөв, түүний гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайлан, уг тайланд хийсэн аудитын дүгнэлтийг яамны цахим хуудаст бүрэн байрлуулан мэдээлж, иргэд, иргэний нийгмийн зүгээс төсвийн зарцуулалтад хяналт тавих боломжийг хангах, улсын төсвийн болон хөтөлбөр, төслийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааг нээлттэй, ил тод, шударга, үр ашигтай байх зарчмаар зохион байгуулж, худалдан авах үйл ажиллагааны зарыг өдөр тутмын сонинд

нийтлүүлэх, түүний гүйцэтгэлийн дүн, уг үйл ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт, бусад хяналт, шалгалтын дүнг яамны цахим хуудаст байршуулан иргэн, байгууллага чөлөөтэй танилцах боломжийг бүрдүүлэхийг Санхүү, хөрөнгө оруулалтын газрын даргад тус тус даалгасан болно. Ийнхүү яамны дотоод ажлын ил тод, нээлттэй байдлыг хангах асуудлыг зохицуулсан нь үр дүнгээ өгч байна.

### **Арав. Дүгнэлт, зорилт**

Тус яамны 2010 оны зорилтууд үндсэндээ хэрэгжлээ. Яамны үйл ажиллагааны төлөвлөгөө 91,98 хувь, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний биелэлт 52.16 болж өмнөх оныхоос 15,1 хувиар өссөн, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2010 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт 90.33% болж өмнөх оныхоос 5.6 хувиар өссөн зэрэг нь үүнийг гэрчилж байна.

#### **Энэ онд:**

➤ ЕБС-д Кембрижийн стандартыг нэвтрүүлэх ажлыг эхлүүлж, тус стандарт хөтөлбөрөөр хичээллэх төрийн өмчийн анхны лаборатори “Шинэ эрин” сургуулийг байгуулж, үйл ажиллагааг нь эхлүүлсэн;

➤ Теле болон радио хичээлийг амжилттай зохион байгуулж, 180 цагийн теле хичээл, 60 цагийн радио хичээлийг онлайн хэлбэрээр явуулж, теле хичээлүүдийг [www.khicheel.mn](http://www.khicheel.mn) цахим хуудсанд байршуулан зайн сургалтыг өргөжүүлэх алхам хийж, багшийн заах арга зүйг шинэчлэх, харилцан бие биеэсээ суралцах боломж бүрдүүлсэн төдийгүй боловсролын салбарын үйл ажиллагааг эцэг эх, олон нийтэд нээлттэй болгосон;

➤ Ерөнхий боловсролын 35 сургуульд “Мэдээлэл, харилцааны технологийн төв”, 37 сургуульд “Цахим номын сан-мэдээллийн төв” байгуулсан; Ерөнхий боловсролын сургуулийн 11 хичээлийн байрыг шинээр ашиглалтад оруулж, суудлын тоог 3848-аар, 9 дотуур байрыг ашиглалтад оруулж, орны тоог 1045-аар, 29 цэцэрлэгийн барилгыг ашиглалтад оруулж, орны тоог 2628-аар, 14 соёлын төвийн барилгыг ашиглалтад оруулж, суудлын тоог 3210-аар, спорт заал 2-ыг ашиглалтад оруулж, талбайг 504 м2 нэмэгдүүлсний зэрэгцээ улсын төсвийн хөрөнгөөр нийт 201 сургууль, цэцэрлэг, соёлын төв, дотуур байр, спорт заалны барилга байгууламжийг шинэчлэн засварлаж сургалтын болон үйлчилгээний орчинг сайжруулсан, Азийн хөгжлийн банкны “Боловсролын хөгжлийн хөтөлбөр-3” төслийн санхүүжилтээр 1323.5 сая төгрөгөөр ерөнхий боловсролын сургуулийн 8 хичээлийн байрыг бүрэн засварласан;

➤ Их сургуулиудыг хотхоноор хөгжүүлэх чиглэлийг батлуулан хэрэгжүүлж эхэлсэн;

➤ Төрийн өмчийн их, дээд сургуулийн бүтцийн өөрчлөлт хийж 42 сургуулийг 16 болгож цөөлсөн;

➤ Дээд боловсролыг шинэчлэх бодлого тодорхойлсон;

➤ Өндөр хөгжилтэй оронд суралцаж буй Монгол оюутны тоог өсгөсөн;

➤ Дэлхийд данслагдсан монгол соёлын өвийг арвижуулж, “Монгол Үндэстний баяр–Наадам”, “Монгол үндэстний хөөмэйн урлаг”, “Бүргэдийн ан буюу Шувуучлахуй” гэсэн 3 өвийг Дэлхийн биет бус соёлын өвд бүртгүүлсэн;

➤ Монголын соёл, урлагийн гадаад сурталчилгааг эрчимжүүлж, Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Казахстан Улс, БНХАУ-ын Өвөр Монголын Өөртөө Засах Орон зэрэг Монголын соёлын өдрүүдийг зохион байгуулсан;

➤ Монгол Улсын шинжлэх ухаан, технологийн хөгжлийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлон батлуулж, хэрэгжүүлж эхэлсэн;

➤ Зарим яам, их сургуультай инновацийн түншлэлийн гэрээ байгуулж, салбарын тулгамдсан асуудлаар хамтарсан санхүүжилттэй инновацийн төслүүд хэрэгжүүлж эхэлсэн зэрэг манай оронд анхдагч болох томоохон арга хэмжээг хэрэгжүүлсэн буюу хүрэгжүүлж эхэлсэн байна.

Энэ бүхэн нь нэг талаас Монгол Улсын төр, засаг боловсрол, соёл, шинжлэх ухааны хөгжлийг тууштай дэмжиж байгаагийн, нөгөө талаас манай багш нар, соёл, урлагийн болон шинжлэх ухааны ажилтнуудын нөр их хичээл, зүтгэлийн үр дүн.

Манай салбарт хийсэн ажил, хүрсэн үр дүн багагүй байгаа ч, дутагдал, тулгамдсан асуудал цөөнгүй байна. Тухайлбал, боловсролын шинэчлэлийн агуулгыг нийгмийн хөгжлийн хэрэгцээ шаардлага, амьдралын эрэлтэд нийцүүлэх, багшийг чадваржуулах, бүх шатны боловсролын чанар, сургуулийн менежментийг сайжруулах нь боловсролын салбарын цаашдын үйл ажиллагааны гол агуулга байх болно. Соёл, урлагийн салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгож, үйлчилгээний хүрээ, хүртээмжийг нэмэгдүүлэх, шинжлэх ухаан, технологи, инновацийн талаар төрөөс баримтлах бодлогыг оновчтой тодорхойлон түүнийг хэрэгжүүлэхэд хүч нөөцийг төвлөрүүлэх, инновацийн үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг бий болгох, соёл, шинжлэх ухааны үйл ажиллагаанд хувийн хэвшлийн бүтээлч оролцоог нэмэгдүүлэх нь манай яамны үйл ажиллагааны тулгамдсан асуудал байсаар байна.

Энэ бүхнийг үндэслэн дараахь чиглэлээр бодитой ахиц дэвшил гаргахаар яамны нийт ажилтны 2010 оны тайлангийн хурлаас тодорхойлсон болно:

1. Боловсролын багц хууль, Соёлын болон Соёлын өвийн тухай, Инновацийн тухай хуулийг Засгийн газар, УИХ-д өргөн барьж батлуулах.

2. ЗГҮАХ-т тусгагдсан зорилтуудыг бүрэн хэрэгжүүлэх.

3. Салбарын хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэх, төслийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх.

4. Кембрижийн стандартад суурилсан ерөнхий боловсролын стандарт, хөтөлбөрийг нэвтрүүлэх ажлыг өргөжүүлэх, эрчимжүүлэх.

5. Багш бэлтгэх, чадваржуулах шинэ тогтолцоог бүрдүүлэх.

6. Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын хамран сургалтыг нэмэгдүүлэхийн зэрэгцээ сургалтын чанарыг ахиулах бодлого боловсруулж хэрэгжүүлэх.

7. Мэргэжлийн боловсролын үйл ажиллагааг ажил олгогч, нийгмийн түншүүдийн үйл ажиллагаатай бүрэн холбох.

8. Дээд боловсролын шинэчлэлийг гүнзгийрүүлэх, оюутны сургалтын төлбөрийн шинэ тогтолцоог буй болгон хэрэгжүүлэх.

9. Их сургуулийг хотхоноор хөгжүүлэх чиглэлийг хэрэгжүүлэх, хотхоны бүтээн босголтын ажлыг эхлүүлэх.

10. Багшийн хөгжлийн ордныг ашиглалтад оруулж, Үндэсний урлагийн ордныг барьж байгуулах ажлыг эхлүүлэх.

**Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам**

**ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ  
ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ  
БИЕЛЭЛТИЙН ДҮН**

№3

Агуулга	Арга Хэмжээ- ний тоо	Хэрэгжилтийн явц							Хугацаа болоогүй	Биелэлт /хувиар/
		100%	90%	70%	50%	30%	10%	0%		
Эрх зүйн орчин, төрийн үйлчилгээ	15	-	-	1	2	5	4	3	-	24.0
Боловсрол	67	10	1	19	29	3	2	-	3	63.12
Соёл, урлаг	25	1	2	5	9	6	1	1	-	50.8
Шинжлэх ухаан	21	1	2	3	7	5	2	1	-	48.1
Бусад	-	-	-	-	-	-	-	-	-	-
<b>Дүн</b>	<b>128</b>	<b>12</b>	<b>5</b>	<b>38</b>	<b>47</b>	<b>19</b>	<b>9</b>	<b>5</b>	<b>3</b>	<b>58.56</b>

**ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2010 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙГ  
ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ДҮН**

№4

Зорилт	Арга хэмжээ- ний тоо	Биелэлт /%/							Биелэл- тийн дүн /%/
		100	90	70	50	30	10	0	
Боловсрол	37	25	10	-	-	-	-	2	91.89
Соёл, урлаг	5	1	1	1	-	2	-	-	64.0
Шинжлэх ухаан	15	11	1	3	-	-	-	-	93.33
Бусад	3	3	-	-	-	-	-	-	100.0
<b>Дүн</b>	<b>60</b>	<b>40</b>	<b>12</b>	<b>4</b>	<b>-</b>	<b>2</b>	<b>-</b>	<b>2</b>	<b>90.33</b>

**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМНЫ 2010 ОНЫ  
ҮР ДҮНГИЙН ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТ /хувиар/**

№5

№	Газрын нэр	Нийт бүтээгдэхүүн	Тусгай захиалгат бүтээгдэхүүн
1	Бага, дунд боловсролын газар	90.54	72.50
2	Мэргэжлийн боловсролын газар	81.92	93.33
3	Соёл, урлагийн газар	80.64	80.0
4	Шинжлэх ухаан, технологийн газар	92.72	95.0
5	Санхүү, хөрөнгө оруулалтын газар	97.27	95.0
6	Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний газар	98.08	-
7	Гадаад хамтын ажиллагааны хэлтэс	96.76	-
8	Төрийн захиргааны удирдлагын газар	94.90	-
9	<b>Бүгд</b>	<b>91.98</b>	<b>86.88</b>

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ҮНЭЛЭХ ЭДИЙН ЗАСАГ,  
НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН БИЕЛЭЛТ

(2010 оны дүнгээр)

№	Үзүүлэлт		Өмнөх он	Тайлант он	Өөрчлөлт	Үнэлгээ		
						хувь	оноо	
1	Хамран сургалтын хувь:	Сургуулийн өмнөх боловсрол	76.7	79.8	3.1	104,04	5,20	
		Бага боловсрол	94,2	94.5	0.3	100,32	5,01	
		Суурь боловсрол	89,8	89.6	-0.2	99,78	4,99	
2	Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны хангалтын хувь		90.0	90.0	0,0	100,0	5,0	
3	Мэргэжлийн багшийн хангалтын хувь		Цэцэрлэг	89.9	93.0	2.1	103,45	5,17
			ЕБС	98,5	98.9	0.4	100,4	5,02
4	Ерөнхий боловсролын сургуулийн сурах бичгийн хангалтын хувь (ангиар)		71,0	71.9	0.9	101.27	5.06	
	Үүнээс	I анги	-	100.0	-			
		II анги	-	100.0	-			
		III анги	-	100.0	-			
		IV анги	-	69.3	-			
		V анги	-	72.6	-			
		VII анги	-	59.7	-			
		VIII анги (12 жилийн)	-	55.8	-			
		VIII анги (11 жилийн)	-	59.2	-			
		IX анги	-	57.8	-			
		X анги	-	58.0	-			
XI анги	-	58.9	-					
5	Нэг компьютерт ногдох хүүхдийн тоо		25,2	23.7	1.5	106.33	5.32	
6	Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын хамралтын тоо*		ЕБС	-	-	-		
			цэцэрлэг	-	-	-		
7	Ерөнхий боловсролын түвшин тогтоох шалгалтын онооны дундаж (дунд боловсролын сургуульд)*		-	-	-	-	-	
8	Дээд боловсролын сургуульд элсэгчдийн ерөнхий шалгалтын онооны дундаж		494,35	496.18	1.83	100,37	5.03	

9	Мэргэжлийн боловсролын сургууль төгсгөгчдийн ажил эрхлэлтийн хувь (төгссөнөөс хойш 6 сарын дотор)		55.6	51.8			
10	Тухайн жилд соёл, урлагийн үйлчилгээг хүртсэн үйлчлүүлэгчдийн тоо /сая/		8.6				
11	Театр, чуулга, соёлын төв, кино театруудад шинээр болон сэргээн тавьсан бүтээлийн тоо (урлагийн төрөл, хэлбэрээр)		161				
	Үүнээс:	Жүжиг	37				
		Концерт	93				
		Циркийн хөтөлбөр	5				
		Дуурь	3				
		Балет	2				
	бусад	21					
12	Олон улсын урлагийн их наадам, уралдаан, үзэсгэлэн, яармагт оролцож онцгой амжилт гаргасан уран бүтээлчдийн тоо		16	15	-1	93.75	4.67
13	Улсын санд худалдан авсан ном, хөгжим, дүрслэх урлагийн шилдэг бүтээлийн тоо		73				
14	Үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлсэн эрдэм шинжилгээний ажлын үр дүн (бүтээлийн тоо, эдийн засгийн өгөөж)		-				
15	Тухайн жилд шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагаанд зарцуулсан хөрөнгө оруулалт (мян.төг)		1504.8				
16	Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэл (хувь)		93.0%				
17	Төсвийн ерөнхийлөн захирагчийн тухайн оны төсвийн багцын зарцуулалтын гүйцэтгэл (хувь)		97.4				
18	Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн		Урсгал өр (сая төг.)	2189.0			
			Авлага (сая төг)	2418.0			
	Дундаж оноо						

Тайлбар: Энд \* (цэцэг) тавьсан 3 үзүүлэлт салбарын статистикийн үзүүлэлтээр гардаггүй учир бөглөх боломжгүй байна.

**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ  
ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН**

(2010 оны үйл ажиллагааны үр дүн)

№	Үзүүлэлт		Үр дүнгийн үнэлгээ	
			хувь	оноо
1	Бодлогын зорилтын хэрэгжилтийн үр дүнгийн үнэлгээ	1.Үндэсний хөгжлийн цогц бодлогын хэрэгжилт	60,0	3.0
		2.Хууль тогтоомжийн хэрэгжилт	93,4	4.67
		3.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	58.56	2.93
		4.Үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилт	<b>91,0</b>	
Үнэлгээний дундаж оноо				
2	Бодлогын зорилтын хэрэгжилтийн зохицуулалтын үнэлгээ	1.Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт	99.33	4.97
		2.Улсын төсөв, зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төслүүдийн хэрэгжилт		
		3.Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилт		
Үнэлгээний дундаж оноо				
3	Байгууллагын үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээ	1.Төсвийн ерөнхийлөн захирагчаас ерөнхий менежертэй байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлт	91.98	4.6
		2.Байгууллагаас дэвшүүлсэн зорилтууд нь үйл ажиллагааны хэтийн бодлого, төлөвлөгөөтэй уялдсан байдлын үнэлгээ	100.0	5.0
Үнэлгээний дундаж оноо			<b>4.53</b>	
4	Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлын үнэлгээ	1.Үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал	100.0	5.0
		2. Хүний нөөцийн бодлогын ил тод байдал	100.0	5.0
		3.Төсөв, санхүүгийн ил тод байдал	100.0	5.0
		4.Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдал	100.0	5.0
Үнэлгээний дундаж оноо				
5	Үйл ажиллагааны үр дагаврын үнэлгээ	1.Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээ	100.0	5.0
		2.Хэрэглэгчийн үнэлгээ	100.0	5.0
Үнэлгээний дундаж оноо				
Ерөнхий үнэлгээ				